

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-139-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Аэродромын гэрчилгээжүүлэлт, үйл ажиллагаа (Шинэчлэгдэж байгаа) /74 хуудас/2017оны NZ amend. 13</p>	<p align="center">АЭРОДРОМЫН ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) / 21 хуудас (үндсэн дүрэм-64 хуудастай байсан)/ 1996 оны NZ amend. 1</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>139.1. Зорилго Энэ бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) аэродромын гэрчилгээжүүлэлт болон үйл ажиллагааны; (2) гэрчилгээжсэн аэродромын аюулгүйн хамгаалалтын; (3) [хүчингүй] (4) UNICOM болон AWIB үйлчилгээний.</p>	<p>139.1. Зорилго, үйлчлэх хүрээ (а) Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэний нисэхийн зориулалтаар үйл ажиллагаа явуулах аэродромыг гэрчилгээжүүлэх, түүний аюулгүй ажиллагаа, хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагааны журмыг тогтооход оршино. (б) Онцгой үүргийн, яаралтай тусламжийн, онцгой нөхцөл байдал үүссэн болон ерөнхий зориулалтын G ангиллын агаарын зайд нислэг үйлдэх, агаараас талбай сонгож буух нөхцөлүүд нь энэ дүрмээр зохицуулагдахгүй. (в) Энэ дүрмийн дагуу олгосон хүчин төгөлдөр гэрчилгээ, түр зөвшөөрөлгүйгээр аэродромын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.</p>	<p>-Amend.2-оор хасагдаж шинээр орж ирсэн. -Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон</p>
<p>139.3. Нэр томьёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.</p>	<p>139.3. Тодорхойлолт</p>	<p>-Нэр томьёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p>139.5. Аэродромын гэрчилгээ эзэмших шаардлага (аа) Энэ зүйл нь дараах аэродромд хамаарна: (1) тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэх онгоцонд үйлчлэх дараах аэродромд: (i) тухайн аэродромд буулт үйлдэхийн өмнөх нисэх онгоцны хөөрөлтийн цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром; эсхүл (ii) тухайн аэродромоос хөөрөлт үйлдсэний дараах нисэх онгоцны буултын цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром; (2) зорчигч тээврийн тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцонд үйлчлэх аэродромд. (а) Хууль болон энэ Бүлгийн дагуу Даргын олгосон аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний (цаашид “Аэродромын гэрчилгээ” гэх) эрхийн хүрээнд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь энэ зүйлд хамаарах аэродромын үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй. (b) Аэродромын гэрчилгээ эзэмшихийг шаарддаггүй аэродромын</p>		<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн</p>

<p>үйл ажиллагаа эрхлэгч нь аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж болно.</p>		
<p>139.5А. Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших шаардлага (a) Энэ зүйл нь, 139.23-ын дагуу хязгаарлагдмал аэродром гэж Дарга тогтоосон аэродромд хамаарна. (b) Хууль болон энэ Бүлгийн дагуу Даргын олгосон хязгаарлагдмал аэродромын гэрчилгээний эрхийн хүрээнд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь энэ зүйлд хамаарах хязгаарлагдмал аэродромын үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй. (c) Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшихийг шаарддаггүй аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргаж болно.</p>		<p>-Amend.10-аар нэмэгдсэн</p>
<p>139.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах (a) Аэродромын гэрчилгээ эсхүл хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1)энэ Дүрэмд заасны дагуу Даргад хүсэлт гаргах; (2)зохих төлбөрийг төлөх. (b) Хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргах үүрэгтэй: (1)гүйцэд бөглөсөн хүсэлтийн маягт; (2)139.77-д шаардсан аэродромын гэрчилгээ эзэмшигчийн, эсхүл 139.417-д шаардсан хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын аль хамааралтайг; (3)эрх бүхий геодезийн ажилтны баталгаажуулсан, тухайн аэродром болон түүний байгууламжийн дэвсгэр зураг; (4)тухайн газрыг аэродромын зорилгоор ашиглах хууль ёсны эрхтэй болохыг нотлох баримт. (c) Хүсэлтийг гэрчилгээ шаардлагатай хугацаанаас 90-ээс доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлсэн байх үүрэгтэй.</p>	<p>139.53. Өргөдөл гаргах (a) Аэродромын үйл ажиллагаа эрхлэхээр өргөдөл гаргагч /цаашид Өргөдөл гаргагч гэх/ нь үйл ажиллагаа эхлэхээр төлөвлөсөн хугацаанаас 60–аас доошгүй хоногийн өмнө ИНЕГ-139/01 маягтын дагуу өргөдөл гаргаж, албан бичиг, энэ дүрмийн В бүлэгт заасан аэродромын заавар, Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд оруулах өгөгдлийн жагсаалт болон дараах баримт бичгийн хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ: 1/аэродромын байршил сонгосон тухай баримт, нисэх буудлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодорхой масштаб бүхий зураг; 2/тухайн аэродромын газрыг эзэмшигчийн талаарх мэдээлэл; 3/аэродромыг ашиглах зорилго, агаарын хөлөг, нислэгийн урьдчилсан хуваарийн тухай танилцуулга; 4/гэрчилгээний хураамж төлсөн баримт.</p>	<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн</p>
<p>139.9. Гэрчилгээ олгох (a) Дарга, 139.7-гийн дагуу хүсэлт гаргасан этгээдэд энэ Дүрмийн дагуу аэродромын гэрчилгээ, эсхүл хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ олгож болно. (b) Энэ Дүрэмд, тогтоосон шаардлага гэж В, эсхүл G Бүлэгт заасан шаардлагын аль хамааралтайг ойлгоно. (c) Дарга, хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ олгохдоо, 139.21-д шаардсан нисэхийн судалгаагаар тогтоогдсон эрсдэлтэй холбоотой, тухайн аэродромын үйл ажиллагаа</p>	<p>139.5. Гэрчилгээжүүлэх бүрэн эрх (a) Аэродромын гэрчилгээ олгох, хугацааг сунгах, гэрчилгээ олгохоос татгалзах, гэрчилгээг хүчингүй болгох, хураах эрхийг ИНЕГ-ын дарга хэрэгжүүлэх бөгөөд ИНЕГ-ын дарга энэ эрхээ Иргэний нисэхийн тухай хуульд заасны дагуу эрх, үүргээ бусад албан тушаалтанд гэрээний дагуу тодорхой хугацаанд шилжүүлж болно.</p>	<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн</p>

<p>эрхлэгчийн мөрдөх шаардлага, эсхүл журмыг тогтоож болно.</p>	<p>(б) Шинээр Аэродромын гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь гэрчилгээжүүлэлттэй холбоотой аливаа асуудлыг ИНЕГ-ын даргад бичгээр ирүүлнэ.</p>	
<p>139.11. Гэрчилгээний хугацаа (а) Дарга, аэродромын гэрчилгээ, эсхүл хязгаарлагдмал аэродромын гэрчилгээний хугацааг, гэрчилгээ олгосон өдрөөс хойш 5 жилээс дээш хугацаагаар тогтоохгүй.</p>	<p>139.61. Гэрчилгээний хүчинтэй хугацаа (а) Аэродромын гэрчилгээг 36 сар хүртэл хугацаатай олгож, сунгалт хийх бөгөөд аэродромын түр зөвшөөрлийг 6 сар хүртэл хугацаатай олгож, нэг удаа сунгалт хийж болно. (б) Аэродромын гэрчилгээ, эсхүл түр зөвшөөрөл нь гэрчилгээ эзэмшигч түүнээс татгалзсан, тэдгээрийн хугацаа дууссан, аэродромын үйл ажиллагааг ИНЕГ-ын эрх бүхий этгээд түр болон бүрмөсөн зогсоосон, гэрчилгээг хураан авснаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр байна</p>	<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн</p>
<p>139.13. Гэрчилгээ сунгах (а) Тухайн гэрчилгээний эрхийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг хүсэж байгаа аэродромын гэрчилгээ эсхүл хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч нь, гэрчилгээний хугацаа дуусах өдрөөс өмнө 139.7-гийн дагуу шинээр гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах үүрэгтэй. (б) 139.7(с)-д заасныг үл харгалзан, гэрчилгээ сунгуулах хүсэлтийг гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлсэн байх үүрэгтэй.</p>	<p>139.53 (б) Гэрчилгээ эзэмшигч нь аэродромын гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлтээ ИНЕГ-139\01 маягтын дагуу гаргаж, хяналтын үзлэгийн хуудас, аэродромын шинэчлэгдсэн зааврын хамт 30 хоногийн өмнө ИНЕГ-ын даргад ирүүлнэ. (в) Түр хугацаагаар аэродромын үйл ажиллагаа эрхлэхээр өргөдөл гаргагч нь үйл ажиллагаагаа эхлэхээр төлөвлөсөн хугацаанаас 14 хоногийн өмнө ИНЕГ-139/01 маягтын дагуу өргөдөл гаргаж, албан тоот, дараах бичиг баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ : 1/ аэродромын байршил сонгосон тухай баримт, байршлыг үзүүлсэн тодорхой масштаб бүхий зураг; 2/ тухайн аэродромын газрыг эзэмшигчийн талаарх мэдээлэл; 3/ аэродромыг ашиглах зорилго, агаарын хөлөг, нислэгийн урьдчилсан хуваарийн тухай танилцуулга; түр зөвшөөрлийн хураамж төлсөн баримт.</p>	<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн</p>
<p>139.15. Нөөц</p>		
<p>139.17. Дүрмийн шаардлагаас хазайх (а) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь, агаараар тээвэрлэгдэж байгаа хүн, эсхүл өмч хөрөнгийг авран хамгаалах яаралтай ажиллагаа шаардсан хэрэв онцгой нөхцөл үүссэн бол С, эсхүл D Бүлгийн шаардлагаас хазайж болно. (аа) Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч нь, агаараар тээвэрлэгдэж байгаа хүн, эсхүл өмч хөрөнгийг авран хамгаалах яаралтай ажиллагаа шаардсан, хэрэв онцгой нөхцөл үүссэн бол G, эсхүл H Бүлгийн шаардлагаас</p>	<p>139.69. Дүрмийн шаардлагаас гажих (а) Осол, онцгой нөхцөл байдлын үед хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах зайлшгүй бөгөөд яаралтай шалтгаанаар гэрчилгээ эзэмшигч нь дүрмийн шаардлагаас гажиж болно.</p>	

<p>хазайж болно.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу C, эсхүл D Бүлгийн, эсхүл энэ зүйлийн (aa)-ийн дагуу G, эсхүл H Бүлгийн шаардлагаас хазайсан гэрчилгээ эзэмшигч нь онцгой нөхцөл үүссэнээс хойш 14 хоногийн дотор, Даргад тайланг бичгээр цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.</p> <p>(c) Энэ зүйлийн (b)-д шаардсан тайланд, дүрмийн шаардлагаас хазайсан үйл явдлын шинж чанар, цар хүрээ болон үргэлжилсэн хугацааг тодорхой заах үүрэгтэй.</p>	<p>(б)Гэрчилгээ эзэмшигч нь дүрмийн шаардлагаас гажсан тухай тайлбарыг хэрэг явдал болсноос хойш 14 хоногийн дотор ИНЕГ-ын даргад бичгээр ирүүлнэ.</p>	<p>-Amend.10-аар өөрчлөгдсөн</p>
<p>139.19. Гэрчилгээжээгүй аэродромд тавих шаардлага Аэродромын гэрчилгээ, эсхүл хязгаарлагдмал аэродромын гэрчилгээний эрхийн хүрээнээс гадуур аэродромын үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь энэ Дүрмийн I Бүлгийн шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.</p>		<p>-Amend.10-аар нэмэгдсэн</p>
<p>AA Бүлэг-Хязгаарлагдмал аэродромыг тодорхойлох</p>		
<p>139.21. Нисэхийн судалгаа</p> <p>(a) Дарга аэродромын гэрчилгээ, эсхүл хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшдэггүй аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийг нисэхийн судалгаа хийхийг дараах тохиолдолд шаардаж болно, хэрэв:</p> <p>(1)Дарга, нөлөө бүхий өөрчлөлт гарсан, эсхүл тухайн аэродромын ашиглалт, эсхүл үйл ажиллагаанд нөлөөлж болох бодит шалтгаан байна гэж үзвэл; эсхүл</p> <p>(2)аливаа этгээд, нисэхийн аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг харуулсан томоохон хүндрэлтэй асуудлыг дэвшүүлсэн бол; эсхүл</p> <p>(3)Дарга, дараах асуудалтай холбоотойгоор, 157.11(a)(2)-ын дагуу нөхцөл заасан шийдвэр гаргасан бол:</p> <p>(i) энэ зүйлийн (a)(1)-д заасан өөрчлөлт; эсхүл</p> <p>(ii) энэ зүйлийн (a)(2)-т заасан хүндрэлтэй асуудал; эсхүл</p> <p>(4) Дарга, дараах асуудалтай холбоотойгоор, 157.11(a)(3)-ын дагуу хүлээн авах боломжгүй гэсэн шийдвэр гаргасан бол:</p> <p>(i) энэ зүйлийн (a)(1)-д заасан өөрчлөлт; эсхүл</p> <p>(ii) энэ зүйлийн (a)(2)-т заасан хүндрэлтэй асуудал.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)(1)-д заасан нөлөө бүхий өөрчлөлтөд дараах өөрчлөлт багтана:</p> <p>(1) дараах нисэх онгоцоор тогтмол арилжааны нислэгийн үйл ажиллагааг эхлүүлсэн, эсхүл эхлүүлэхээр төлөвлөсөн:</p> <p>(i) 9-өөс дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай; эсхүл</p> <p>(ii) төлбөрт ачаалал нь 3410 кг, эсхүл түүнээс бага, MCTOW нь 5700 кг-аас дээш жинтэй; эсхүл</p> <p>(iii) SEIFR-ээр зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх;</p>		<p>-Amend.10-аар нэмэгдсэн</p>

эсхүл

- (2) аэродромын агаарын хөлгийн хөдөлгөөний огцом өсөлт; эсхүл
- (3) тухайн аэродромд ашиглаж байгаа агаарын хөлгийн маяг, эсхүл агаарын хөлгийн гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны төрлийн нөлөө бүхий өөрчлөлт; эсхүл
- (4) тухайн аэродромын бодит үзүүлэлтийн нөлөө бүхий өөрчлөлт; эсхүл
- (5) тухайн аэродром, эсхүл түүний ойролцоох осол, эсхүл зөрчлийн огцом өсөлт; эсхүл

(6) тухайн аэродром дээрх агаарын хөлгийн хөдөлгөөний жилийн төлөв нь үргэлжилсэн 3 жилийн хугацаанд дараах хэмжээнээс хэтэрсэн бол:

- (i) 8000, эсхүл түүнээс олон VFR болон IFR-ийн нийт хөдөлгөөн; эсхүл
- (ii) 1500, эсхүл түүнээс олон IFR-ийн хөдөлгөөн; эсхүл
- (iii) 12 000, эсхүл түүнээс олон VFR болон IFR-ийн нийт хөдөлгөөн, үүний 1800, эсхүл түүнээс олон хөдөлгөөн нь IFR-ийн эсхүл
- (iv) 3000, эсхүл түүнээс олон IFR-ийн хөдөлгөөн; эсхүл
- (v) 20 000, эсхүл түүнээс олон VFR болон IFR-ийн нийт хөдөлгөөн.

(c) Хэрэв Дарга нисэхийн судалгаа хийхийг шаардсан бол, тухайн хүсэлт нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) бичгээр үйлдсэн байх;
- (2) тухайн хүсэлтийн шалтгааныг заасан байх;
- (3) шаардлагатай нисэхийн судалгааны ажлын хамрах хүрээг заасан байх;
- (4) тухайн нисэхийн судалгааг хийж дуусах огноог заасан байх.

(d) Даргаас нисэхийн судалгаа хийх шаардлага хүлээж авсан этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) Даргын шаардлагатай гэж үзсэн этгээд, салбарын төлөөлөгч, төлөөллийн бүлэг болон байгууллагатай зөвлөлдөх;
- (2) нисэхийн судалгаагаар дараах хүчин зүйлийг тогтоох:
 - (i) тухайн аэродромыг агаарын хөлгөөр аюулгүй, үр дүнтэй ашиглах болон газарт байгаа хүн, өмч хөрөнгийн аюулгүй байдалд тухайн аэродромын төлөвлөлт, эсхүл ашиглалтын үзүүлэх нөлөө;
 - (ii) эрсдэлийг бууруулах одоогийн болон төлөвлөж байгаа арга хэмжээ;
- (3) тухайн нисэхийн судалгааг хүсэлтэд заасан хугацаа

-Amend.10-аар
нэмэгдсэн

<p>дуусахаас өмнө Даргад хүргүүлэх.</p> <p>(e) Хэрэв Дарга, тухайн аэродромын үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлийг таньж тогтоох болон үнэлгээ хийхэд шаардагдах хангалттай мэдээлэл нисэхийн судалгаанд тусгагдаагүй байна гэж үзвэл тухайн этгээдээс нэмэлт мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.</p> <p>(f) Нэмэлт мэдээлэл ирүүлэх шаардлагатай этгээд нь Даргад шаардлагатай мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй.</p>		
<p>139.23. Хязгаарлагдмал аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийг тодорхойлох</p> <p>(a) Дарга, 139.21(d)(3)-ын дагуу ирүүлсэн нисэхийн судалгааг хүлээн авсны дараа, нисэхийн аюулгүй байдалд учрах эрсдэлийн түвшинд энэ зүйлийн (b)-ийн дагуу үнэлгээ хийж, сайтар судлан, тухайн аэродром нь хязгаарлагдмал аэродромын гэрчилгээний эрхийн хүрээнд ажиллах ёстой гэж үзвэл, аэродромыг хязгаарлагдмал аэродром гэж тогтоосон шийдвэр гаргах үүрэгтэй.</p> <p>(b) Шийдвэр гаргахын өмнө Дарга дараах үүрэгтэй:</p> <p>(1) дараах мэдээлэлд анхаарч, тухайн аэродромын үйл ажиллагааны нисэхийн аюулгүй байдалд учрах эрсдэлийг үнэлэх аюулгүй байдлын дүгнэлт гаргах:</p> <p>(i) эрсдэлийг бууруулах одоогийн болон төлөвлөж байгаа бүх арга хэмжээг багтаасан, 139.21-ийн дагуу хийсэн нисэхийн судалгаа;</p> <p>(ii) тухайн аэродромд холбоотой тогтоогдсон бүх эрсдэл;</p> <p>(iii) 139.21 (b)-д заасан асуудал;</p> <p>(iv) бусад холбогдох мэдээлэл.</p> <p>(2) дараах зорилгоор тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй зөвлөлдөх:</p> <p>(i) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нисэхийн аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг бууруулж, эсхүл арилгаж чадах эсэхийг тогтоох;</p> <p>(ii) энэ хэсгийн (2)(i)-ийн дагуу тогтоосон арга хэмжээг авсан тохиолдолд, нисэхийн аюулгүй байдалд учрах эрсдэлийг шийдвэр гаргах шаардлагагүй түвшинд хүртэл бууруулж чадах эсэхийг тогтоох;</p> <p>(3) хэрэв шийдвэр гаргах шаардлагатай бол Дарга тохиромжтой гэж үзсэн, агаарын тээврийн салбарын болон бусад талуудтай зөвлөлдөх.</p> <p>(c) Энэ зүйлийн (b)(1)(i)-ийн зорилгоор хэрэв Дарга тохиромжтой гэж үзвэл, 139.21-д шаардсан нисэхийн судалгааны оронд, ИНД-157-гийн дагуу бэлтгэсэн нисэхийн судалгааг ашиглаж болно.</p>		<p>-Amend.10-аар нэмэгдсэн</p>
<p>139.25. Шийдвэрийг мэдэгдэх</p>		

<p>Дарга шийдвэр гаргасны дараа, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид дараах мэдээллийг бичгээр цаг алдалгүй мэдэгдэх үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> (1) тухайн шийдвэр; (2) тухайн шийдвэрийн хүчинтэй болох огноо; (3) тухайн шийдвэрийг гаргасан үндэслэл; (4) Хуулийн дагуу гомдол гаргах аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн эрх. 		<p>-Amend.10-аар нэмэгдсэн</p>
<p>139.27. Шийдвэр хүчинтэй болох Шийдвэр нь Даргын заасан өдрөөс эхлэн хүчинтэй болно.</p>		
<p>139.29. Шийдвэрийг цуцлах</p> <p>(a) Хэрэв аэродромын үйл ажиллагаа эрхлэгч хүсэлт гаргасан ба Дарга 139.23(a)-д заасан шийдвэр гаргахад баримталсан шалгуур үзүүлэлт нь цаашид шаардлага хангахгүй болсон бөгөөд аэродром нь цаашид хязгаарлагдмал аэродромын гэрчилгээний эрхийн хүрээнд ажиллах шаардлагагүй гэж үзвэл, Дарга тухайн аэродромын хувьд гаргасан шийдвэрээ цуцалж болно.</p> <p>(b) Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь, тухайн шийдвэрийг гаргахад 139.23(a)-д заасан шалгуур үзүүлэлт хангалтгүй бөгөөд тухайн аэродром нь цаашид хязгаарлагдмал аэродромын гэрчилгээний эрхийн хүрээнд ажиллах шаардлагагүй гэдгийг Даргад нотлох үүрэгтэй.</p> <p>(c) Цуцалсан шийдвэр нь Даргын заасан өдрөөс эхлэн хүчинтэй болно.</p>		<p>-Amend.10-аар нэмэгдсэн</p>
<p>В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага</p>	<p>Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ</p>	
<p>139.51. Аэродромын төлөвлөлтийн шаардлага</p> <p>(a) Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн аэродромын бодит үзүүлэлт, саадыг хязгаарлах гадаргуу, саад болон хориотой бүсийг тэмдэглэх навигацийн ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ болон тухайн аэродромын төхөөрөмж, байгууламж нь дараах шаардлагад нийцэж байгааг бататгах үүрэгтэй:</p> <ol style="list-style-type: none"> (1) тухайн аэродромын үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа агаарын хөлгийн үзүүлэлт; (2) тухайн ХБЗ зориулан тогтоосон хамгийн бага цаг уурын минима; (3) тухайн ХБЗ-ны агаарын хөлгийн үйл ажиллагаанд зориулан тогтоосон гадна орчны гэрлийн нөхцөл. <p>(b) Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч, ХБЗ-ны төгсгөлийн аюулгүйн зурвас (RESA) нь аэродромын ХБЗ-ны төгсгөлд тогтоосон Хавсралт А.1-д заасан бодит үзүүлэлттэй нийцэж байгааг дараах тохиолдолд бататгах үүрэгтэй, хэрэв:</p>	<p>139.7. Гэрчилгээжүүлэлтийн ангилал</p> <p>(a) Үйлдвэрлэгчээс олгосон гэрчилгээнд заасан, 9–өөс дээш суудалтай агаарын хөлгөөр зорчигч тээврийн, тогтмол, шөнийн, сургалтын, шалгалтын нислэг үйлдэх аэродром нь энэ дүрмийн дагуу гэрчилгээжсэн байна.</p> <p>(б) Орон нутгийн, улирлын чанартай үйл ажиллагаа явуулах аэродром, ерөнхий зориулалтын нисэхийн 180 хүртэлх хоногийн хугацаатай нислэгт аэродром ашиглах этгээд нь энэ дүрмийн заалтын дагуу түр зөвшөөрөл авч, бүртгүүлнэ.</p> <p>(в) Иргэний нисэхэд ашиглаж буй аэродромыг нислэгийн тоо, давтамж, нисэх буудлын дэд бүтцийн нөхцөлөөр нь дараах байдлаар ангилна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ I ангилал: Олон улсын хуваарьт нислэг үйлдэх аэродром; 2/ II ангилал: Бүс нутгийн хэмжээний хуваарьт нислэг 	<p>-Amend.10-аар өөрчлөгдсөн</p>

- (1) тухайн ХБЗ-ыг Монгол Улсаас эхлэлтэй, эсхүл төгсгөлтэй тогтмол олон улсын нислэгт ашигладаг бол; эсхүл
- (2) 2010 оны 06 сарын 22-ноос хойш аэродромын гэрчилгээг анх удаа олгосон бөгөөд тухайн ХБЗ-ыг, 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоц тогтмол агаарын тээврийн үйлчилгээнд ашигладаг бол; эсхүл
- (3) тухайн ХБЗ нь 2010 оны 06 сарын 22-ноос хойш ашиглалтад орсон бөгөөд, 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоц, тогтмол агаарын тээврийн үйлчилгээнд ашигладаг бол; эсхүл
- (4) тухайн ХБЗ-ыг 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоц тогтмол агаарын тээврийн үйлчилгээнд ашигладаг бөгөөд:
- (i) буултын боломжит зай (LDA) эсхүл ХБЗ-ны талбайн уртыг 2010 оны 06 сарын 22-ноос өмнө тухайн ХБЗ-д зориулан хэвлэн нийтэлсэн зай, эсхүл уртаас 15 м-ээс их зайд, эсхүл түүнээс их хэмжээгээр уртасгасан бол; эсхүл
- (ii) тухайн ХБЗ-ыг сайжруулж, 2010 оны 06 сарын 22-ноос хойш хэрэглэлийн нислэгт ашиглахаар категори ахиулсан бол.
- (c) Тухайн аэродромд тогтоосон RESA нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.
- (d) Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн аэродромд тогтоосон бодит үзүүлэлт, саадыг хязгаарлах гадаргуу, ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ, төхөөрөмж болон байгууламж нь дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:
- (1) дараах шаардлагад нийцсэн байх:
- (i) Хавсралт С;
- (ii) Хавсралт D;
- (iii) Хавсралт E-ийн E.1, E.2 болон E.3;
- (iv) Хавсралт E-ийн E.4-ийг 2020 оны 7 сарын 30-наас хойш;
- (v) Хавсралт F;
- (vi) Хавсралт G;
- (vii) Хавсралт H-ийг 2020 оны 7 сарын 30-наас хойш;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх.
- (e) Энэ зүйлийн (d) нь дараах нэг, эсхүл хэд хэдэн нисэх онгоц ашигладаг аэродромын зөвхөн тухайн хэсэгт хамаарна:
- (1) тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа бөгөөд:
- (i) тухайн аэродромд буулт үйлдэхийн өмнөх нисэх онгоцны хөөрөлтийн цэг нь Монгол Улсын нутаг

үйлдэх, дэд бүтэц сайтай аэродром;

3/ III ангилал: Орон нутгийн чанартай хуваарьт болон захиалгат нислэг үйлдэх аэродром, бэлтгэл аэродромууд;

4/ IV ангилал: Орон нутгийн, улирлын чанартай нислэг үйлдэх аэродром;

5/ V ангилал: Ерөнхий зориулалтын нисэхэд зориулагдсан нислэгийн зурвас, талбай.

(г) I; II; III ангиллын аэродромууд энэ дүрмийн шаардлагын дагуу үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ, IV ангиллын аэродром түр зөвшөөрлийг тус тус авч, бүртгүүлнэ. V ангиллын нислэгийн зурвасны хувьд энэ дүрмийн шаардлагаар гэрчилгээ, түр зөвшөөрөл авахгүй бөгөөд тээвэрлэгч (ашиглагч) нь аюулгүй ажиллагаагаа бүрэн хариуцаж нислэг үйлдсэн тухайгаа болон талбайн солбилцол, өгөгдлийн талаарх мэдээллийг ИНЕГ-т ирүүлнэ.

(д) Аэродромын ангиллаас хамаарч зайлшгүй хийгдэх төлөвлөгөөт үзлэг шалгалт I ангиллын хувьд жилд 2 удаа, II ангиллын хувьд жилд 1 удаа, III ангиллын хувьд 2 жилд 1 удаа тус тус хийгдэнэ. IV ангиллын аэродромын хувьд түр зөвшөөрөл олгохоос өмнө үзлэг шалгалт хийнэ.

139.9. Гэрчилгээжүүлэх шаардлага

(а) Гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаагаа энэ дүрэм болон нисэхийн аюулгүй ажиллагааны шаардлагад нийцүүлэн явуулна.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн шаардлагыг биелүүлэхдээ ИНЕГ-аас гаргасан холбогдох зөвлөмжийн цуврал, журмуудыг мөрдлөг болгон ажиллана.

(в) Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэний агаарын хөлгийн нислэгт ашиглах аэродром нь ИНЕГ-аас гэрчилгээжсэн, эсхүл зөвшөөрөл авсан байна.

(г) Түр зөвшөөрөлтэй аэродромын үйл ажиллагаа тогтмолжиж, хуваарьт болон захиалгат нислэг үйлдэх нөхцөл бүрдсэн үед ИНЕГ-аас энэ дүрмийн дагуу Аэродромын гэрчилгээ авахаар хүсэлт гаргаж болно.

Гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлага

-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн

дэвсгэрийн гадна оршдог аэродром бол; эсхүл
(ii) тухайн аэродромоос хөөрөлт үйлдсэний дараах, нисэх онгоцны буултын цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром бол;
(2), зорчигч тээврийн тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай.

	Шаардлага	Аэродромын ангилал			
			I	II	V
	Гэрчилгээний хугацаа (сараар)	6	4	4	
	139.103–т заасан аэродромын өгөгдлүүд, зураг, бусад мэдээлэл				
	Албан тушаалтан, ажилтны нэрс, тасны дугаар, и-мэйл хаяг, үүрэг хариуцлагыг харуулсан бүтэц зохион байгуулалтын бүдүүвч				
	Ажилтнуудын сургалтын хөтөлбөр				
	Газар эзэмших, ашиглах талаар тухайн орон нутгийн засаг захиргааны зөвшөөрөл				
	Онцгой байдлын үе ажиллах төлөвлөгөө				
	Авран хамгаалах, гал унтраах хөтөлбөр, тоног төхөөрөмж, хүн хүчний мэдээлэл, дүрмийн аардлагаас чөлөөлсөн мэдээлэл				
	Перроны удирдлага зохицуулалтын журам				
	Аэродром болон түүний орчинд шувуу, зэрлэг амьтдын аюулаас сэргийлэх хөтөлбөр				
0	Аэродромд үзлэг хийх болон бэлэн байдлын тухай мэдээллийн журам				
1	Аэродромын ойртолтын болон хамгаалагдсан бүсэд үйл ажиллагаа явуулах журам				
	Нисэх буудлын байгаль орчныг хамгаалах хөтөлбөр, нарийвчилсан үнэлгээ				
3	А аэродром ашиглалтын заавар				
4	Аэродромын үйл ажиллагааны чанарын дотоод хяналтын журам				

5	Аюулгүй байдлын үзлэг хяналтын хөтөлбөр				
6	Нислэгийн талбайд барилгын ажил хийх журам				
7	Нислэгийн талба дотор болон түүний гадна навигацйн тоноглолыг хамгаалах журам				
8	Газрын үйлчилгээ үзүүлэх журам				
9	Аэродромын аюулгүйн бүс тогтоосон тухай орон нутгийн Засаг даргын захирамж				

Аэродромын гэрчилгээ болон түр зөвшөөрөл авахаар өрөгдөл гаргагч нь дээрх хүснэгтэд “х”-ээр тэмдэглэгдсэн шаардлагуудыг аэродромын заавартаа тусгасан байна.

- 139.51. Ерөнхий шаардлага
- (а) Гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн В Бүлэгт заасан Аэродромын зааврыг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөнө.
- (б) Аэродромын гэрчилгээ, түр зөвшөөрөл шинээр авах болон хугацаа сунгуулахаар өргөдөл гаргагч нь Аэродромын зааврыг ИНЕГ-аар хянуулж, зөвшөөрүүлсэн байна.

139.53. Аэродромын хязгаарлалт
 Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, хэрэв аэродром дээрх агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд зайлшгүй шаардлагатай бол, тухайн аэродромын төлөвлөлт, эсхүл байгууламж, эсхүл үзүүлж байгаа үйлчилгээнээс үүсэх холбогдох хязгаарлалтыг тухайн аэродромын ашиглалтад тогтоох үүрэгтэй

-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн

139.55. Ажилтанд тавих шаардлага
 (а) Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:
 (1) Гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон дараах удирдах ажилтан:
 (i) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан

139.153. Хүний нөөц, бие бүрэлдэхүүн
 (а) Гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн шаардлагыг биелүүлж ажиллах чадвартай хүний нөөцтэй байна. Үүнд:
 1/ гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагаа нь энэ дүрмийн шаардлагыг хангаж, санхүүжиж байгааг бататгах эрх бүхий удирдах албан тушаалтан;

<p>шаардлага болон стандартын дагуу гүйцэтгэж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй;</p> <p>(ii) хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартыг хангаж байгааг бататгах үүрэг хариуцлага хүлээх;</p> <p>(2) нисэх буудлын менежерээр томилогдсон дараах удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд:</p> <p>(i) тухайн аэродром болон түүний үйл ажиллагаа А-ээс D Бүлгийн шаардлагыг хангаж байгааг бататгах үүрэг хариуцлага хүлээх;</p> <p>(ii) 139.75-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны үүрэг хариуцлага хүлээх;</p> <p>(iii) Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх;</p> <p>(3) А-аас D Бүлгийн шаардлагын дагуу, тухайн аэродром, түүний үйлчилгээ болон байгууламжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх хангалттай тооны ажилтан.</p> <p>(aa) Энэ зүйлийн (a)(2)(ii)-т заасан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвар, туршлагаа нотлох үүрэгтэй.</p> <p>(b) Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн аэродром, түүний үйлчилгээ болон байгууламжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай ажилтны ур чадварт суурь үнэлгээ хийх ба түүнийг хадгалах журмыг тогтоох үүрэгтэй.</p>	<p>2/ тухайн аэродром болон түүний үйл ажиллагаанд энэ дүрмийн шаардлагыг дагаж мөрдөж байгааг бататгах эрх бүхий албан тушаалтан;</p> <p>3/ үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах аэродром, түүний тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, үйлчилгээг гүйцэтгэх үүрэг бүхий мэргэжлийн, дадлага, туршлагатай ажилтнууд.</p> <p>(б) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн талбайд нэвтрэх, хөдөлгөөнтэй бүсэд тээврийн хэрэгсэл жолоодох, нислэгийн хөдөлгөөний байгууллагатай холбоо барих, талбайд ажиллах журам, нисэх буудлын дэд бүтцийн талаарх танилцуулга зэрэг шаардлагатай сэдвүүдээр шинээр ажилд орсон хүмүүст сургалт явуулахаас гадна давтан сургалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.</p> <p>(в) Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварын түвшинг тогтоох, давтан сургах журам бүхий сургалтын хөтөлбөртэй байна.</p>	<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн</p>
<p>139.57. Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө</p> <p>(a) Аэродромын гэрчилгээ эзэмших <u>хүсэлт гаргагч нь</u> тухайн аэродромд, эсхүл аэродромын ойролцоо онцгой нөхцөл үүсэх боломжийг багасгах, хүний амь нас, өмч хөрөнгөд учирч болох хохирлын хэмжээг <u>бүүрүүлэх</u> зорилготой аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, мөрддөг байх үүрэгтэй.</p> <p>(b) Тухайн аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө нь дараах мэдээллийг багтаасан байх ёстой:</p> <p>(1) <u>төлөвлөсөн онцгой нөхцөлийн төрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;</u></p> <p>(2) <u>төлөвлөсөн</u> онцгой нөхцөлийн үед шуурхай хариу арга хэмжээ авах журам;</p> <p>(3) тухайн <u>төлөвлөгөөг</u> хэрэгжүүлэх үүрэгтэй этгээдийг зохих</p>	<p>139.175. Онцгой <u>байдлын</u> төлөвлөгөө</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь онцгой байдал үүссэн үед хүний амь насыг хамгаалах, эд хөрөнгө эвдрэл, гэмтлийг <u>багасгах</u> зорилготой нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөөг өөрийн нисэх буудлын онцлогт тохируулан боловсруулж, мөрдөнө. Нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг тусгана:</p> <p>1/онцгой <u>байдлын</u> нөхцөлд ажиллах заавар, журам;</p> <p>2/<u>журмыг</u> хэрэгжүүлэх албан тушаалтны гарын авлага;</p>	

гарын авлагаар хангах дэлгэрэнгүй мэдээлэл;

- (4) төлөвлөгөөнд хамрагдаж байгаа байгууллагын дэлгэрэнгүй мэдээлэл болон гүйцэтгэх үүрэг хариуцлага;
- (5) 139.5(аа)(1)-д заасан аэродромын хувьд, онцгой нөхцөлийн төрөлд тохирсон, зохих ёсоор тоноглогдсон онцгой нөхцөлийн удирдлагын төв болон удирдлагын цэг;
- (6) онцгой нөхцөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай, эмнэлгийн төхөөрөмжийг багтаасан, бэлэн байгаа төхөөрөмжийн тодорхойлолт болон тэдгээрийн байрлалын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) тодорхой онцгой нөхцөл үүссэн үед холбоо барих хүмүүс, байгууллагын нэр, болон утасны дугаарыг багтаасан мэдээлэл;
- (8) тухайн аэродромын болон түүний ойролцоох газар нутгийг багтаасан торлосон зураг;
- (9) 139.109-ийн дагуу аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөг тогтмол хэрэгжүүлэх журам.

(с) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

(1) [хүчингүй]

(2) аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөг боловсруулахдаа холбогдох бүх этгээд болон байгууллагын оролцоог аль болох боломжит хэлбэрээр хангах.

3/оролцох байгууллагуудын нэрс, тэдний үүрэг, хариуцлага, онцгой байдлын штаб, удирдлагын байр;

4/онцгой байдлын үед харилцан ажиллах байгууллага, албан тушаалтнуудын нэрсийн жагсаалт, хаяг, утас;

5/аэродром болон хашаанаас гаднах 8 км орчмын бүсийг үзүүлсэн торлосон зураг;

6/онцгой байдлын үед ажиллах журамд дараах нөхцөл байдлуудыг нарийвчлан тусгана:

- 6.1. агаарын хөлгийн осол;
- 6.2. тэсрэх бөмбөг;
- 6.3. барилгын гал;
- 6.4. шатах тослох материалтай газарт гал гарах;
- 6.5. байгалийн гамшиг;
- 6.6. аюултай материал;
- 6.7. агаарын хөлөг барьцаалах;
- 6.8. нийтийг хамарсан жагсаал цуглаан, үймээн самуун;
- 6.9. цахилгаан тасрах, усны үер.

7/тээврийн болон эмнэлгийн тусламж үзүүлэх боломж, автобааз, эмнэлгийн нэрс, хаяг, утас;

8/ нисэх буудалд ажиллаж буй төрийн байгууллагуудын нэрсийн жагсаалт, утас, хаяг;

9/ ослоос амьд үлдсэн хүмүүсийг байршуулах тухай заавар;

10/ хөдлөх чадвараа алдсан агаарын хөлгийг зайлуулах тухай заавар;

11/ онцгой байдал зарлах, дохио өгөх заавар;

12/ нисэх буудал, цамхагийн нислэгийн удирдагчийн хамтарч ажиллах заавар.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь онцгой байдлын төлөвлөгөөний дагуу бүх байгууллага, хувь хүмүүсийн гүйцэтгэх ажил үүргийг зохицуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/ онцгой байдлын төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэх журмыг боловсруулахдаа холбогдох байгууллага, хүмүүсийн саналыг авч танилцуулсан байна; нисэх

Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн

	<p>буудлын ажиллагсад өөрийн гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ танилцаж ойлгосон, сургалтанд хамрагдсан байх бөгөөд онцгой байдлын төлөвлөгөөг жилд 1-ээс доошгүй удаа нягтлан шалгасан, хоёр жилд нэг удаа бүрэн хэмжээний дасгал, сургуулилт хийж, түүнийгээ бататгасан байна.</p>	
--	---	--

139.59. Аврах болон гал унтраах - категори тогтоох

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, 139.5(аа)(1)-д заасан аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Хүснэгт 1-д заасан аврах болон гал унтраах аэродромын категорийг тухайн аэродромыг тогтмол ашигладаг хамгийн том нисэх онгоцны маягийн дагуу тогтоох үүрэгтэй.

Хүснэгт 1. Аэродромын аврах болон гал унтраах категори.

Аэродромын категори ¹	Нисэх онгоцны нийт урт ²	Их биеийн максимум өргөн
3	12 м – 18 м хүртэл, гэхдээ 18 м орохгүй	3 м
4	18 м – 24 м хүртэл, гэхдээ 24 м орохгүй	4 м
5	24 м – 28 м хүртэл, гэхдээ 28 м орохгүй	4 м
6	28м - 39м хүртэл, гэхдээ 39м орохгүй	5 м
7	39м - 49м хүртэл, гэхдээ 49м орохгүй	5 м
8	49 м – 61 м хүртэл, гэхдээ 61 м орохгүй	7м
9	61 м – 76 м хүртэл, гэхдээ 76 м орохгүй	7 м
10	76 м – 90 м хүртэл, гэхдээ 90 м орохгүй	8 м

139.161. Авран хамгаалах, гал унтраах ажиллагааны зэрэглэл

(а) Авран хамгаалах, гал унтраах ажиллагааны зэрэглэлийг тухайн аэродромд тогтмол нислэг үйлдэх хамгийн том онгоцны урт, их биеийн өргөний хэмжээг үзүүлсэн Хүснэгт 1-ийн дагуу тогтоох бөгөөд ингэхдээ энэ зүйлийн (б)-г анхаарч үзнэ.

Хүснэгт 1. Аэродромын авран хамгаалах, гал унтраах ажиллагааны зэрэглэл

Галын зэрэглэл	Онгоцны урт	Их биеийн өргөн
1	0-9 м, гэвч 9 дэх нь орохгүй	2 м
2	9-12 м, гэвч 12 дахь нь орохгүй	2 м
3	12-18 м, гэвч 18 дахь нь орохгүй	3 м
4	18-24 м, гэвч 24 дахь нь орохгүй	4 м
5	24-28 м, гэвч 28 дахь нь орохгүй	4 м
6	28-39 м, гэвч 39 дэх нь орохгүй	5 м
7	39-49 м, гэвч 39 дэх нь орохгүй	5 м
8	49-61 м, гэвч 61 дэх нь орохгүй	7 м
9	61-76 м, гэвч 76 дахь нь орохгүй	7 м

-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн

1. Тухайн аэродромыг тогтмол ашигладаг хамгийн том нисэх онгоцны маягийн дагуу категори тогтоохдоо, нэгдүгээрт нисэх онгоцны нийт уртыг, хоёрдугаарт их биеийн өргөний хэмжээг харгалзана.

2. Хэрэв нисэх онгоцны нийт уртад тохирсон категори сонгосны дараа нисэх онгоцны их биеийн өргөний хэмжээтэй баганад (3) үзүүлсэн тухайн категорийн максимум хэмжээнээс их байгаа бол тухайн нисэх онгоцны хэмжээний хувьд аэродромын категориог нэг категориор дээшлүүлэн тогтооно.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу тогтоосон аэродромын категориог дараах категориор бууруулж болно:

(1) нэг категориор, хэрэв аливаа 12 сарын хамгийн их ачаалалтай үргэлжилсэн 3 сард энэ зүйлийн (a)-ийн дагуу тухайн аэродромын категориог тогтоосон нисэх онгоцны хөдөлгөөн нь 700-гаас бага бол; эсхүл

(2) хоёр категориор, хэрэв:

(i) аливаа 12 сарын хамгийн их ачаалалтай үргэлжилсэн 3 сард энэ зүйлийн (a)-ийн дагуу тухайн аэродромын категориог тогтоосон нисэх онгоцны хөдөлгөөн нь 700-гаас бага бол;

(ii) тухайн аэродромыг ашиглаж байгаа нисэх онгоцны хэмжээгээр энэ зүйлийн (a)-ийн дагуу тогтоосон аэродромын категориудын хооронд 3, эсхүл түүнээс дээш категориын зөрүү байгаа бол.

(c) Энэ зүйлийн (a)-д зааснаас бусад аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь аврах болон гал унтраах категориог дараах байдлаар тогтоох үүрэгтэй:

(1) хэрэв аэродром нь тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай турбо-жэт, эсхүл турбо-фэн нисэх онгоцонд үйлчилдэг бол, тухайн аэродромын аврах болон гал унтраах категориог Хүснэгт 1-д заасан, аэродромыг тогтмол ашигладаг хамгийн том

10	76-90 м, гэвч 90 дэх нь орохгүй	8 м
----	---------------------------------	-----

(б) Авран хамгаалах, гал унтраах ажиллагааны зэрэглэлийг дараах байдлаар тогтооно:

1/ Хүснэгт 1-д тогтоосон галын зэрэглэлд хамаарах II, III ангиллын аэродромд тогтмол хуваариар хөөрч, буух нислэгийн долоо хоногийн дундаж нь 15-аас бага байвал галын зэрэглэлийг нэгээр бууруулж болно;

2/ Хүснэгт 1-д тогтоосон галын зэрэглэлд хамаарах II, III ангиллын аэродромд тогтмол хуваариар хөөрч, буух нисл

3/ эгийн долоо хоногийн дундаж нь 3-аас бага байвал галын зэрэглэлийг нэгээр бууруулж болно. Гэхдээ аль ч тохиолдолд тогтоосон галын зэрэглэл нь 4 зэрэглэлээс доош байж болохгүй;

4/ Хүснэгт 1-д тогтоосон галын зэрэглэлтэй, III, IV ангиллын аэродромд хөөрч, буух нислэгийн долоо хоногийн дундаж нь 3-аас бага байвал галын зэрэглэлийг нэгээр бууруулж болно.

5/ орон нутгийн улирлын чанартай IV ангиллын аэродромын галын зэрэглэлийг Хүснэгт 1-ийн дагуу 1 болон 2 зэрэглэлд хамруулан тогтоож гал унтраах үндсэн бодисыг 100% туслах чанарын бодисоор орлуулж болно;

6/ галын зэрэглэл буурсан тухай мэдээллийг ИНЕГ-ын дарга, нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага, агаарын тээвэрлэгчдэд урьдчилан мэдэгдсэн байна.

нисэх онгоцны маягийн дагуу тогтоох ёстой бөгөөд уг категорийг хоёр категориор бууруулж болох боловч аливаа тохиолдолд Категори 4-өөс доош байж болохгүй;

- (2) хэрэв аэродром нь энэ зүйлийн (с)(1)-д заасан турбо-жэт, эсхүл турбо-фэн нисэх онгоцонд үйлчилдэггүй боловч турбо-жэт биш, эсхүл турбо-фэн биш, , тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа 30-аас дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцонд үйлчилдэг ба аливаа 12 сарын хамгийн их ачаалалтай үргэлжилсэн 3 сард эдгээр нисэх онгоцны 700-гаас их хөдөлгөөний ачаалалтай бол, тухайн аэродромын Категори 3, эсхүл түүнээс дээш байх ёстой;
- (3) хэрэв энэ хэсгийн (1), эсхүл (2)-т аэродромын аврах болон гал унтраах категорийг тогтоогүй бол, категори хамаарахгүй.

139.61. Аврах болон гал унтраах-гал унтраах бодис

Энэ дүрмийн 139.111-д аврах болон гал унтраах хүчин чадалтай байхыг шаардсан аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь 139.59-ийн дагуу тогтоосон галын категорид шаардлагатай. Хүснэгт 2-т заасан минимум хэмжээтэй унтраах бодисыг бэлэн байлгах үүрэгтэй.

Хүснэгт 2. Унтраах бодисын хэрэглэх боломжтой минимум хэмжээ

Аэродромын категори	В түвшний шаардлага хангасан хөөс		С түвшний шаардлага хангасан хөөс		Нэмэлт бодис		
	Ус	Хөөс зарцуулалт / мин	Ус	Хөөс зарцуулалт / мин	Хуурай химийн бодис	Зарцуулалт Хэмжээ	Эсхүл О 2
	Литр	Литр	Литр	Литр	Кг	Кг/сек	Кг
1	2	3	4	5	6	7	8
3	1200	900	820	630	135	2.25	270
4	400	1800	1700	1100	135	2.25	270
5	5400	3000	3900	2200	180	25	360
6	7900	4000	5800	2900	225	2.25	450
7	12100	5300	8800	3800	225	2.25	450
8	18200	7200	12800	5100	450	4.5	900
9	24300	9000	17100	6300	450	4.5	900
10	32300	11200	22280	7900	450	4.5	900

Тайлбар:

1. Эзлэхүүний нэгж нь литрээр, жингийн нэгж нь

139.163. Гал унтраах бодис

(а) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн дагуу тогтоосон авран хамгаалах, гал унтраах ажиллагааны зэрэглэлийг хангах, Хүснэгт 2-т тодорхойлсон шаардлагатай гал унтраах бодисыг бэлэн байлгана.

Хүснэгт 2: Бэлэн байлгах гал унтраах бодисын доод хэмжээ

	А зэрэглэлий хөөс		В зэрэглэлийн хөөс		Туслах бодис
	Ус ⁽¹⁾ (л)	Хөөс зарцуулалт л/минут	Ус ⁽¹⁾ (л)	Хөөс зарцуулалт л/минут	Химийн хуурай бодис ⁽²⁾ (кг)
(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)
1	350	300	230	230	45
2	1000	800	670	550	90
3	1800	1300	1200	900	135
4	3600	2600	2400	1800	135
5	8100	4500	5400	3000	180
6	11800	6000	7900	4000	225
7	18200	7900	12100	5300	225
8	27300	10800	18200	7200	450
9	36400	13500	24300	9000	450
10	48200	16600	32300	11200	450

Тайлбар: Гал унтраахад аль ч туслах бодисыг оновчтойгоор хэрэглэж болно.

(б) Аэродромын авран хамгаалах, гал унтраах ажиллагааны галын зэрэглэлээс хамааруулан галын машинд байвал зохих

-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн

килограммаар илэрхийлэгдэнэ.

2. Багана 2 болон 4-д үзүүлсэн усны хэмжээ нь өгөгдсөн категорийн нисэх онгоцны нийт уртын дундаж хэмжээнд үндэслэсэн болно.

үндсэн болон туслах чанарын бодисын доод хэмжээг Хүснэгт 2-т заасны дагуу тогтоох бөгөөд үндсэн болон туслах чанарын бодисыг дараах байдлаар орлуулан ашиглаж болно:

1/ 1 болон 2 ангиллын аэродромд усыг 100 % туслах чанарын бодисоор орлуулна;

2/ 3 болон 4 ангиллын аэродромд А зэрэглэлийн хөөс ашиглах тохиолдолд усны 30 хүртэл хувийг туслах чанарын бодисоор орлуулна. Гал унтраах бодисыг орлуулахад дараах харьцааг мөрдөнө:

1 кг туслах чанарын бодис = А зэрэглэлийн хөөс үүсгэх 1л ус;

1 кг туслах чанарын бодис= В зэрэглэлийн хөөс үүсгэх 0.66л ус.

Тайлбар 1: Хөөс үүсгэхэд шаардагдах усны хэмжээ нь А зэрэглэлийн хөөсний хувьд 8,2 л/мин/м², В зэрэглэлийн хөөсний хувьд 5,5 л/мин/м² байна.

Тайлбар 2: Өөр ямар нэг төрлийн туслах бодисыг хэрэглэх тохиолдолд орлуулах харьцааг шалгаж үзэх шаардлагатай.

3/ галын машинд байх ёстой хөөс үүсгэгчийн доод хэмжээ нь усны эзлэхүүнийг 2 дахин авсан хэмжээний хөөс гаргахад хүрэлцэхээр байна;

4/ агаарын хөлгийн осол сүйрэл болсон газрын ойр галын машиныг усаар яаралтай цэнэглэх зориулалтын усны нэмэгдэл нөөцийг бүрдүүлсэн байна;

5/ нөөцөнд байх хөөс үүсгэгч болон гал унтраах туслах чанарын бодисын хэмжээ нь галын машинд байвал зохих хамгийн бага хэмжээнээс 2 дахин их болон 200%-тай тэнцэхээр байна. Нөөцөнд заавал байх ёстой зохих хэмжээний нөхөн хангалтыг тухай бүр хийж байна.

139.63. Аврах болон гал унтраах-тээврийн хэрэгсэл

(а) Энэ дүрмийн [139.111-д аврах болон гал унтраах](#) хүчин чадалтай байхыг шаардсан аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь [139.59-д тогтоосон аэродромын категорийн хувьд](#), Хүснэгт 3-т заасан аврах болон гал унтраах минимум тээврийн хэрэгсэлтэй байх үүрэгтэй.

Хүснэгт 3. Аврах болон гал унтраах тээврийн хэрэгслийн минимум тоо

139.59-ийн дагуу тогтоосон аэродромын категори	Аврах болон гал унтраах тээврийн хэрэгсэл
3	1
4	1
5	1
6	2
7	2
8	3
9	3
10	3

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (a)-д шаардсан тээврийн хэрэгслийг дараах нэгжтэй хоёр талын радио холбоотой байхаар тоногдсон байх ёстой:

(1) тухайн аэродромд шаардсан аврах болон гал

139.165. Авран хамгаалах, гал унтраах машин механизм

(a) Аэродромын гэрчилгээ эзэмшигч энэ дүрмийн [139.161-ийн дагуу тогтоогдсон](#), тухайн зэрэглэлийн шаардлага хангасан авран хамгаалах, гал унтраах машин механизм, [тоног төхөөрөмжийг](#) бэлэн байлгана.

унтраах бусад тээврийн хэрэгсэлтэй;

(2) тухайн аэродромд үйлчилгээ үзүүлж байгаа аэродромын удирдлагын эсхүл нислэгийн мэдээллийн үйлчилгээтэй;

(3) хүсэлт гаргагчийн аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөнд заасан бусад галын хэсэгтэй.

(с) Энэ зүйлийн (b)-г үл харгалзан, аврах болон гал унтраах тээврийн хэрэгслийг **хоёр талын радио холбоогоор тоногдсон байхыг дараах тохиолдолд шаардахгүй**, хэрэв:

(1) зөвхөн нэг тээврийн хэрэгсэл шаардлагатай бол;

(2) тухайн аэродромд үйлчилгээ үзүүлж байгаа аэродромын удирдлагын, эсхүл нислэгийн мэдээллийн үйлчилгээ байхгүй бол;

(3) аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөнд бусад галын хэсэгтэй радио холбоо барихаар заагаагүй бол.

(d) Энэ зүйлийн (a)-д шаардсан тээврийн хэрэгсэл нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

(1) **анивчдаг, эсхүл эргэлддэг маяктай байх;**

(2) **тод харагдахуйц дан улаан, эсхүл шар-ногоон өнгөөр тэмдэглэгээ хийгдсэн байх.**

*(б) Авран хамгаалах, гал унтраах машинууд нь **хоёр талын радио холбоотой байх бөгөөд тэдгээр нь дараах газруудтай холбоо барих боломжтой байна:***

1/ бусад авран хамгаалах, гал унтраах тусгай машин механизмтай;

2/ цамхагийн нислэгийн удирдагчтай;

3/ нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөөнд тусгагдсан бусад хэсгүүдтэй.

(в) Авран хамгаалах, гал унтраах машинууд нь ямар ч үед орчноосоо ялгагдахаар тэмдэг, тэмдэглэгээтэй, тод өнгөөр будагдсан байна.

(г) Хүйтний улиралд зориулалтын дулаан газарт байлгах, техникийн үзлэг, үйлчилгээ, хяналтыг тогтмол хийх, үүрэг гүйцэтгэхэд байнга бэлэн байлгана.

(д) Үзэгдэх орчин муу тохиолдолд ослын газарт саадгүй хүрэх журамтай байна.

(е) Хөөрч буух зурвасны босгоноос хашаа хүртэлх зайд буюу аэродромын хязгаар дотор буултын оролт үйлдэх бүсэд галын машин чөлөөтэй нэвтрэх замыг бэлэн байлгана. Аэродромын хашааны гадна осол болох үед ослын гарцуудыг тооцож урьдчилан бэлдсэн байна.

(ж) Авран хамгаалах, гал унтраах аль нэг машин техник тухайн нислэгийн үед үүрэг гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд ИНЕГ, нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага, агаарын тээвэрлэгчдэд урьдчилан мэдэгдсэн байна.

139.65. Аврах болон гал унтраах-ажилтанд тавих шаардлага

Энэ дүрмийн 139.111-д аврах болон гал унтраах хүчин чадалтай байхыг шаардсан аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн аэродромын аврах болон гал унтраах бүх бие бүрэлдэхүүн дараах шаардлагыг хангаж байгааг бататгах журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай зориулалтын хамгаалалтын хувцас болон авран хамгаалах төхөөрөмжөөр тоноглогдсон байх;
- (2) сургалтад хамрагдсан, эрүүл мэнд болон бие бялдрын хувьд тохирсон байх ба аврах болон гал унтраах төхөөрөмжийг ашиглах чадвартай байх;
- (3) ур чадвараа хадгалах байнгын дадлага болон давтан сургалтад хамрагдсан байх;
- (4) аврах болон гал унтраах тээврийн хэрэгсэл, эсхүл тээврийн хэрэгслүүд болон төхөөрөмжийн хүчин чадлыг бүрэн хэмжээгээр ажиллуулах хангалттай тооны ажилтныг бэлэн байлгах;
- (5) тэдний туслалцаа шаардлагатай онцгой нөхцөл үүссэн, эсхүл гарч болзошгүй үед дуут дохио, сэрүүлэг, эсхүл бусад хэлбэрээр анхааруулсан дохио хүлээж авдаг байх.

139.167. Авран хамгаалах, гал унтраах бие бүрэлдэхүүнд тавигдах шаардлага

(а) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь авран хамгаалах, гал унтраах бие бүрэлдэхүүнийн хувьд дараах зүйлийг бататгана:

- 1/ гал эсэргүүцэх бие бүрэлдэхүүн нь зохих сургалтанд хамрагдаж тусгайлан бэлтгэгдсэн, бие бялдрын хувьд эрүүл чийрэг, төрөл бүрийн галтай дасгал сургуульд оролцсон, зориулалтын хамгаалалтын хувцас, багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан, тэдгээрийг ямар ч төрлийн галд чадварлаг эзэмшдэг, багаар ажиллах чадвартай байна;
- 2/ бие бүрэлдэхүүн нь "Агаарын хөлгийн гал унтраах, зорчигчдыг аврах" анхан шатны болон давтан сургалтанд хамрагдсан, жилд нэгээс доошгүй, хоёр жилд нэг удаа "Нисэх буудлын онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө"-ний дагуу бодит байдалд ойртуулсан бүрэн хэмжээний бататгах дадлага сургалтанд хамрагдаж илэрсэн дутагдлыг арилган, төлөвлөгөөнд баяжилт хийсэн байна;
- 3/ бие бүрэлдэхүүн нь үйл ажиллагааны заавартай байх бөгөөд энэ заавартаа хүн нэг бүрийн хийх ажлын хуваарь, галын дуудлагаар ажиллах, галын техникийн засвар үйлчилгээ, тэдгээрийг ашиглах чадвар, төрөл бүрийн галтай сургалт дадлага, бие бялдрын хөгжлийн шалгууруудыг оруулсан байна;
- 4/ машин механизм, тоног төхөөрөмж нь байнгын бэлэн байдалтай, хангалттай орон тоотой байна;
- 5/ дуудлагыг дуут болон гэрлэн дохиогоор хүлээн авах боломжтой байна.

-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн

139.67. Аврах болон гал унтраах-хариу арга хэмжээ авах чадвар

Энэ дүрмийн 139.111-д аврах болон гал унтраах хүчин чадалтай байхыг шаардсан аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, хэрэв Дарга шаардсан бол, тухайн аэродромын алсын барааны харагдацын болон гадаргуугийн тохиромжтой нөхцөлд дараах аврах болон гал унтраах хариу арга хэмжээ авах чадвараа харуулсан байх үүрэгтэй:

- (1) тухайн аэродромын категорийн хувьд, 139.61-ийн Хүснэгт 2-т шаардсан хөөсний 50%-иас доошгүйг зарцуулахад шаардлагатай аврах болон гал унтраах тээврийн хэрэгсэл бие бүрэлдэхүүн нь анхны дуудлагаас хойш 3 минутын дотор өөрийн байрлаж байгаа постоос, шаардлагатай хэмжээний хөөс цацах хөдөлгөөнт бүсийн хамгийн хол цэгт хүрч, хөөс цацахад бэлэн болсон байх;
- (2) тухайн аэродромын категорийн хувьд 139.61-ийн Хүснэгт 2-т шаардсан хэмжээний гал унтраах бодисыг гаргахад шаардлагатай эхний хариу үйлдэл үзүүлэх аврах болон гал унтраах тээврийн хэрэгсэл бие бүрэлдэхүүнээс бусад, аврах болон гал унтраах тээврийн хэрэгсэл бие бүрэлдэхүүн нь дараах үүрэгтэй:
 - (i) анхны дуудлагаас хойш 4 минутаас ихгүй хугацаанд ирсэн байх;
 - (ii) бие бүрэлдэхүүн нь, унтраах бодисыг тасралтгүй залгуулан цацахыг бататгах.

139.67A. Аврах болон гал унтраах-холбооны болон анхааруулах систем

- (a) Энэ зүйл нь 2020 оны 7 сарын 30-нд өдрөөс хойш үйлчилнэ.
- (b) Энэ дүрмийн 139.111-д аврах болон гал унтраах хүчин чадалтай байхыг шаардсан аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, галын ангийг тухайн аэродромын удирдлагын цамхаг, бусад галын анги

139.169. Авран хамгаалах, гал унтраах ажлын чадварт тавигдах шаардлага

(a) Гэрчилгээ эзэмшигч нь авран хамгаалах, гал унтраах ажиллагааг гүйцэтгэх чадвараа дараах байдлаар үзүүлнэ:

- 1/ дуудлага хүлээн аваад 3 минутын дотор энэ дүрмийн 139.163 зүйлийн Хүснэгт 2-т заасан гал унтраах хөөсний 50%-тай тэнцэх хэмжээний хөөсийг шахах хүчин чадалтай эхний галын машин ослын газарт ирж хөөсөө цацаж эхэлсэн байх;
- 2/ эхний галын машин ослын газарт ирснээс хойш 1 минутын дотор дараагийн галын машинууд ирж энэ дүрмийн 139.163 зүйлийн хүснэгт 2-т заасан гал унтраах хөөсийг үргэлжлүүлэн цацах.

-Amend.10-аар нэмэгдсэн

<p>аврах болон гал унтраах тээврийн хэрэгсэлтэй холбосон бие даасан холбооны системтээр хангах үүрэгтэй.</p> <p>(с) Энэ зүйлийн (а) нь 2020 оны 7 сарын 30-нд өдөр хүчингүй болно.</p>		
<p>139.69. Нийтийн хамгаалалт</p> <p>(а) Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) аэродромын хөдөлгөөнт бүс рүү мал, амьтан санамсаргүй нэвтрэхээс хамгаалах;</p> <p>(1А) зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгсэл аэродромын үйл ажиллагааны бүсэд нэвтрэхээс хамгаалах;</p> <p>(2) агаарын хөлгийн хөдөлгүүрийн хийн урсгалаас хүн болон өмч хөрөнгийг боломжит хэлбэрээр хамгаалах.</p> <p>(b) Энэ дүрмийн 139.5 (аа)-д заасан аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, (а)(1) болон (а)(1А)-д шаардсан хамгаалалт нь дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1) хүмүүс тээврийн хэрэгслээр, эсхүл явган хүний замаар дамжин шууд нэвтрэх аэродромын үйл ажиллагааны бүсийн дэргэдэх талбай нь:</p> <p>(i) нэвтрэх хяналттай, эсхүл хамгаалалттай барилга, байгууламж болон хаалга гарц бүхий үргэлжилсэн хаалт, хашлагатай байх;</p> <p>(ii) 1200 мм-ээс доошгүй өндөр хаалттай байх;</p> <p>(2) бусад талбай нь агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул учруулж болзошгүй мал амьтан нэвтрэхээс урьдчилан сэргийлэхэд тохирсон барилга болон өндөр хаалттай байх.</p>		<p>-Amend.10-аар нэмэгдсэн</p>
	<p>139.59. Гэрчилгээ, түр зөвшөөрөл олгох</p> <p>(а) ИНЕГ-ын дарга нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд харшлахгүй гэж үзсэн тохиолдолд дараах шаардлагыг бүрэн хангасан өргөдөл гаргагчид Аэродромын гэрчилгээ, эсхүл түр зөвшөөрлийг олгоно. Үүнд:</p> <p>1/ төлөвлөсөн хугацаанд нислэг үйлдэж эхлэх тухай агаарын тээвэрлэгч, эсхүл ашиглагч бичгээр мэдэгдсэн;</p> <p>2/ ирүүлсэн өргөдөл, аэродромын заавар, холбогдох бусад бичиг баримт нь энэ дүрэм болон нисэхийн аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн;</p>	

	<p>3/ хяналтын үзлэг шалгалтад тэнцсэн, аэродромын үйл ажиллагааг нисэхийн аюулгүй ажиллагааны болон энэ дүрмийн шаардлагын хүрээнд эрхлэх боломжийг бүрдүүлсэн, нисэх буудлын дэд бүтэц нь стандартын шаардлагыг хангасан, үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах чадварлаг боловсон хүчинтэй, удирдлага зохион байгуулалт сайн, санхүүгийн болон материалын эх үүсвэр, нөөцтэй нь батлагдсан.</p>	
<p>139.71. Мал, амьтан, шувууны аюулаас сэргийлэх, зохицуулалт Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, хэрэв зэрлэг ан амьтан тухайн аэродром дээрх агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул учруулахаар бол, тухайн аюулыг бууруулах, эсхүл арилгах зорилготой хүрээлэн буй орчны менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.</p>	<p>139.193. Мал, амьтан, шувууны аюулаас сэргийлэх</p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-ын даргаар хүлээн зөвшөөрөгдсөн “Амьтан, шувууны аюулаас сэргийлэх хөтөлбөр”-тэй байх ба энэ талаар Үйл ажиллагааны заавартаа тусгасан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1/ хөтөлбөрийн бүлэг тус бүрээр хэрэгжилтийг хариуцах этгээд, түүний үүрэг; 2/ газар эзэмшлийн төлөвлөгөө, шувууны нүүдэл, суурьшлын байршил; 3/ улсын, бүсийн, орон нутгийн хөтөлбөрийн хуулбар хувь; 4/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийн сурвалж; 5/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах журам; 6/ сургалт, шалгалтын төлөвлөгөө. <p>(б) Гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааны заавартаа заасны дагуу амьтан, шувуунаас учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг багасгах, нэн даруй арилгах арга хэмжээг авах бөгөөд доорх нөхцөл байдал үүссэн үед түүнтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1/ агаарын хөлөг сүрэг шувууны довтолгоонд өртсөн; 2/ агаарын хөлөг шувуутай мөргөлдсөнөөс гэмтэл үүссэн; 3/ агаарын хөлгийн хөдөлгүүрт шувуу орсон; <p>нислэгийн талбай, ойртолт болон хөөрөлтийн бүсэд шувуу байнга, ихээр үзэгдэх болсон.</p>	<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн</p>
<p>139.73. Аэродромын өгөгдөл болон мэдээллийг зарлан мэдээлэх</p>	<p>139.195. Аэродромын байдлын тухай илтгэх, тайлагнах, мэдээлэх</p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь аэродромын байдлын тухай мэдээллийг цуглуулах, агаарын тээвэрлэгч, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагад мэдээлэх, утсан болон радио холбоо, факс гэх мэт арга хэрэгслийг хэрэглэж хэвшсэн байх бөгөөд агаарын тээвэрлэгч болон бусад үйлчлүүлэгчдийг дараах мэдээллээр хангана:</p>	<p>-Amend.10-аар нэмж орсон</p>

Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад дараах зүйлийг мэдэгдэх журмыг тогтоох үүрэгтэй:

- (1) аэродромын өгөгдөл болон мэдээлэл;
- (2) 139.853-д заасны дагуу тухайн аэродромын ашиглалтад тогтоосон хязгаарлалт;
- (3) тухайн аэродромын ашиглалтад нөлөөлөх өөрчлөлтийг цаг алдалгүй.

- 1/ хөдөлгөөний бүсэд явагдаж буй барилгын ажил, аэродромын засвар арчлалтын ажлын талаар;
- 2/ гадаргуугийн эвдрэлийн талаар;
- 3/ цас, мөстөлт, ус, хатуурсан, хөлдсөн цасны талаар;
- 4/ хөдөлгөөнт бүс болон аюулгүйн бүсэд гадны биет илэрсэн талаар;
- 5/ гэрэл суултын систем ажиллахгүй байх талаар;
- 6/ шувуу, амьтны аюул хяналтаас гарсан талаар;
- 7/ авран хамгаалах болон галын хангалт хийгдэхгүй талаар;
- 8/ аюулгүй ажиллагаанд харшлах бусад хүчин зүйлүүдийн талаар.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх буудлын нөхцөлийн талаарх мэдээллийг үргэлжилсэн 12 сарын хугацаанд цуглуулж хадгална.

139.63. Гэрчилгээг шилжүүлэх

(а) ИНЕГ-ын дарга нь дараах журмыг баримтлан Аэродромын гэрчилгээг шилжүүлэхийг зөвшөөрч болно:

- 1/ гэрчилгээ эзэмшигч нь аэродромын үйл ажиллагааг зогсоохоос 60-аас доошгүй хоногийн өмнө энэ тухайгаа ИНЕГ-ын даргад бичгээр мэдэгдэж, Аэродромын гэрчилгээг ирүүлнэ;
- 2/ гэрчилгээ эзэмшигч нь Аэродромын гэрчилгээг шилжүүлэн авагчийн талаарх мэдээллийг ИНЕГ-т албан ёсоор мэдэгдэнэ;
- 3/ гэрчилгээ шилжүүлэн авагч нь гэрчилгээ эзэмшигч үйл ажиллагаагаа зогсоохоос 14 -өөс доошгүй хоногийн өмнө уг Аэродромын гэрчилгээг шилжүүлэн авах тухай хүсэлтээ энэ дүрмийн Б бүлэгт заасны дагуу ИНЕГ-ын даргад ирүүлнэ;
- 4/ гэрчилгээ шилжүүлэн авагч энэ дүрмийн шаардлагыг бүрэн хангаж байгаа нь нотлогдсон тохиолдолд гэрчилгээг шилжүүлнэ;

(б) ИНЕГ-ын дарга Аэродромын гэрчилгээг шилжүүлэхээс татгалзсан тохиолдолд гэрчилгээ шилжүүлэн авахыг хүссэн

	этгээдэд энэ тухай шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.	
	139.67. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх (а) ИНЕГ-ын дарга өргөдөл гаргагч, гэрчилгээ эзэмшигчийг энэ дүрмийн шаардлагаас ИНД-11-д заасны дагуу тодорхой хугацаагаар, үйл ажиллагааны хязгаарлалттайгаар чөлөөлж болно.	
139.75. Аюулгүй байдлын удирдлага Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрдөх үүрэгтэй.		-Amend.10-аар нэмж орсон
139.76. Нислэгийн хөдөлгөөний өгөгдлийг мэдээлэх Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн аэродромын сарын нислэгийн хөдөлгөөний өгөгдлийг цуглуулж, Даргад 3 сар тутам мэдээлэх журмыг тогтоох үүрэгтэй.		-Amend.10-аар нэмж орсон
139.76А. Аэродром дээр хийгдэх ажил Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн аэродромд хийгдэж байгаа ажил агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул учруулахгүй байхыг бататгах зорилгоор, урьдчилсан сэргийлэх арга хэмжээг багтаасан журмыг тогтоох үүрэгтэй.		-Amend.10-аар нэмж орсон
139.76В. Баримт бичиг Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй: (1) тухайн аэродром, түүнтэй холбоотой үйлчилгээ болон байгууламжийн ашиглалт үйл ажиллагаанд шаардлагатай холбогдох баримт бичгийн хувийг хадгалах; (2) дараах зүйлийг бататгах зорилгоор энэ хэсгийн (1)-д шаардсан баримт бичгийн хяналтын журмыг тогтоох: (i) холбогдох баримт бичгийн хүчинтэй хувийг ажилтны ашиглах шаардлагатай байрлалд хэрэглэхэд бэлэн байлгах; (ii) хүчингүй болсон баримт бичгийг гаргаж байгаа, эсхүл ашиглаж байгаа бүх цэгээс нэн даруй хураадаг байх; (iii) өөрчлөгдөж хүчингүй болсон материалыг ашиглахаас сэргийлж, баримт бичгийн зүйл бүрийн хүчинтэй байдлыг таних боломжтой байх;		-Amend.10-аар нэмж орсон
139.77. Аэродромын гэрчилгээжүүлэлтийн Ерөнхий заавар (а) Аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан Ерөнхий зааврыг <u>Даргад</u> хүргүүлэх	139.101. Ерөнхий шаардлага (а) Энэ дүрмийн шаардлагын дагуу боловсруулж, <u>ИНЕГ-аас</u> хүлээн зөвшөөрсөн, хянасан Аэродромын зааваргүй	

үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад заавар нь дараах шаардлагыг хангаж байгааг бататгаж хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:
- (i) тухайн байгууллагыг тодорхойлж, энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулсан байх;
 - (ii) байнга дагаж мөрддөг байх;
- (1A) 139.75-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотойгоор:
- (i) ИНД -100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) аэродромын гэрчилгээ сунгуулахаас бусад хүсэлт гаргагчийн хувьд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхээ дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 139.55(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын албан тушаал болон нэрс;

- (3) 139.55(a)(1) болон 139.55(a)(2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын дараах шаардлагыг багтаасан үүрэг, хариуцлага:
- (i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
 - (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;
- (4) 139.55(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (5) 139.53-ын дагуу тогтоосон тухайн аэродромын ашиглалтад тавих хязгаарлалт;
- (6) А, В, С, эсхүл D Бүлгийн шаардлагаас хүсэлт гаргагчийг чөлөөлсөн бүх хүчинтэй шийдвэр (exemption);

тохиолдолд Аэродромын гэрчилгээ, түр зөвшөөрөл олгох, хүчинтэй хугацааг сунгахыг хориглоно.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь Аэродромын зааврын хүчин төгөлдөр батлагдсан хувийг үзлэг шалгалт хийхэд зориулан нисэх буудалд тогтмол байрлуулж, нэг хувийг ИНЕГ-ын даргад ирүүлсэн байна.

(г) Аэродромын зааврыг мөрдөж, хэрэгжүүлэх шаардлагын дагуу нисэх буудлын ажиллагсад хүртээмжтэй байлгахад гадна ажиллагсад өөрийн гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ танилцсан байна.

(д) Аэродромын зааврыг боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулахдаа ИНЕГ-аас гаргасан зөвлөмжийн цувралуудыг ашиглаж болно.

139.103. Аэродромын зааврын агуулга

(а) Гэрчилгээ эзэмшигч Аэродромын заавартаа дор дурдсан мэдээлэл, баримт бичгийг тусгах буюу хавсаргасан байна:

- 1/ аэродромын өгөгдлүүд, бусад мэдээлэл;
- 2/ 15 км радиустай байршлын газрын зураг;
- 3/ аэродромын ерөнхий төлөвлөгөө;
- 4/ нислэгийн талбайн торлосон зураг, схем;
- 5/ тэмдэг, тэмдэглэгээ, дохио, гэрэлтүүлэг;
- 6/ навигацийн тоноглолын байршил, хэмжээг үзүүлсэн зураг;
- 7/ албан тушаалтан, ажилтны нэрс, утасны дугаар, и-мэйл хаяг;
- 8/ албан тушаалтан, ажилтнуудын үүрэг хариуцлагыг харуулсан бүтэц зохион байгуулалтын бүдүүвч;
- 10/ газар эзэмших, ашиглах талаар тухайн орон нутгийн засаг захиргааны зөвшөөрөл;
- 11/ аэродромын онцгой байдлын үед ажил аэродромын онцгой байдлын үед ойр орших хот суурингийн хүчний болон эмнэлэг, эрүүл ахуйн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, дадлага сургуулилтын төлөвлөгөө;
- 12/ авран хамгаалах, гал унтраах хөтөлбөр, тоног төхөөрөмж, хүн хүчний мэдээлэл, эсхүл ойролцоо суурин газрын онцгой байдлын хэлтэс, галын албатай хамтран ажиллах гэрээ, хэрэгжилт;

-Amend.4-өөр хүчингүй болж

-Amend.10-аар нэмэгдсэн

- (6A) тухайн байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;
- (7) 139.57-д шаардсан аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө;
- (8) 139.59-ийн дагуу тогтоосон аэродромын аврах болон гал унтраах категорийн мэдэгдэл, 139.61, 139.63 болон 139.67A-д шаардсан гал унтраах бодис, тээврийн хэрэгсэл болон бие даасан холбооны системийн үзүүлэлтийн хамт, 139.65-д шаардсан журам болон ажилтнууд, 139.111(с)(2), (3)-т шаардсан журам;
- (9) 139.69-д шаардсан нийтийн хамгаалалтын тодорхойлолт;
- (10) 139.71-д шаардсан бол, хүрээлэн буй орчны менежментийн хөтөлбөр;
- (11) 139.73-т шаардсан, аэродромын өгөгдөл болон мэдээллийг зарлан мэдээлэх журам;
- (12) [хүчингүй]
- (12A) 139.76-д шаардсан, нислэгийн хөдөлгөөний өгөгдлийг цуглуулах болон мэдээлэх журам;
- (13) 139.103-т шаардсан, аэродромын засвар, үйлчилгээний хөтөлбөр;
- (14) 139.105-д шаардсан, навигацид зориулсан аэродромын ил харааны туслах хэрэгсэл тэмдэглэгээний урьдчилан сэргийлэх засвар, үйлчилгээ болон шалгалт хийх журам;
- (15) 139.76A-д шаардсан, аэродром дээр ажил гүйцэтгэх журам болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- (16) [хүчингүй]
- (17) 139.117-д шаардсан, аэродромын үзлэгийн хөтөлбөр, журам болон мэдээллийн тогтолцоо;
- (18) 139.119-д шаардсан, газрын үйлчилгээний тээврийн хэрэгслийг хянах журам;
- (19) 139.125-д шаардсан, аэродромд аюултай нөхцөл үүссэн үед агаарын хөлгийн үйл ажиллагааг хязгаарлах журам;
- (19A) 139.76B(2)-т шаардсан, аэродромын ашиглалт болон үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийн хяналт, зохицуулалтын журам;
- (20) 139.203(d)(8) болон (9)-д шаардсан, аюулгүйн хамгаалалтын мэдлэг олгох хөтөлбөр, журмын дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан D Бүлгийн аюулгүйн хамгаалалтын шаардлагыг мөрдөх арга хэмжээний тайлбар;
- (21) 139.205(с)-д шаардсан, аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөр;

- 13/ авран хамгаалах, гал унтраах талаар дүрмийн шаардлагаас чөлөөлсөн танилцуулга;
- 14/ аэродромын хөдөлгөөний бүсэд хөдлөх чадвараа алдсан агаарын хөлгийг шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө, тоног төхөөрөмж, сургалт;
- 15/ аэродром болон түүний орчинд шувуу, зэрлэг амьтдын аюулаас сэргийлэх хөтөлбөр;
- 16/ перроны удирдлага зохицуулалтын журам;
- 17/ аэродромд үзлэг хийх болон бэлэн байдлын тухай мэдээллийн журам ;
- 18/ аэродромын ойртолтын болон хамгаалагдсан бүсэд үйл ажиллагаа явуулах журам;
- 19/ хашаа хамгаалалтын хийц, байршил, гэрэлтүүлэг, хаалга, гарцуудын зураг, мэдээлэл;
- 20/ нисэх буудлын байгаль орчныг хамгаалах хөтөлбөр, нарийвчилсан үнэлгээ;
- 21/ хамгаалах төлөвлөгөө; аэродромын онцгой байдлын үед ойр орших хот суурингийн хүчний болон эмнэлэг, эрүүл ахуйн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, дадлага сургуулилтын төлөвлөгөө;
- 22/ авран хамгаалах, гал унтраах хөтөлбөр, тоног төхөөрөмж, хүн хүчний мэдээлэл, эсхүл ойролцоо суурин газрын онцгой байдлын хэлтэс, галын албатай хамтран ажиллах гэрээ, хэрэгжилт;
- 23/ авран хамгаалах, гал унтраах талаар дүрмийн шаардлагаас чөлөөлсөн танилцуулга;
- 24/ аэродромын хөдөлгөөний бүсэд хөдлөх чадвараа алдсан агаарын хөлгийг шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө, тоног төхөөрөмж, сургалт;
- 25/ аэродромын онцгой байдлын үед ойр орших хот суурингийн хүчний болон эмнэлэг, эрүүл ахуйн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, дадлага сургуулилтын төлөвлөгөө;
- 26/ авран хамгаалах, гал унтраах хөтөлбөр, тоног төхөөрөмж, хүн хүчний мэдээлэл, эсхүл ойролцоо суурин газрын онцгой байдлын хэлтэс, галын албатай хамтран ажиллах гэрээ, хэрэгжилт;
- 9/ ажилтнуудын сургалтын хөтөлбөр
- (б) Аэродромын заавар нь хуудасны дугаар, хавсралт, тэмдэглэгээ, хяналт өөрчлөлтийн огноо зэргийг багтаасан, нэмэлт өөрчлөлт оруулах, санал авах, хянахад хялбар бүтэцтэй байна.

(22) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, тараах журам;

(b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

27/аэродромын онцгой байдлын үед ойр орших хот суурингийн хүчний болон эмнэлэг, эрүүл ахуйн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, дадлага сургуулилтын төлөвлөгөө;

28/авран хамгаалах, гал унтраах хөтөлбөр, тоног төхөөрөмж, хүн хүчний мэдээлэл, эсхүл ойролцоо суурин газрын онцгой байдлын хэлтэс, галын албатай хамтран ажиллах гэрээ, хэрэгжилт;

29/авран хамгаалах, гал унтраах талаар дүрмийн шаардлагаас чөлөөлсөн танилцуулга;

30/аэродромын хөдөлгөөний бүсэд хөдлөх чадвараа алдсан агаарын хөлгийг шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө, тоног төхөөрөмж, сургалт;

31/аэродром болон түүний орчинд шувуу, зэрлэг амьтдын аюулаас сэргийлэх хөтөлбөр;

32/перроны удирдлага зохицуулалтын журам;

33/аэродромд үзлэг хийх болон бэлэн байдлын тухай мэдээллийн журам ;

34/аэродромын ойртолтын болон хамгаалагдсан бүсэд үйл ажиллагаа явуулах журам;

35/хашаа хамгаалалтын хийц, байршил, гэрэлтүүлэг, хаалга, гарцуудын зураг, мэдээлэл;

36/нисэх буудлын байгаль орчныг хамгаалах хөтөлбөр, нарийвчилсан үнэлгээ;

37/аэродром ашиглалтын заавар/ хучилттай, хучилтгүй, аюулгүйн зурвасууд, цас мөстөлтийг арилгах, цэвэрлэгээ, арчлалт;

38/аэродромын үйл ажиллагааны чанарын дотоод хяналтын журам;

39/аюулгүй байдлын үзлэг хяналтын хөтөлбөр;

40/нислэгийн талбайд барилгын ажил хийх журам;

41/нислэгийн талбай дотор болон түүний гадна навигацгийн тоноглолыг хамгаалах журам;

42/газрын үйлчилгээ үзүүлэх журам.

(б) Гэрчилгээжсэн аэродром нь Чикагогийн конвенцийн Хавсралт 14 “Аэродром”-ын зөвлөмжийн дагуу үйл ажиллагаандаа Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Энэ шаардлагыг аэродром дээр үйл ажиллагаа явуулдаг бүх байгууллагуудад хэрэгжүүлж ажиллана. Аэродромын ангиллаас хамаарч Аэродромын зааварт заавал оруулах бичиг баримтын бүтэц өөр байж болно.

<p>139.101. Байнгын хэрэгжилт Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй: (1)139.77-д шаардсан Ерөнхий зааврын хүчинтэй, нэгээс доошгүй бүрэн хувийг тухайн аэродромд хадгалах; (2)Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журам, хөтөлбөр, систем болон төлөвлөгөөг дагаж мөрдөх; (3)Ерөнхий зааврын холбогдох бүлгийг шаардлагатай ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглах боломжтой байлгах; (4)энэ Дүрмийн дагуу аэродромын гэрчилгээжүүлэлтэд тогтоосон В Бүлгийн шаардлагыг биелүүлж, стандартыг байнга мөрдөх; (5)САА 24139/01 маягтад шаардсан үйлчилгээний хаяг, утасны дугаар, эсхүл бусад холбоо барих дэлгэрэнгүй мэдээллийн өөрчлөлтийг 28 хоногийн дотор Даргад мэдээлэх.</p>		<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт хийгдсэн</p>
<p>139.102. RESA шилжилтийн зохицуулалт [Хүчингүй]</p>		<p>-Amend.5-аар хүчингүй болсон</p>
<p>139.103. Аэродромын засвар, үйлчилгээ (a) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалт, тогтмолжилт, эсхүл үр дүнтэй байдалд нөлөөлөхгүй нөхцөлд тухайн аэродромын байгууламжид засвар, үйлчилгээ хийх, хэрэв хамааралтай бол, урьдчилан сэргийлэх засвар, үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй. (b) Засвар, үйлчилгээний хөтөлбөрт дараах шаардлагыг тусгасан байх ёстой: (1)хучилттай маневрын талбайн гадаргуугийн хувьд агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул учруулж болох гээгдсэн биет, эсхүл хог хаягдлыг цэвэрлэсэн байх; (2) хучилттай ХБЗ-ны гадаргуугийн хувьд гадаргуугийн барьцалтын итгэлцүүрийн үзүүлэлт сайн, агаарын хөлгийн дугуйны өнхрөлтийн эсэргүүцэл бага байх нөхцөлийг хангахаар арчилж хамгаалсан байх; (3)2020 оны 7 сарын 30-наас хойш, ХБЗ тундастай үед стандарт мэдээллийн аргыг ашиглан тухайн хэмжилтийн болон бодит цаг хугацааны гадаргуугийн нөхцөлийн тайланг мэдээлэх.</p>	<p>139.155. Аэродромын арчлалт (a) Нисэх буудал нь ангиллаасаа хамааран аэродромын ашиглалт хариуцсан нэгж, мэргэжилтэнтэй байна. (b) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлөг аюулгүй хөөрч, буух нөхцөлийг хангах зорилгоор хучилттай элементүүд, хайрган болон ердийн хөрсөн элементүүд, аюулгүйн зурвасууд, нислэгийн талбайн нийт хэмжээнд ашиглалтын болон засвар үйлчилгээний ажлын журам, аэродром ашиглалтын зааврын дагуу засвар арчлалтын ажлыг явуулж, аэродромын бэлэн байдлыг хангана. (c) Аэродром ашиглалтын зааварт бетон хучилтын зэрэгцээ хавтангийн өндрийн зөрүү, хучилтын хагарлын өргөн, нүхний гүн, нүхний нийт хэмжээ зэргийн зөвшөөрөгдөх хэмжээг заасан байна. (d) Хучилттай гадаргуугаас аливаа гадны биет, бохирдолт, тоос, шороо, резины наалдац, элс шороо зэргийг зохих аргачлалын дагуу тухай бүр зайлуулсан байна. (e) Цас, мөс цэвэрлэгээний ажилд хэрэглэсэн химийн гаралтай бодисын үлдэгдлийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу аль болох түргэн зайлуулах арга хэмжээ авна.</p>	<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон</p>

	<p>(е) Нислэгийн талбайн хэмжээнд навигацийн болон ил харааны тэмдэг, тоноглолоос өөр төрлийн биет, ухсан нүх, овоолсон шороо, чулуу, байгууламж байхыг хориглоно.</p> <p>(ж) Зөвшөөрөгдөх тэмдэгт, тоноглол зэрэг нь аль болох уян харимхай материалаар хийгдсэн байна.</p> <p>(з) Агаарын хөлөг хөөрч буух зурвасны хязгаарыг давах зайлшгүй шаардлагатай тохиолдолд аюулгүйн зурвасуудын гадаргуу нь эвдрэл гэмтэл учруулахааргүй байна.</p>	
<p>139.105. Навигацийн ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээний засвар, үйлчилгээ болон шалгалт</p> <p>(а) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь тухайн аэродромд суурилуулсан навигацийн ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээний засвар, үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-д шаардсан засвар, үйлчилгээний хөтөлбөрт дараах зүйл багтсан байх ёстой:</p> <p>(1) навигацийн ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ нь хэрэглэгчийг энэ Дүрэмд заасан холбогдох стандартын дагуу найдвартай, үнэн зөв чиглүүлэх мэдээллээр үргэлжлүүлэн хангаж байгааг бататгах журам;</p> <p>(2) тухайн хэрэглэгчийг үргэлжлүүлэн чиглүүлж чадахыг бататгах, гэрэлтүүлгийн системийн ажиллагаагүй байж болохыг зөвшөөрсөн гэрлийн тооны дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>(3) гэмтэлтэй, эсхүл ажиллагаагүй тэмдэг, тэмдэглэгээг яаралтай сэргээж ашиглалтад оруулах журам.</p>	<p>139.55. Хяналтын үзлэг шалгалт</p> <p>(а) Аэродромын гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагч нь ИНЕГ-аас дүрмийн шаардлагыг хангуулахаар явуулж буй сорил, төлөвлөгөөт болон гэнэтийн үзлэг шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлж өгнө.</p> <p>139.57. Хяналтын үзлэг шалгалтын хэлбэрүүд</p> <p>(а) Эхний үзлэг шалгалтыг ИНЕГ-аас шинээр гэрчилгээжих болон Аэродромын гэрчилгээг өөр этгээдэд шилжүүлэх тохиолдолд хийнэ.</p> <p>(б) Төлөвлөгөөт буюу үе шатны үзлэг шалгалтыг гэрчилгээжсэн аэродромын үйл ажиллагааны заавар, стандартын шаардлагыг хангах, иргэний нисэхийн багц дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд итгэлтэй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор, батлагдсан хуваарийн дагуу хийнэ. Энэ хэлбэрийн үзлэг шалгалтыг энэ дүрмээр тогтоосон хугацаанд хийх бөгөөд шалгалтын явцын талаарх тэмдэглэл, тайлан, байцаагчийн дүгнэлтийг хувийн хэрэгт хадгална.</p> <p>(в) Гэнэтийн болон нэмэлт үзлэг шалгалтыг дараах тохиолдолд хийнэ:</p> <p>1/ осол, зөрчил гарсан тохиолдолд, эсхүл мэдээллийн мөрөөр; эсхүл</p> <p>2/ хуваарьт үзлэгийн үр дүн, дүгнэлтэд үндэслэн; эсхүл</p> <p>3/ нислэгийн талбайд барилгын ажил явагдаж буй үед явцыг шалгах; эсхүл</p> <p>аэродромын байдал аэродромын стандарт болон зааварт нийцэж тохирч байгаа эсэхийг бататгах.</p>	<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон</p>
<p>139.107. Аэродром дээр хийгдэх ажил [Хүчингүй]</p>	<p>139.183. Нислэг үйлдэж буй аэродром дээр хийгдэх барилгын ажил, засвар үйлчилгээ</p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь аэродром дээр аливаа ажил,</p>	

засвар, үйлчилгээ хийхдээ агаарын хөлгийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдгийг бататгасан байна.

(б) Нислэг үйлдэж буй аэродром дээр барилгын ажил, засвар, үйлчилгээ хийгдэх талаар нисэх буудлын удирдлага, ажил гүйцэтгэгч талууд хамтран журам боловсруулж, түүнийгээ дагаж мөрдөнө.

(в) Аэродромд засвар үйлчилгээ хийгдэх үед аюулгүй ажиллагааг хангах талаар ИНЕГ-аас гаргасан Зөвлөмжийн цувралыг удирдамж болгож ажиллана.

-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон

139.109. Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө

Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

(1) 139.57-д шаардсан, гэрчилгээ эзэмшигчийн аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний дагуу аэродромын онцгой нөхцөлийн үед үүрэг, хариуцлага хүлээсэн бүх ажилтан өөрсдийн томилогдсон ажил үүргийн талаар ойлголттой бөгөөд зохих ёсоор сургалтад хамрагдсаныг бататгах;

(2) 139.57-д шаардсан аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний сорилтыг дараах аль нэг хэлбэрээр хийсэн байх:

(i) хоёр жилээс хэтрэхгүй давтамжтай хийдэг аэродромын онцгой нөхцөлийн бүрэн хэмжээний дасгал сургуулалт болон аэродромын онцгой нөхцөлийн бүрэн хэмжээний дасгал сургуулалтын үед илэрсэн үл тохирлыг залруулсныг бататгах зорилгоор аэродромын онцгой нөхцөлийн бүрэн хэмжээний дасгал сургуулалтуудын хооронд хийдэг онцгой нөхцөлийн тусгай дасгал сургуулалт; эсхүл

(ii) эхний жилээс эхлэн гурван жилийн хугацаанд хэсэгчилсэн сорилтыг хэд хэдэн удаа явуулсан үед аэродромын онцгой нөхцөлийн бүрэн хэмжээний дасгал сургуулалтыг анх хийснээс хойш гурван жилээс хэтрэхгүй хугацаанд явуулах;

(3) энэ хэсгийн (2)-т заасан дасгал сургуулалтын дараа тухайн төлөвлөгөөнд үнэлгээ хийх эсхүл онцгой нөхцөлийн дараа илэрсэн үл тохирлыг засах;

(4) хууль сахиулах байгууллага, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэгчид, аврах болон гал унтраах байгууллага, эмнэлгийн ажилтан болон эмнэлгийн байгууллага болон үндсэн түрээслэгчийг шаардлагатай тохиолдолд оролцуулан 139.57-д шаардсан аэродромын

онцгой нөхцөлийн төлөвлөгөөнд үүрэг хүлээж байгаа бүх байгууллага, хүмүүстэй хамтран зохицуулалт хийх.

139.111. Аврах болон гал унтраах үйл ажиллагааны шаардлага

(a) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд аэродромын гэрчилгээ эзэмшигч нь дараах нисэх онгоцоор үйл ажиллагаа гүйцэтгэх үед 139.61 болон 139.63-ын минимум шаардлагыг хангасан аврах болон гал унтраах хүчин чадлаар тухайн аэродромыг хангасан байх үүрэгтэй:

(1) зорчигч тээвэрлэх тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа 30-аас дээш зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоц; эсхүл

(2) тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэх онгоц нь:

(i) тухайн аэродромд буулт үйлдэхийн өмнөх нисэх онгоцны хөөрөлтийн цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром бол; эсхүл

(ii) тухайн аэродромоос хөөрөлт үйлдсэний дараах нисэх онгоцны буултын цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром бол.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, аэродромын гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд аврах болон гал унтраах хүчин чадлыг 139.61 болон 139.63-т заасан дээд категорид шаардсан минимумд хүртэл дээшлүүлэх үүрэгтэй, хэрэв:

(1) нисэх онгоцны хөдөлгөөн нэмэгдэж байгаа, эсхүл тухайн аэродромыг ашигладаг байгаа нисэх онгоцны маяг өөрчлөгдөж байгаа бол;

(2) нислэгийн тоо нэмэгдэх, эсхүл нисэх онгоцны маягт өөрчлөлт орох нь 139.59-д заасны дагуу аврах болон гал унтраах категорийг дээшлүүлж байгаа бол.

(c) Энэ зүйлийн (a) болон (b)-г үл харгалзан, аэродромын гэрчилгээ эзэмшигч нь дараах тохиолдолд аврах болон гал унтраах хүчин чадлыг тухайн аэродромыг ашиглах хамгийн өндөр үзүүлэлттэй нисэх онгоцонд тохирох аэродромын категорид шаардсан түвшнээс бага түвшин рүү бууруулж болно, хэрэв:

(1) тухайн аэродром нь 139.59-ийн дагуу аэродромын категорийг тогтоосон нисэх онгоцны үзүүлэлтээс бага үзүүлэлттэй нисэх онгоц ашиглахаар хязгаарлагдсан бол;

(2) 139.77-д шаардсан Ерөнхий зааварт, категори бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий хүмүүс, тэдгээрийн үйл ажиллагааны журам тусгагдсан бол;

(3) 139.77-д шаардсан Ерөнхий зааварт, тухайн аэродромын

-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон

-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон

аврах болон гал унтраах хүчин чадлыг бүхэлд нь хүчингүй болгох журам тусгагдсан бол.

- (d) Нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас тухайн мэдээллийг зарлан мэдэгдэх хүртэл аэродромын гэрчилгээ эзэмшигчийг энэ зүйлийн (c)-д заасан аврах болон гал унтраах хүчин чадлыг бууруулахыг хориглоно.
- (e) Энэ зүйлийн (a)-д аврах болон гал унтраах хүчин чадлаар хангахыг шаардсан аэродромын гэрчилгээ эзэмшигч нь тээврийн хэрэгсэл бүр ашиглалтын хугацаандаа хариу үзүүлэх хугацааг хангах, төхөөрөмжийн үр дүнтэй ажиллагааг бататгахын тулд аврах болон гал унтраах тээврийн хэрэгсэл, эсхүл тээврийн хэрэгслийн урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээний системийг тогтоосон байх үүрэгтэй.
- (f) Хэрэв энэ зүйлд шаардсан аврах болон гал унтраах тээврийн хэрэгсэл нь гэрчилгээ эзэмшигч 139.67-д шаардсан хариу арга хэмжээ авах чадвараа алдах хүртэл ажиллагаагүй болсон бол аэродромын гэрчилгээ эзэмшигч нь дараах арга хэмжээг авах үүрэгтэй:
- (1) ажиллагаагүй аврах болон гал унтраах тээврийн хэрэгслийг гэрчилгээ эзэмшигчийн хариу арга хэмжээ авах чадварыг хангах тээврийн хэрэгслээр нэн даруй солих;
- (2) хэрэв энэ зүйлийн (f)(1)-т шаардсан тээврийн хэрэгслийг нэн даруй солих боломжгүй бол, 139.123 -д шаардсан мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй;
- (3) хэрэв 139.67-д шаардсан хариу арга хэмжээ авах чадвар нь шаардлагатай тээврийн хэрэгсэл ажиллагаагүй болсноос хойш 72 цагийн дотор эргэж хэвийн байдалд ороогүй бол аэродромын агаарын тээврийн үйл ажиллагааг ажиллагаатай хэвээр үлдсэн аврах болон гал унтраах тээврийн хэрэгсэлтэй хамааралтайгаар тухайн аэродромын категорид нийцсэн нисэх онгоцоор хязгаарлах.
- (g) Энэ зүйлийн (a)-д аврах болон гал унтраах хүчин чадлаар хангахыг шаардсан аэродромын гэрчилгээ эзэмшигч нь энэ Дүрэмд шаардсан аврах болон гал унтраах төхөөрөмж болон үр дүнтэй үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэшсэн хангалттай тооны ажилтантайгаар энэ зүйлийн (a)-д заасан үйл ажиллагааны үед агаарын хөлгийн онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах үүрэгтэй.

139.113. Аэродромын агаарын хөлгийн хөдөлгөөний зохицуулалт

Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь Дарга аюулгүй байдлын

-Amend.10-аар нэмж

<p>ашиг сонирхлын үүднээс шаардсан бол аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ эсхүл аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аль аль нь байхыг бататгана.</p>		<p>орсон</p>
<p>139.115. Апрон зохицуулалтын үйлчилгээ (а) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн хөдөлгөөний нягтрал болон үйл ажиллагааны нөхцөл нь апрон үйлчилгээ шаардаж байгаа бол аэродромыг тухайн зохицуулалтын үйлчилгээгээр хангасан болохыг бататгана. (б) Апрон зохицуулалтын үйлчилгээтэй аэродромын гэрчилгээний эрхийн хүрээнд ажиллаж байгаа аэродромын үйл ажиллагаанд аэродромын удирдлагын үйлчилгээ хийгдэж байгаа ба тухайн аэродромын удирдлагын үйлчилгээ нь апрон зохицуулалтын үйлчилгээнд оролцдоггүй бол тухайн гэрчилгээ эзэмшигч нь аэродромын удирдлагын болон апрон зохицуулалтын үйлчилгээний хооронд агаарын хөлгийн шилжүүлэлтийг хийдэг байна.</p>		<p>-Amend.10-аар нэмж орсон</p>
<p>139.117. Аэродромын үзлэгийн хөтөлбөр <u>Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:</u> (1) аэродром, түүний <u>байгууламж нь</u> энэ Дүрэмд заасны дагуу засвар үйлчилгээ хийгдсэнийг бататгах аэродромын үзлэгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх; (2) аэродромын үзлэг хийхэд ашиглах тохиромжтой багаж, төхөөрөмжөөр хангах; (3) аэродромын үзлэгийг зохих ёсоор сургалтад хамрагдсан ажилтан гүйцэтгэснийг бататгах журмыг тогтоох; <u>(4) аэродромын үзлэгийн үед тэмдэглэгдсэн аюултай нөхцөлийг шуурхай засаж залруулсныг бататгах мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх.</u></p>	<p>139.179. Үзлэг <u>шалгалтын</u> хөтөлбөр (а) Гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн биелэлтийг хянах аэродромын үзлэгийн хөтөлбөртэй байх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгасан байна: 1/ аэродромын үзлэгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах багаж, тоног төхөөрөмж, <u>гадаргуугийн үрэлтийн коэффициент хэмжигч, шороон зурвасны даац хэмжигч, налуу, өндөр, зай хэмжигч зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байна;</u> 2/ аэродромын үзлэгийг дадлага туршлагатай, сургалтанд хамрагдсан мэргэжлийн ажилтан хийх тухай баталгаажуулсан журамтай байна; <u>3/ үзлэг хийх эрх бүхий этгээд, ээлжийн болон ашиглалтын инженер нь доорх сургалт зааварчилгаанд үе шаттайгаар /анхан болон давтан/ хамрагдсан байна. Үүнд:</u> <u>3.1. нисэх бүүдлын ерөнхий төлөвлөгөө, аэродромын тэмдэг дохио, гэрэлтүүлэг;</u> <u>3.2. нисэх бүүдлын онцгой байдлын төлөвлөгөө;</u> <u>3.3. нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагад мэдээ дамжуулах, хүлээн авах журам;</u> <u>3.4. аэродромд бэлэн бус аюултай байдал үүсэх үед ажиллах журам;</u></p>	<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон</p>

- 3.5. амьтан, шувууны аюулаас сэргийлэх талаар;
- 3.6. нислэгийн зурвас, талбайд машин механизм, тоног төхөөрөмж ажиллах, хөдлөх журам;
- 3.7. аэродромын зуны болон өвлийн ашиглалт, арчлалт.

4/ үзлэгийн үр дүнд илэрсэн алдаа дутагдлыг зассаныг бататгах мэдээллийн системтэй байна.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь доорх хуваарийн дагуу үзлэг хийх хөтөлбөртэй байна:

- 1/ өдөр тутмын үзлэг;
- 2/ аэродромд барилгын ажил явагдаж буй нөхцөлд;
- 3/ цаг уурын тааламжгүй нөхцөл үүссэн үед;
- 4/ осол, зөрчил гарсан үед.

(в) Түр зөвшөөрөл эзэмшигч нь нислэгийн зурвасны үзлэгийн журамтай байна.

139.119. Газрын үйлчилгээний тээврийн хэрэгсэл

(а) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь тухайн аэродромын үйл ажиллагааны бүсэд газрын үйлчилгээний тээврийн хэрэгсэл нэвтрэхийг хязгаарлах, хянах журмыг тогтоох үүрэгтэй.

(б) Энэ зүйлийн (а)-д шаардсан журмын дагуу, тухайн аэродромын үйл ажиллагааны бүсэд нэвтрэх газрын үйлчилгээний тээврийн хэрэгсэл нь аэродром, эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагаанд шаардлагатай тээврийн хэрэгслээр хязгаарлагдах ёстой.

(с) Тухайн аэродромын үйл ажиллагаанд аэродромын удирдлагын үйлчилгээ багтдаг бол энэ зүйлийн (а)-д шаардсан журамд дараах үйл ажиллагаа багтсан байх ёстой:

(1) газрын үйлчилгээний тээврийн хэрэгсэл үйл ажиллагааны бүсэд аюулгүй, журмын дагуу нэвтрэх, болон ажиллах нөхцөлөөр хангах;

(2) тухайн аэродромын маневрын талбайд ажиллаж байгаа газрын үйлчилгээний тээврийн хэрэгслийг дараах байдлаар удирддаг байхыг шаардах:

(i) тээврийн хэрэгсэл болон аэродромын удирдлагын үйлчилгээний хоорондын хоёр талын радио холбооны хэрэгслээр; эсхүл

(ii) хэрэв тээврийн хэрэгсэл нь радио холбоогүй бол, аэродромын удирдлагын үйлчилгээтэй хоёр талын холбоо бүхий тээврийн хэрэгслээр хамт дагуулах; эсхүл

139.181. Газрын үйлчилгээний машин механизм

(а) Гэрчилгээ эзэмшигч нь зөвхөн аэродром болон агаарын хөлөгт үйлчилдэг газрын үйлчилгээний машин механизмыг аэродромын хөдөлгөөний бүсэд оруулах бөгөөд энэ ажиллагааг тусгайлан баталгаажуулсан журмаар зохицуулна.

(б) Газрын үйлчилгээний машин, механизмыг аэродром, талбайд нэвтрэх, аюулгүй ажиллагааг хангаж ажиллуулах, тэдгээрийг дараах тоноглолын тусламжтайгаар удирдаж байхаар журамд тусгасан байна:

1/ хоёр талын радио холбоо (газрын үйлчилгээний машин механизм болон нислэгийн удирдагч)-той байна; эсхүл

2/ газрын үйлчилгээний машин механизм нь радио холбоогоор тоноглогдоогүй тохиолдолд ажиллагаанд хамтран оролцож байгаа машин механизм нь хоёр талын радио холбоогоор тоноглогдсон байна; эсхүл

-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон

<p>(iii) хэрэв хоёр талын радио холбоо, эсвэл дагалдах тээврийн хэрэгслийг ашиглах боломжгүй бол, тухайн тээврийн хэрэгслийг удирдах зорилгоор тэмдэг, дохио, эсхүл хамгаалалт ашиглах тохирсон арга хэмжээ авах.</p> <p>(d) Аэродромын удирдлагын үйлчилгээ нь тухайн аэродромын үйл ажиллагаанд багтдаггүй тохиолдолд, энэ зүйлийн (а)-д шаардсан журам нь аэродромын үйл ажиллагааны бүсэд ажиллаж байгаа газрын үйлчилгээний тээврийн хэрэгслийг тэмдэг, эсхүл урьдчилан тохиролцсон дохиогоор удирдах нөхцөлөөр хангах ёстой.</p> <p>(e) Энэ зүйлийн (а)-д шаардсан журам нь, тухайн аэродромын аливаа хэсэгт уг газрын үйлчилгээний тээврийн хэрэгслийг ажиллуулах, аэродромын үйл ажиллагааны бүсэд нэвтрэх эрхтэй, ажилтан, түрээслэгч, эсхүл гэрээт гүйцэтгэгч нь гэрчилгээ эзэмшигчийн тогтоосон газрын үйлчилгээний тээврийн хэрэгслийн үйл ажиллагааны журмыг мэддэг, биелүүлдэг байхыг бататгах ёстой.</p>	<p>3/ хоёр талын радио холбоогоор тоноглох боломжгүй тохиолдолд машин механизмыг удирдах тусгай тэмдэг, тэмдэглэгээ болон дуут дохиогоор тоноглосон байна.</p> <p>(в) Аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлагагүй тохиолдолд аэродромын талбайд ажиллах газрын үйлчилгээний машин, механизмыг зохих тэмдэг, дохиогоор удирдах, тухайн ажиллагааг удирдаж буй этгээд машин, механизмын хооронд радио холбоотой байна.</p> <p>(г) Аэродромын хамгаалалттай бүсэд түр болон удаан хугацаагаар нэвтрэх эрх авсан аливаа этгээд тухайн бүсэд машин техник ашиглах бол аэродромын гэрчилгээ эзэмшигчээс гаргасан газрын үйлчилгээний машин, механизмыг аэродромын хамгаалалттай бүсэд ажиллуулах журамтай урьдчилан танилцаж, түүнийг дагаж мөрдөнө.</p>	
<p>139.121. Нислэгийн Хөдөлгөөний Үйлчилгээний байгууламж болон навигацийн туслах төхөөрөмжийг хамгаалах</p> <p>Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) аэродромын цахилгааны төхөөрөмж, эсхүл навигацийн ил харааны туслах төхөөрөмж, эсхүл НХҮ-ний байгууламжийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болох тухайн аэродром дахь, эсхүл гэрчилгээ эзэмшигчийн хяналтад байдаг аэродром орчмын газар дээрх барилга угсралтын, эсхүл бусад ажиллагаанаас сэргийлэх;</p> <p>(2) гэрчилгээ эзэмшигчийн эрх мэдлийн хүрээнд байх аэродромын цахилгааны төхөөрөмж, эсхүл навигацийн ил харааны туслах төхөөрөмж, эсхүл НХҮ-ний байгууламжид тасалдал, доголдол гарахаас сэргийлэх.</p>	<p>139.191 Навигацийн тоноглолыг хамгаалах.</p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь нисэх буудлын, цамхагийн нислэгийн удирдагчийн, түүнчлэн навигацийн тоног төхөөрөмжийн харагдац, хэвийн үйл ажиллагаанд саад учруулах аливаа барилга байгууламж барихыг хориглох бөгөөд цамхагийн нислэгийн удирдагчийн болон навигацийн тоног төхөөрөмжийг эвдлэх, гэмтээх, хулгайлахаас хамгаална.</p>	<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон</p>
<p>139.123. Аэродромын нөхцөлийг зарлан мэдээлэх</p> <p>Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь 139.73-д шаардсан журмын дагуу агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж болох аэродромын үйл ажиллагааны нөхцөлийг цаг алдалгүй NOTAM-аар зарлуулахаар нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад мэдээлэх үүрэгтэй.</p>		<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон</p>
<p>139.125. Аюултай нөхцөл</p> <p>Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь, хэрэв тухайн аэродромын аль нэг хэсэгт аюултай нөхцөл үүссэн үед агаарын хөлгийн үйл ажиллагааг хязгаарласан, эсхүл хориглосныг бататгах журмыг тогтоох үүрэгтэй.</p>		<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон</p>
<p>139.127. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт</p>	<p>139.65. Гэрчилгээнд өөрчлөлт оруулах</p>	

- (a) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавар нь аэродромын тодорхойлолт болон түүний холбогдох төлөвлөгөө, хөтөлбөр, үйлчилгээ, тогтолцоо, журам болон байгууламж хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар нэмэлт өөрчлөлт хийгдсэнийг бататгах үүрэгтэй.
- (b) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт хийсэн нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгааг болон өөрийн Ерөнхий зааварт заасан тухайн нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдсөнийг бататгах үүрэгтэй.
- (c) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа, нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргад хадгалуулахаар цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.
- (d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхээс өмнө Даргаас урьдчилан зөвшөөрөл авсан байх шаардлагатай:
 - (1) Гүйцэтгэх захирлыг өөрчлөх;
 - (2) нэр заагдсан удирдах ажилтныг өөрчлөх;
 - (3) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог өөрчлөх, хэрэв тухайн өөрчлөлт нь бодит өөрчлөлт бол.
- (e) Дарга энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх нөхцөлийг тодорхойлж болно.
- (f) Гэрчилгээ эзэмшигч, энэ зүйлийн (e)-гийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.
- (g) Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь тухайн аэродромын гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардсан бол, гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.
- (h) Нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигч Ерөнхий заавартаа оруулах үүрэгтэй.

139.129. Аюулгүй байдлын үзлэг шалгалт болон аудит [Хүчингүй]

- (a) ИНЕГ-ын дарга дараах нөхцөл, байдал үүссэн тохиолдолд Аэродромын гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй :
 - 1/ аэродромын эзэмшигч, удирдлага, зохион байгуулалт өөрчлөгдсөн;
 - 2/ аэродромын үйл ажиллагаа, ашиглалтын журамд өөрчлөлт орсон;
 - 3/ аэродромын эдэлбэр газар, хашаа хамгаалалт өөрчлөгдсөн;
 - 4/ гэрчилгээ эзэмшигч хүсэлт гаргасан.

-Amend.10-аар нэмж орсон

139.189. Аюулгүй байдлын үзлэг, хяналт

- (a) Аэродром болон агаарын навигацийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг ИНД 140-ийн дагуу гэрчилгээжсэн байгууллага, эсхүл уг дүрмийн шаардлагад нийцсэн байгууллага гэрээгээр гүйцэтгэнэ.
- (б) Энэ зүйлийн (a)-д заасан байгууллага нь цахилгаан эрчим хүч, холбоо, хамгаалалтын хашааны суваг, гарц, цэвэр усны хангамж зэрэгт аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлнэ.
- (в) Цахилгааны тэжээл тасарсан үед болон шөнийн гэрэл

суултын системийн ердийн ажиллагааг тасралтгүй хангах нөөц цахилгаан үүсгүүртэй байна.

(г) Гэрчилгээ эзэмшигч нь зорчигч, тэдгээрийн гар тээш болон тээшинд аюулгүй байдлын үзлэг хийх, үзлэгт хамрагдсан зорчигчдыг тусгаарлах, үзлэгийн дараах болон үзлэгт хамрагдсан зорчигчдыг нисэн ирж байгаа болон дамжин өнгөрөх зорчигчдоос тусгаарлах бүсүүдийг тус тус бэлтгэнэ.

(д) Гэрчилгээ эзэмшигч нь дараах эд зүйлсийг аэродромын хориотой бүс болон агаарын хөлөгт нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна. Үүнд:

1/ бүх төрлийн галт зэвсэг;

2/ бүх төрлийн мэс, багаж, зэвсэг; бүх төрлийн сүм;

3/ агаарын хөлөгт болон зорчигчдод аюул учруулахуйц бүх төрлийн тэсэрч дэлбэрэх бодис, тэдгээрийн эд анги.

139.131. Нисэхийн судалгаа

(a) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаандаа мониторинг хийх бөгөөд нөлөө бүхий өөрчлөлт, эсхүл аэродромын үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж болох нөлөө бүхий өөрчлөлтөд нисэхийн судалгаа хийх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан нөлөө бүхий өөрчлөлтөд дараах зүйл багтана:

(1) аэродромын агаарын хөлгийн хөдөлгөөний огцом өсөлт; эсхүл

(2) агаарын хөлгийн үйл ажиллагааны төрлийн нөлөө бүхий өөрчлөлт; эсхүл

(3) тухайн аэродромын бодит үзүүлэлтийн нөлөө бүхий өөрчлөлт; эсхүл

(4) тухайн аэродром, эсхүл түүний ойролцоох осол, эсхүл зөрчлийн огцом өсөлт; эсхүл

(5) тухайн аэродром дээрх агаарын хөлгийн хөдөлгөөний жилийн төлөв нь үргэлжилсэн 3 жилийн хугацаанд дараах хэмжээнээс хэтэрсэн бол:

(i) 8000, эсхүл түүнээс олон VFR болон IFR-ийн нийт хөдөлгөөн; эсхүл

(ii) 1500, эсхүл түүнээс олон IFR-ийн хөдөлгөөн; эсхүл

(iii) 12 000, эсхүл түүнээс олон VFR болон IFR-ийн нийт хөдөлгөөн, үүний 1800, эсхүл түүнээс олон хөдөлгөөн нь IFR-ийн, эсхүл

(iv) 3000, эсхүл түүнээс олон IFR-ийн хөдөлгөөн; эсхүл

(v) 20 000, эсхүл түүнээс олон VFR болон IFR-ийн нийт

-Amend.10-аар нэмж орсон

<p>хөдөлгөөн.</p> <p>(с) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь нисэхийн судалгаа хийж дууссаны дараа, дараах ажлыг нэн даруй гүйцэтгэх үүрэгтэй:</p> <p>(1) тухайн аэродромын үйл ажиллагаанд үнэлгээ хийж, хэрэв шаардлагатай бол нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай өөрчлөлтийг Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий зааварт оруулах;</p> <p>(2) тухайн нисэхийн судалгааны үр дүнг Даргад хүргүүлэх.</p> <p>(d) Хэрэв боломжтой бол аэродромын гэрчилгээ эзэмшигч нь нөлөө бүхий өөрчлөлт орохоос өмнө нисэхийн судалгаа хийх үүрэгтэй.</p> <p>(e) Хэрэв аэродромын гэрчилгээ эзэмшигчид нөлөө бүхий өөрчлөлт орохоос өмнө нисэхийн судалгаа хийх боломж байхгүй бол, тухайн өөрчлөлтийн дараа гэрчилгээ эзэмшигч цаг алдалгүй нисэхийн судалгаа хийх үүрэгтэй.</p>	<p>139.105. Аэродромын зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах</p> <p>(a) ИНЕГ-ын дарга Аэродромын зааварт аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу өөрийн санаачилгаар өөрчлөлт оруулж болно.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигч Аэродромын зааварт өөрчлөлт оруулах саналаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болох хугацаанаас 30 хоногийн өмнө ИНЕГ139/03 маягтын дагуу ИНЕГ-ын даргад ирүүлж, нэмэлт өөрчлөлтийг хянуулна.</p> <p>(в) Зааварт ИНЕГ-ын даргын санаачилгаар өөрчлөлт оруулж байгаа тохиолдолд түүнийг хүчинтэй болох хугацаанаас 7 хоногийн өмнө гэрчилгээ эзэмшигчид мэдэгдэнэ.</p>	
<p>D Бүлэг - Аэродромын аюулгүйн хамгаалалт</p>	<p>Г БҮЛЭГ. АЭРОДРОМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</p>	
<p>139.203. Аюулгүйн хамгаалалттай аэродромд тавих шаардлага</p> <p>Хашаа хаалтад тавих шаардлага</p> <p>(a) <u>Аюулгүйн хамгаалалттай</u> аэродромын гэрчилгээ эзэмшигч нь <u>139.69-ийн</u> (Нийтийн хамгаалалт) шаардлагыг мөрдөхөөс гадна, тухайн аэродромын аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд санамсаргүй, зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэх болон санаатай зөвшөөрөлгүй нэвтрэх үйлдлийг зогсооход чиглэсэн харуул хамгаалалтаар хангах үүрэгтэй.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан харуул хамгаалалт нь:</p> <p>(1) нийтийн болон аюулгүйн хамгаалалттай бүсийн, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн хооронд тохирох цоожны систем, эсхүл хяналтын систем бүхий хашаа, хаалга болон бусад хаалтаас бүрдсэн байх;</p> <p>(2) аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтэрсэн хоолой, ус зайлуулах суваг, эсхүл туннелийн хяналтыг бататгасан байх ёстой.</p> <p>(c) Барилга болон энэ зүйлийн (b)(1)-д шаардсан хаалтын өндөр нь хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалтын бүс рүү нэвтрэхээс хамгаалсан үр дүнтэй арга хэмжээ авах орчин тойрны газар нутгийн байршлыг тооцсон байх ёстой ба өндрийг 2440 мм-ээс намгүй өндөртэй байхаар барих ёстой.</p> <p>Бусад шаардлага</p> <p>(d) Аюулгүйн хамгаалалттай аэродромын гэрчилгээ эзэмшигч</p>	<p>139.187. Аэродромын хамгаалагдсан бүсэд тавигдах шаардлага</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь хамгаалагдсан бүсэд зөвшөөрөлгүй хүн, мал, амьтан, тээврийн хэрэгсэл нэвтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн болон аюулгүй байдлын бүсүүдийг заагласан, зохих хяналтын системээр тоноглогдсон хаалга, гарц бүхий хашаа хамгаалалт хийнэ. Хамгаалалтын хашааны өндөр нь:</p> <p>1/ I ангиллын аэродромын хувьд 220 см;</p> <p>2/ II-III ангиллын аэродромын хувьд 180 см-ээс багагүй;</p> <p>IV ангиллын аэродромын хувьд аюулгүй байдлыг хангах үүднээс хашаа хамгаалалт хийж болно.</p>	<p>-Amend.10-аар нэмж орсон</p>

нь дараах үүрэгтэй:

- (1) хууль бус үйлдэлд өртсөн болох нь тогтоогдсон, эсхүл өртсөн гэж үзэж байгаа, эсхүл аюулгүйн хамгаалалтын бусад шалтгаанаар аэродромын хэвийн үйл ажиллагаанаас тусгаарлах зорилгоор, тусгаарлагдсан агаарын хөлгийг зогсоох байршлыг тухайн аэродромд тогтоох;
- (2) зорчигч тээвэрлэх агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа 30-аас гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоц шөнийн цагаар ашигладаг аэродромын зогсоолын талбайг гэрэлтүүлгээр ханган байнгын ажиллагаатай байлгах ба үндсэн гэрэлтүүлгийн систем татгалзсан үед онцгой нөхцөлийн гэрэлтүүлгээр хангах;
- (3) шөнийн цагаар ашиглах аэродромд зориулан тогтоосон тусгаарлагдсан агаарын хөлгийн зогсоолын бүсийг гэрэлтүүлгээр хангах, эсхүл 30 минутын турш ажиллах боломжтой зөөврийн гэрэлтүүлэгтэй байх;
- (4) зорчигч, багийн гишүүд болон тээшинд аюулгүй байдлын үзлэг хийх зорилгоор тухайн аэродромд дараах бүсийг тогтоох:
 - (i) агаарын хөлөгт суухаас өмнө, олон улсын нислэгийн зорчигч, багийн гишүүд болон тээшинд аюулгүй байдлын үзлэг хийх бүс;
 - (ii) аюулгүй байдлын үзлэгээр орсон олон улсын нислэгийн зорчигч, багийн гишүүд, зөвшөөрөгдөөгүй эд зүйлс, эсхүл аюулгүй байдлын үзлэгээр ороогүй хүмүүстэй харьцахаас сэргийлсэн үзлэгийн дараах бүс;
 - (iii) ирж байгаа, дамжин өнгөрч байгаа болон дамжин суух зорчигч, багийн гишүүдийг аюулгүй байдлын үзлэгт хамрагдсан этгээдтэй харьцахаас сэргийлж, олон улсын нислэгээс буух явцад нь ирж байгаа зорчигч болон багийн гишүүдийг явах зорчигч болон багийн гишүүдээс тусгаарлах бүс;
- (4A) Сайд, эсхүл Дарга шаардлагатай гэж үзвэл, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс рүү нэвтэрч байгаа болон тухайн бүсэд байгаа хүмүүс, эд зүйлс, бодис, тээврийн хэрэгсэлд аюулгүй байдлын үзлэг болон нэгжлэг хийх бүсийг тогтоох;
- (5) аюулгүйн хамгаалалтын заналхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах тохиолдолд Сайд, эсхүл Дарга шаардлагатай гэж үзвэл, энэ зүйлийн (d)(4)-т шаардсан олон улсын болон орон нутгийн нислэгийн зорчигч,

(e) **Тусгаарлагдсан агаарын хөлгийн зогсоолыг тодорхой байршилд сонгож, 30 минутын турш тасралтгүй хангах зөөврийн буюу байнгын гэрэлтүүлэгтэй байхаар бэлтгэнэ**

-Бусад шаардлага
Amend.3-аар шинээр
орсон

- багийн гишүүд болон тэдгээрийн тээшинд аюулгүй байдлын үзлэг хийх бүсийг тухайн аэродромд тогтоох;
- (6) үзлэгээр орсон зорчигчид ашиглах боломжтой газарт байрласан аэродромын зөвшөөрөгдсөн бүс нь аюулгүй байдлын үзлэгээр орсон этгээдэд дараах эд зүйлсийг дамжуулахаас сэргийлсэн нэвтрэх хяналтын хангалттай арга хэмжээ авах боломжтой байдлаар төлөвлөгдсөнийг бататгах:
- (i) галт зэвсэг; эсхүл
- (ii) бусад аюултай довтолгооны зэвсэг, эсхүл бүх төрлийн хэрэгсэл; эсхүл
- (iii) бүх төрлийн сум; эсхүл
- (iv) агаарын хөлгийн аюулгүй байдал, эсхүл агаарын хөлөг дэх хүмүүст аюул учруулахад ашиглаж болох тэсэрч дэлбэрэх, эсхүл хөнөөл учруулах бодис, эсхүл төхөөрөмж;
- (7) энэ зүйлийн (d)(4), (d)(4A), (d)(5) болон (d)(6)-д шаардсан бүх бүсийг зөвшөөрөлгүй этгээд тухайн бүсэд нэвтрэхээс сэргийлсэн нэвтрэх хяналтын хангалттай арга хэмжээ авах боломжтой байдлаар төлөвлөх;
- (8) гэрчилгээ эзэмшигчийн үндсэн ажилтан эсхүл гэрээгээр ажиллаж байгаа этгээд нь тэдний ажил үүрэгт хамааралтай аюулгүйн хамгаалалтын зохих түвшний мэдлэгтэй болохыг бататгах аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөр болон журмыг тогтоох;
- (9) тухайн эзэмшигчийн тогтоосон аюулгүйн хамгаалалтын журам болон тухайн аэродромын аюулгүйн хамгаалалттай холбоотой тушаал шийдвэрийн **зөрчил, болон түүний үл тохирлыг тодорхойлж Даргад мэдээлэх, арга хэмжээ авах журмыг тогтоох;**
- (10) цахилгаан хангамж, холбоо, цэвэр бохир усны хангамж зэрэг үйлчилгээг (эдгээрээр хязгаарлагдахгүй) нисэхийн үйл ажиллагааны эсрэг хууль бус үйлдэлд ашиглах эрсдэлийг багасгах зорилгоор эдгээрийн аюулгүй байдлыг хангах;
- (11) Дарга шаардсан тохиолдолд, тухайн аэродром доторх аюулгүйн хамгаалалттай бүсийн периметрт, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд тэмдэг байрлуулах;
- (12) дараах зүйлийг бататгах журмыг тогтоох:
- (i) зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл аюулгүйн

139.71 Зөрчил гаргасан, шаардлага биелүүлээгүй үед авах арга хэмжээ

- (a) Аэродромын үйл ажиллагаанд хийсэн хяналт, үзлэг шалгалтын үед илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор **ИНЕГ-аас тавьсан шаардлагыг үл биелүүлсэн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу харуцлага хүлээлгэнэ.**

<p>хамгаалалттай бүс рүү, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс рүү орохгүйг;</p> <p>(ii) аюулгүйн хамгаалалттай бүсэд, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд илрүүлсэн зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл, эсхүл сэжиг бүхий тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу шийдвэрлэх;</p> <p>(e) Энэ зүйлийн (d)(8)-д шаардсан сургалтын хөтөлбөр нь дараах зүйлийг багтаасан байх ёстой:</p> <p>(1) анхан шатны болон давтан сургалтын холбогдох үе шат;</p> <p>(2) хийгдэх сургалтад тохирох мэдлэгийн шалгалт, эсхүл ур чадварын үнэлгээ.</p> <p>(f) Аэродромын гэрчилгээ эзэмшигч, энэ зүйлийн (e)(1)-д шаардсан сургалтын үе шат нь дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1) Даргын хүлээн зөвшөөрөхүйц сэдвийн задаргааг багтаадаг байх;</p> <p>(2) гэрчилгээ эзэмшигчээс зөвшөөрөгдсөн этгээд боловсруулсан бөгөөд уялдаа холбоотой хэлбэрээр зохион байгуулдаг байх.</p> <p>(g) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь, энэ зүйлийн (d)(8)-ын дагуу сургалтад хамрагдах шаардлагатай этгээдийг сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын үе шатанд 3-аас дээшгүй жилийн давтамжтайгаар хамрагддаг байхыг бататгах үүрэгтэй:</p>		
<p>139.205. Аюулгүйн хамгаалалт тогтоогоогүй аэродромд тавих шаардлага</p> <p>(a) Аюулгүйн хамгаалалт тогтоогоогүй аэродромын гэрчилгээ эзэмшигч нь 139.69-ийн (Нийтийн хамгаалалт) шаардлагыг мөрдөхөөс гадна дараах үүрэгтэй:</p> <p>(1) тухайн аэродром дахь заналхийллийн эсрэг хариу арга хэмжээ авахыг Сайд, эсхүл Дарга шаардсан тохиолдолд, 139.203(d)(4) (хэрэв эдгээр шаардлага нь орон нутгийн зорчигч, багийн гишүүд болон тээшинд хамаардаг бол) болон 139.203(d)(4A)-д шаардсан аюулгүйн хамгаалалттай аэродромын гэрчилгээ эзэмшигчийн тухайн аэродромд тогтоох ёстой бүсэд хэрэгжүүлэх нөөц төлөвлөгөөтэй байх;</p> <p>(2) аюулгүйн хамгаалалттай аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн эзэмшигчийн гэрчилгээ эзэмшигчид тавих 139.203(d)(2), (3) болон (9)-ийг мөрдөх.</p> <p>(b) Зорчигч тээврийн хуваарьт агаарын тээврийн үйл</p>		<p>-Amend.10-аар нэмэлт өөрчлөлт орсон</p>

ажиллагаанд оролцож байгаа 19, эсхүл түүнээс дээш маягаар гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцонд үйлчилдэг, аюулгүйн хамгаалалт тогтоогоогүй аэродромын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

(1) нийт ажилтны аюулгүйн хамгаалалтын талаарх ойлголт, мэдээллийг хангах, бусад байгууллагад хангалттай мэдээлэл өгөхийг бататгах зорилгоор аюулгүйн хамгаалалтын талаар ойлголт, мэдлэгтэй хүмүүсээс бүрдсэн хэсгийг байгуулах;

(2) 12-оос доошгүй сарын давтамжтайгаар энэ хэсгийн (1)-ийн дагуу байгуулсан аюулгүйн хамгаалалтын хэсгийн хурлыг зарлан хуралдуулж, Даргалж, уулзалтын тэмдэглэл хөтлөх.

(c) Зорчигч тээврийн хуваарьт агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа 19, эсхүл түүнээс дээш маягаар гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцонд үйлчилдэг, аюулгүйн хамгаалалт тогтоогоогүй аэродромын гэрчилгээ эзэмшигч нь, түүний үндсэн ажилтан, эсхүл гэрээгээр ажиллаж байгаа этгээдийг тэдний ажил үүрэгт хамааралтай аюулгүйн хамгаалалтын зохих түвшний мэдлэгтэй болохыг бататгах аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөр болон журмыг тогтоох үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (c)-д шаардсан сургалтын хөтөлбөр нь дараах зүйлийг багтаасан байх ёстой:

(1) анхан шатны болон давтан сургалтын холбогдох үе шат;

(2) хийгдэх сургалтад тохирох мэдлэгийн шалгалт, эсхүл ур чадварын үнэлгээ.

(e) Аэродромын гэрчилгээ эзэмшигч, энэ зүйлийн (d)(1)-д шаардсан сургалтын хэсэг бүр нь дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

(1) Даргын хүлээн зөвшөөрөхүйц сэдвийн задаргааг багтаадаг байх;

(2) тухайн гэрчилгээ эзэмшигчээс зөвшөөрөгдсөн этгээд боловсруулсан бөгөөд уялдаа холбоотой хэлбэрээр зохион байгуулдаг байх.

(f) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь, сургалтад хамрагдах шаардлагатай этгээдийг сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын үе шатанд 3-аас дээшгүй жилийн давтамжтайгаар хамрагддаг байхыг бататгах үүрэгтэй.

(б) Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь **нислэгийн талбайд нэвтрэх, хөдөлгөөнтэй бүсэд тээврийн хэрэгсэл жолоодох, нислэгийн хөдөлгөөний байгууллагатай холбоо барих, талбайд ажиллах журам, нисэх буудлын дэд бүтцийн талаарх танилцуулга зэрэг шаардлагатай сэдвүүдээр шинээр ажилд орсон хүмүүст сургалт явуулахаас гадна давтан сургалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.**

(в) Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварын түвшинг тогтоох, давтан сургах **журам бүхий сургалтын хөтөлбөртэй байна.**

139.171. Аюултай бодис болон хортой материалыг хадгалах, ашиглах

	<p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь ачаа шуудан тээврийн үйл ажиллагаа явуулдаг тохиолдолд аюултай материал хадгалах, ашиглах, тээвэрлэх журам боловсруулж мөрдөх бөгөөд энэ журамд доорх зүйлүүдийг тусгасан байна:</p> <p>1/ аюултай материалыг ашиглах, хадгалах ажилд томилогдсон хариуцагчтай байна;</p> <p>2/ үйлдвэрлэгчээс буюу илгээгчээс гаргасан ачааг тээвэрлэх, хадгалах болон аюулгүй байдлыг нь баталгаажуулна; аюултай ачаа, материал хадгалах тусгайлан бэлтгэсэн өрөөг нисэх буудал дотор байгуулна.</p>	
	<p>139.177. Аэродромын бэлэн бус байдал</p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь тухайн аэродромд аюултай нөхцөл байдал үүссэн тохиолдолд нислэгийн үйл ажиллагааг хязгаарлах тухай журам боловсруулан, Үйл ажиллагааны заавартаа тусгасан байна.</p> <p>(б) Аэродромын аль нэг хэсэг үйл ажиллагаанд бэлэн бус байгаа тохиолдолд нислэгийн аливаа ажиллагааг эхлүүлж болохгүй гэдгийг дээрх журмаар бататгасан байна.</p>	
	<p>139.197. Ашиглагдаагүй болон барилгын ажил хийгдэж байгаа аэродромын хэсгийг тэмдэглэх</p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь барилгын ажил явагдаж байгаа болон ашиглагдаагүй нислэгийн талбайн хэсгийг тэмдэгжүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гэрэлтүүлнэ. Агаарын хөлгийн хөдөлгөөн, нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болох барилга байгууламж, төхөөрөмжийг тэмдэгжүүлнэ.</p> <p>(б) Шинээр барилгын, засварын ажил эхлэхээс өмнө газар доорх цахилгааны кабель, утас, холбоо мэдээллийн шугам сүлжээг гэмтээхээс урьдчилан сэргийлж зайлшгүй хийгдэх кабелийн хайлт, бусад ажлыг гүйцэтгэх журам боловсруулж мөрдөнө.</p>	
<p>Е Бүлэг - Нөөц</p>		
<p>Ү Бүлэг-UNICOM (нийтлэг холбоо) болон AWIB (аэродромын цаг уурын мэдээлэл дамжуулагч) үйлчилгээ</p>		
<p>139.351. UNICOM болон AWIB үйлчилгээний хангалт</p> <p>(а) Аливаа этгээд нь дараах үйлдэл хийхгүй байх үүрэгтэй: (1) энэ Бүлгийн дагуу хангадаг болон ажиллуулдаг байхаас бусад тохиолдолд UNICOM-ийн үйлчилгээгээр хангах</p>		

<p>эсхүл ажиллуулах;</p> <p>(2) энэ Бүлгийн дагуу UNICOM болон AWIB үйлчилгээгээр хангадаг болон ажиллуулдаг байхаас бусад тохиолдолд НХҮ-тэй холбоогүй нисэхийн үйл ажиллагааг дэмжих аэродромын мэдээлэл, эсхүл цаг агаарын мэдээллийг дамжуулах.</p> <p>(b) Энэ Бүлэг нь аливаа этгээдийг ИНД-174.6-гийн дагуу цаг агаарын үндсэн мэдээгээр хангах үүргээс чөлөөлөхгүй.</p> <p>(c) Бие даасан аэродром нь, нэгээс олон UNICOM, эсхүл нэгээс олон AWIB үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлдэггүй байх үүрэгтэй.</p>		<p>-Amend.10-аар нэмэгдсэн</p>
<p>139.353. UNICOM болон AWIB үйлчилгээний шаардлага</p> <p>(a) UNICOM, эсхүл AWIB үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) ИНД-171.17-гийн дагуу дуудлага нэр авахаар Даргад хүсэлт гаргах;</p> <p>(2) Харилцаа холбооны тухай хуулийн дагуу радио аппаратад олгодог холбооны давтамжийн зөвшөөрөл авах хүсэлт гаргах;</p> <p>(3) тухайн үйлчилгээг үзүүлэхээр төлөвлөж байгаа аэродромын үйл ажиллагаа эрхлэгчээс бичгээр зөвшөөрөл авах.</p> <p>(b) UNICOM, эсхүл AWIB үйлчилгээгээр хангаж, эсхүл үйлчилгээ үзүүлж байгаа этгээд нь UNICOM, эсхүл AWIB үйлчилгээ нь дараах шаардлагын дагуу хийгддэг болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1) энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу олгосон дуудлагаар;</p> <p>(2) энэ зүйлийн (a)(2)-ын дагуу олгосон харилцаа холбооны давтамжийн зөвшөөрлийн хүрээнд;</p> <p>(3) ICAO-гийн Хавсралт 10, Vol. III, Part II Chapter 2-т заасан хамаарах системийн үзүүлэлтийн дагуу;</p> <p>(4) ICAO-гийн Хавсралт 10, Vol. II-т заасан хамаарах холбооны үйл ажиллагааны журмын дагуу.</p> <p>(c) UNICOM, эсхүл AWIB үйлчилгээгээр хангаж, эсхүл үйлчилгээ үзүүлж байгаа этгээд уг UNICOM, эсхүл AWIB үйлчилгээ нь дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1) алдаатай, эсхүл төөрөгдүүлэх мэдээлэл дамжуулдаггүй байх; эсхүл</p> <p>(2) мэдээ дамжуулах үед хүлээн авсан мэдээллийг өөрчилдөггүй байх; эсхүл</p> <p>(3) НХҮ, эсхүл цаг уурын үйлчилгээтэй зөрчилддөггүй байх.</p> <p>(d) UNICOM, эсхүл AWIB үйлчилгээгээр хангаж, эсхүл үйлчилгээ үзүүлж байгаа этгээд нь UNICOM, эсхүл AWIB үйлчилгээ нь дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:</p>		<p>-Amend.10-аар нэмэгдсэн</p>

(1) алдаатай, эсхүл төөрөгдүүлэх мэдээлэл дамжуулахгүйгээр гүйцэтгэдэг байх;

(2) хэрэв үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл үйлчилгээ үзүүлэгч алдаатай мэдээлэл дамжуулсныг сэжиглэх шалтгаан байгаа бол үйлчилгээг үргэлжлүүлэхийг зөвшөөрдөггүй байх;

(3) ИНД-174.6-гийн дагуу цаг агаарын үндсэн мэдээ дамжуулах шаардлагад нийцдэг байх.

(e) UNICOM үйлчилгээгээр хангаж, эсхүл үйлчилгээ үзүүлж байгаа этгээд нь дараах үйлчилгээг үзүүлж болно:

(1) ИНД-174.6-гийн дагуу цаг агаарын үндсэн мэдээ, эсхүл Хууль болон ИНД 174.6-гийн дагуу Даргын олгосон цаг уурын үйлчилгээ үзүүлэх гэрчилгээний эрхийн хүрээнд цаг уурын мэдээгээр хангах;

(2) цаг агаарын үндсэн мэдээ, эсхүл бусад холбогдох цаг уурын мэдээний аль нэгээс болон тухайн аэродромыг ашиглаж байгаа агаарын хөлгийн нисгэгчээс авсан салхины чиглэлийн мэдээлэлд тулгуурлан, ашиглахаар сонгосон ХБЗ-ыг мэдээллээр хангах;

(3) ИНД-119.73-ын дагуу агаарын тээвэрлэгчид тавих шаардлагыг хангасан нислэг дагах үйлчилгээ үзүүлэх;

(4) онцгой нөхцөлийн хариу арга хэмжээг эхлүүлэх;

(5) Аэродромын давтамжид хариулах хэсгийн (Aerodrome Frequency Response Unit) үүрэг гүйцэтгэх;

(6) нисгэгчийн хүсэлтээр, UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэж байгаа агаарын хөлгийн байрлалын талаарх мэдээллээр хангах;

(7) НМҮ-ээр ихэвчлэн нийтлэгддэг эсхүл мэдээлдэг аэродромын талаарх агаарын навигацитай холбоотой түр, эсхүл байнгын аюулын дэлгэрэнгүй мэдээг дамжуулах.

(f) UNICOM үйлчилгээгээр хангаж, эсхүл тухайн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд нь дараах үйлчилгээ үзүүлэхгүй байх үүрэгтэй:

(1) НХҮ-ээр хангах; эсхүл

(2) хөдөлгөөний мэдээллийг өгөх, эсхүл санал болгох; эсхүл

(3) хөдөлгөөний мэдээллийг эхлүүлэх, эсхүл олж авах.

(g) UNICOM үйлчилгээгээр хангаж байгаа этгээд нь энэ Бүлгийн дагуу UNICOM байгууламж ажиллуулж байгаа этгээдийн сургалт, ур чадварт үнэлгээ хийх болон эрх олгох журмыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

(h) AWIB үйлчилгээгээр хангаж, эсхүл үзүүлж байгаа этгээд нь дараах мэдээллээр хангаж болно:

- (1) салхины чиглэл, хүч;
- (2) алсын барааны харагдац;
- (3) үүлшил;
- (4) агаарын хэм;
- (5) далайн түвшний агаарын даралт, эсхүл Хууль болон ИНД-174-ын дагуу Даргын олгосон цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд QNH;
- (6) ИНД-174.6-гийн дагуу гаргасан цаг агаарын үндсэн мэдээ, эсхүл бусад холбогдох цаг уурын мэдээ болон тухайн аэродромыг ашиглаж байгаа агаарын хөлгийн нисгэгчээс авсан салхины чиглэлийн мэдээлэлд тулгуурлан, ашиглахаар сонгосон ХБЗ;
- (7) тухайн аэродромыг ашиглаж байгаа агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой хөдөлгөөний мэдээллээс бусад үйл ажиллагаа.

139.355. UNICOM үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага

UNICOM үйлчилгээ үзүүлж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) хувийн нисгэгчийн үнэмлэхний, эсхүл түүнтэй дүйцэх баримт бичигт тавих нислэгийн радио холбооны шаардлагын түвшин хүртэлх сургалтад хамрагдаж, ур чадварын үнэлгээ хийлгэсэн байх;
- (2) үзүүлж байгаа үйлчилгээний шаардлагад нийцэх сургалтад хамрагдаж, ур чадварын үнэлгээ хийлгэсэн байх;
- (3) тухайн үйлчилгээг үзүүлэх зөвшөөрлийн хамрах хүрээг нотлох баримтыг бичгээр олгосон байх.

139.357. UNICOM, эсхүл AWIB үйлчилгээний мэдээллийг зарлах

UNICOM, эсхүл AWIB үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа этгээд нь тухайн үйлчилгээг эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө Монгол Улсын AIP-д зарлуулахаар нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад дараах мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй:

- (1) тухайн үйлчилгээний байрлал, дуудлага, радио долгионы давтамж;
- (2) тухайн аэродромын эсхүл үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа аэродромын тодорхойлолт;
- (3) үйл ажиллагаа гүйцэтгэх цаг;
- (4) үзүүлж байгаа үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- (5) үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл;
- (6) дараах дэлгэрэнгүй мэдээлэл:

-Amend.10-аар
нэмэгдсэн

-Amend.10-аар
нэмэгдсэн

<p>(i) үйлчилгээ үзүүлэгчийн нэр, шуудангийн хаяг, хэрэв байгаа бол электрон шуудан, утас, факсын дугаар;</p> <p>(ii) шаардлагатай байж болох NOTAM мэдээ дамжуулах хүсэлт болон хэвлэн нийтэлсэн мэдээллийн өөрчлөлтийг хариуцсан этгээдийн нэр, утасны дугаар, шуудангийн хаяг болон хэрэв байгаа бол электрон шуудан, утас, факсын дугаар.</p>		
<p>139.359. Үйлчилгээний шилжилтийн зохицуулалт [Хүчингүй]</p>		
<p>G Бүлэг-Хязгаарлагдмал аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх шаардлага</p>		
<p>139.401. Ажилтанд тавих шаардлага</p> <p>(a) Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:</p> <p>(1) Гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон дараах удирдах ажилтан:</p> <p>(i) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу хийж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй;</p> <p>(ii) хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартыг хангаж байгааг бататгах үүрэг хариуцлага хүлээх;</p> <p>(2) нисэх буудлын менежерээр томилогдсон удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд:</p> <p>(i) тухайн аэродром болон түүний үйл ажиллагаа А, G болон Н Бүлгийн шаардлагыг хангаж байгааг бататгах үүрэг хариуцлага хүлээх;</p> <p>(ia) 139.409-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны үүрэг хариуцлага хүлээх;</p> <p>(ii) хэрэв удирдах ажилтан нь Гүйцэтгэх захирлаас өөр ажилтан бол, Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх;</p> <p>(3) А, G болон Н Бүлгийн шаардлагын дагуу, тухайн аэродром, түүний үйлчилгээ болон байгууламжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх хангалттай тооны ажилтан.</p> <p>(aa) Энэ зүйлийн (a)(2)(ia)-д заасан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвар, туршлагаа нотлох үүрэгтэй.</p> <p>(b) Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт</p>		<p>-Amend.12-оор шинээр орсон</p>

<p>гаргагч нь тухайн аэродром, түүний үйлчилгээ болон байгууламжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай ажилтны ур чадварт суурь үнэлгээ хийх ба түүнийг хадгалах журмыг тогтоох үүрэгтэй.</p> <p>(с) Энэ зүйлийн (а)(2)-т заасан Гүйцэтгэх захирал болон удирдах ажилтны үүргийг нэг хүн гүйцэтгэж болно.</p>		
<p>139.403. Аэродромын хязгаарлалт Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, хэрэв аэродром дээрх агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд зайлшгүй шаардлагатай бол, тухайн аэродромын төлөвлөлт, эсхүл байгууламж, эсхүл үзүүлж байгаа үйлчилгээнээс үүсэх холбогдох хязгаарлалтыг тухайн аэродромын ашиглалтад тогтоох үүрэгтэй.</p>		
<p>139.405. Нийтийн хамгаалалт Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн аэродромд дараах үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> (1) хөдөлгөөнт бүс рүү мал, амьтан санаандгүй нэвтрэхээс сэргийлэх; (2) зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгсэл аэродромын үйл ажиллагааны бүсэд нэвтрэн орохоос хамгаалах; (3) агаарын хөлгийн үйл ажиллагаанаас хүн болон өмч хөрөнгийг боломжит хэлбэрээр хамгаалах. 		
<p>139.407. Аэродромын өгөгдөл болон мэдээллийг зарлан мэдээлэх Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад дараах зүйлийг мэдэгдэх журмыг тогтоох үүрэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> (1) аэродромын өгөгдөл болон мэдээлэл; (2) 139.403-д заасны дагуу тухайн аэродромын ашиглалтад тогтоосон хязгаарлалт; (3) тухайн аэродромын ашиглалтад нөлөөлөх өөрчлөлтийг цаг алдалгүй. 		
<p>139.409. Аюулгүй байдлын удирдлага Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрдөх үүрэгтэй.</p>		<p>-Amend.12-оор шинээр орсон</p>
<p>139.411. Нислэгийн хөдөлгөөний өгөгдлийг мэдээлэх Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн аэродромын сарын нислэгийн хөдөлгөөний өгөгдлийг цуглуулж, Даргад 3 сар тутам мэдээлэх журмыг тогтоох үүрэгтэй.</p>		
<p>139.413. Аэродром дээр хийгдэх ажил</p>		

<p>Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн аэродромд хийгдэж байгаа ажил агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул учруулахгүй байхыг бататгах зорилгоор, урьдчилсан сэргийлэх арга хэмжээг багтаасан журмыг тогтоох үүрэгтэй.</p>		
<p>139.415. Баримт бичгийн хөтлөлт Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> (1) тухайн аэродром, түүнтэй холбоотой үйлчилгээ болон байгууламжийн ашиглалт болон үйл ажиллагаанд шаардлагатай холбогдох баримт бичгийн хувийг хадгалах; (2) дараах зүйлийг бататгах зорилгоор энэ зүйлийн (1)-д шаардсан баримт бичгийн хяналтын журмыг тогтоох: <ul style="list-style-type: none"> (i) холбогдох баримт бичгийн хүчинтэй хувийг ажилтан ашиглах шаардлагатай байрлалд хэрэглэхэд бэлэн байлгах; (ii) хүчингүй болсон баримт бичгийг гаргаж байгаа, эсхүл ашиглаж байгаа бүх цэгээс нэн даруй хураадаг байх; (iii) өөрчлөгдөж хүчингүй болсон материалыг ашиглахаас сэргийлж, баримт бичгийн зүйл тус бүрийн хүчинтэй байдлыг таних боломжтой байх. 		
<p>139.417. Хязгаарлагдмал аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий заавар (а) Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан байх шаардлагатай Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> (1) хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад заавар нь дараах шаардлагыг хангаж байгааг бататгаж, Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл: <ul style="list-style-type: none"> (i) тухайн байгууллагыг тодорхойлж, энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулсан байх; (ii) байнга дагаж мөрддөг байх; (1A) 139.409-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд: <ul style="list-style-type: none"> (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг; (ii) хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ сунгуулахаас бусад хүсэлт гаргагчийн хувьд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхээ дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө; (2) 139.401(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын албан тушаал болон тэдний 		<p>-Amend.12-оор шинээр орсон</p> <p>-Amend.13-аар прагравын ишлэл буруу байсныг зассан</p>

нэрс;

(3) 139.401(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын дараах шаардлагыг багтаасан үүрэг, хариуцлага:

(i) Дарга, эсхүл ИНЕГ-тай, тухайн байгууллагын нэрийн өмнөөс шууд харьцах тэдний хариуцсан асуудал;

(ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;

(4) хэрэв хамааралтай бол, 139.401(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;

(5) 139.403-ын дагуу тогтоосон аэродромын ашиглалтад тавих хязгаарлалт;

(6) 139.405-д шаардсан нийтийг хамгаалах хамгаалалтын тодорхойлолт;

(6A) тухайн байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;

(7) 139.407-д шаардсан, аэродромын өгөгдөл болон мэдээллийг зарлан мэдээлэх журам;

(8) хүчингүй;

(9) 139.411-д шаардсан, нислэгийн хөдөлгөөний өгөгдлийг цуглуулах болон мэдээлэх журам;

(10) 139.413-д шаардсан, аэродром дээр ажил гүйцэтгэх журам болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

(11) 139.415(2)-т шаардсан, аэродромын ашиглалт болон үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийн хяналт, зохицуулалтын журам;

(12) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан шаардлагаас гадна, Ерөнхий заавар нь 139.21-д шаардсан нисэхийн судалгаагаар тогтоосон дараах зүйлд хамаарах эрсдэлийг удирдахад шаардлагатай журам, эсхүл шаардлагыг агуулсан байх ёстой:

(1) бодит үзүүлэлт, саадыг хязгаарлах гадаргуу, ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ, төхөөрөмж, байгууламж болон RESA-г багтаасан аэродромын төлөвлөлтийн шаардлага;

(2) аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө;

(3) аврах болон гал унтраах ;

(4) Мал, амьтан, шувууны аюулаас сэргийлэх, зохицуулалт;

(5) аэродромын засвар, үйлчилгээ;

(6) навигацийн ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ –

<p>засвар үйлчилгээ болон шалгалт; (7)аэродромын НХҮ; (8)апрон зохицуулалтын үйлчилгээ; (9)аэродромын үзлэгийн хөтөлбөр; (10) газрын үйлчилгээний тээврийн хэрэгсэл; (11) НХҮ-ний байгууламж болон навигацийн туслах төхөөрөмжийг хамгаалах; (12) аэродромын нөхцөлийг зарлан мэдээлэх.</p> <p>(с) Энэ Бүлэгт шаардсан Ерөнхий зааварт 139.21, эсхүл 139.457-д шаардсан нисэхийн судалгаагаар тогтоосон эрсдэлийг удирдах, эсхүл бууруулах зорилгоор В болон С Бүлгийн шаардлагыг иш татан хэрэглэж болно.</p> <p>(d) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.</p>		
<p>Н Бүлэг - Хязгаарлагдмал аэродромын үйл ажиллагааны шаардлага</p>		<p>-Amend.10-аар шинээр орсон</p>
<p>139.451. Байнгын хэрэгжилт Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) 139.417-д шаардсан Ерөнхий зааврын хүчинтэй, нэгээс доошгүй бүрэн хувийг тухайн аэродромд хадгалах; (2) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журам, төлөвлөгөө, систем болон хөтөлбөрийг дагаж мөрдөх; (3) Ерөнхий зааврын холбогдох бүлгийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглах боломжтой байлгах; (4) энэ Дүрмийн дагуу хязгаарлагдмал аэродромын гэрчилгээжүүлэлтэд тогтоосон G Бүлгийн шаардлагыг биелүүлж, стандартыг байнга мөрдөх; (5) САА 24139/01 маягтад шаардсан үйлчилгээний хаяг, утасны дугаар, эсхүл бусад холбоо барих дэлгэрэнгүй мэдээллийн өөрчлөлтийг 28 хоногийн дотор Даргад мэдээлэх.</p>		
<p>139.453. Аюултай нөхцөл Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч нь, хэрэв тухайн аэродромын аль нэг хэсэгт аюултай нөхцөл үүссэн үед агаарын хөлгийн үйл ажиллагааг хязгаарласан, эсхүл хориглосныг бататгах журмыг тогтоох үүрэгтэй.</p>		
<p>139.455. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт (а)Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавар нь аэродромын тодорхойлолт болон түүний холбогдох төлөвлөгөө, хөтөлбөр, үйлчилгээ, тогтолцоо, журам болон</p>		

байгууламж хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар нэмэлт өөрчлөлт хийгдсэнийг бататгах үүрэгтэй.

- (b) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт хийсэн нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгааг болон өөрийн Ерөнхий зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдсөнийг бататгах үүрэгтэй.
- (c) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа, нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргад цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.
- (d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхээс өмнө Даргаас урьдчилан зөвшөөрөл авсан байх шаардлагатай:
- (1) Гүйцэтгэх захирал өөрчлөх;
 - (2) нэр заагдсан удирдах ажилтныг өөрчлөх;
 - (3) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог өөрчлөх хэрэв тухайн өөрчлөлт нь бодит өөрчлөлт бол.
- (e) Дарга энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх нөхцөлийг тодорхойлж болно.
- (f) Гэрчилгээ эзэмшигч, энэ зүйлийн (e)-гийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.
- (g) Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь хязгаарлагдмал аэродромын гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардсан бол, гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.
- (h) Нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигч Ерөнхий заавартаа оруулах үүрэгтэй.

139.457. Нисэхийн судалгаа

- (a) Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагаандаа мониторинг хийх бөгөөд аэродромын үйл ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлж болох нөлөө бүхий өөрчлөлтөд нисэхийн судалгаа хийх үүрэгтэй.
- (b) Энэ зүйлийн (a)-д заасан нөлөө бүхий өөрчлөлтөд дараах зүйл багтана:
- (1) аэродромын агаарын хөлгийн хөдөлгөөний огцом өсөлт; эсхүл
 - (2) агаарын хөлгийн үйл ажиллагааны төрлийн нөлөө бүхий өөрчлөлт; эсхүл
 - (3) тухайн аэродромын бодит үзүүлэлтийн нөлөө бүхий өөрчлөлт; эсхүл
 - (4) тухайн аэродром, эсхүл түүний ойролцоох осол, эсхүл зөрчлийн огцом өсөлт; эсхүл

<p>(5) тухайн аэродром дээрх агаарын хөлгийн хөдөлгөөний жилийн төлөв нь үргэлжилсэн 3 жилийн хугацаанд дараах хэмжээнээс хэтэрсэн бол:</p> <p>(i) 8000, эсхүл түүнээс олон VFR болон IFR-ийн нийт хөдөлгөөн; эсхүл</p> <p>(ii) 1500, эсхүл түүнээс олон IFR-ийн хөдөлгөөн; эсхүл</p> <p>(iii) 12 000, эсхүл түүнээс олон VFR болон IFR-ийн нийт хөдөлгөөн, үүний 1800, эсхүл түүнээс олон хөдөлгөөн нь IFR-ийн; эсхүл</p> <p>(iv) 3000, эсхүл түүнээс олон IFR-ийн хөдөлгөөн; эсхүл</p> <p>(v) 20 000, эсхүл түүнээс олон VFR болон IFR-ийн нийт хөдөлгөөн.</p> <p>(с) Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч нь нисэхийн судалгаа хийж дууссаны дараа, дараах ажлыг нэн даруй гүйцэтгэх үүрэгтэй:</p> <p>(1) тухайн аэродромын үйл ажиллагаанд үнэлгээ хийж, хэрэв шаардлагатай бол нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай өөрчлөлтийг Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн Ерөнхий зааварт оруулах;</p> <p>(2) тухайн нисэхийн судалгааны үр дүнг Даргад хүргүүлэх.</p> <p>(d) Хэрэв боломжтой бол, тухайн хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч нь нөлөө бүхий өөрчлөлт орохоос өмнө нисэхийн судалгааг хийх үүрэгтэй.</p> <p>(e) Хэрэв хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигчид нөлөө бүхий өөрчлөлт орохоос өмнө нисэхийн судалгаа хийх боломж байхгүй бол, тухайн өөрчлөлтийн дараа гэрчилгээ эзэмшигч цаг алдалгүй нисэхийн судалгаа хийх үүрэгтэй.</p>		
<p>I Бүлэг - Гэрчилгээжээгүй аэродромын үйл ажиллагааны шаардлага</p>		<p>-Amend.10-аар шинээр орсон</p>
<p>139.501. Хамрах хүрээ</p> <p>(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, энэ Бүлэг нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид хамаарна.</p> <p>(b) Энэ Бүлэг нь дараах аэродромд хамаарахгүй:</p> <p>(1) аэродромын гэрчилгээ эзэмшигч;</p> <p>(2) хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч;</p> <p>(3) зөвхөн ХАА-н үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлөг ашигладаг, эсхүл ашиглахаар төлөвлөж байгаа аэродромын үйл ажиллагаа эрхлэгч.</p>		
<p>139.503. Аюултай нөхцөл</p> <p>Энэ бүлэгт хамаарах аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн аэродромын аль нэг хэсэгт аюултай нөхцөл үүссэн үед агаарын хөлгийн хөдөлгөөнийг тухайн аэродромын хэсэгт хязгаарлах эсхүл хориглох зохицуулалтыг бататгах журмыг</p>		

<p>тогтоох үүрэгтэй.</p>		
<p>139.505. Хөдөлгөөний тоог мэдээлэх Энэ Бүлэгт хамаарах аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь дараах үүрэгтэй: (a) тухайн аэродромын нислэгийн хөдөлгөөний өгөгдлийн жилийн тайланг Даргад хүргүүлэх. (b) хэрэв Дарга бичгээр хүсэлт гаргасан бол, тухайн аэродромын нислэгийн хөдөлгөөний цуглуулах болон мэдээлэх.</p>		
<p>J Бүлэг - Шилжилтийн зохицуулалт</p>		<p>-Amend.10-аар шинээр орсон</p>
<p>139.551. Олон улсын тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд үйлчилдэг аэродромын гэрчилгээ эзэмшигчийн болон хүсэлт гаргагчийн шилжилт (a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна: (1) тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэх онгоцонд үйлчилдэг дараах аэродромын гэрчилгээ эзэмшигчид: (i) тухайн аэродромд буулт үйлдэхийн өмнөх нисэх онгоцны хөөрөлтийн цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром; эсхүл (ii) тухайн аэродромоос хөөрөлт үйлдсэний дараах нисэх онгоцны буултын цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром; (2) тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэх онгоцонд үйлчлэх дараах аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчид: (i) тухайн аэродромд буулт үйлдэхийн өмнөх, нисэх онгоцны хөөрөлтийн цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром; эсхүл (ii) тухайн аэродромоос хөөрөлт үйлдсэний дараах, нисэх онгоцны буултын цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром; (b) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу хэрэгжүүлэлтийн огноог тогтоохоос өмнө, энэ зүйл хамаарах байгууллагыг дараах зүйлийг мөрдөхийг шаардахгүй: (1) 139.55(a)(2)(ii), хэрэв тухайн байгууллага аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол; (2) 139.75, хэрэв тухайн байгууллага аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон хадгалахын оронд 139.557-д шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол; (3) 139.77(a)(1A):</p>		

- (4)139.77(a)(3)(ii);
- (5)137.77(a)(6A); гэхдээ

(c) Гүйцэд бөглөсөн САА маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг дараах тохиолдолд Даргад хүргүүлсэн байх үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (a)(2)-ын дагуу аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд 2019 оны 7 сарын 30-наас хойш;
- (2) энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу аэродромын гэрчилгээ эзэмшигчийн хувьд 2019 оны 7 сарын 30-наас өмнө;

(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:

- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхээр санал болгосон огноог багтаасан байх;
- (2) тухайн байгууллага 139.75-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.

(e) Хэрэв хүлээн зөвшөөрөх боломжтой гэж үзвэл Дарга:

- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
- (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтооно.

(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу хэрэгжүүлэх өдрийг тогтоохдоо Дарга дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
- (2) тухайн байгууллагын төвөгшил;
- (3) тухайн байгууллагын ажиллагаанд оршиж байгаа эрсдэл;
- (4) гэрчилгээний хугацаа сунгах огноо;
- (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;
- (6) хэрэгжүүлэх хугацаа нь 2020 оны 2 сарын 1-нээс хойш байна.

(g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу аэродромын гэрчилгээ эзэмшигч нь хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг гэрчилгээ сунгуулах хүсэлтийн хамт хүргүүлэхгүй.

(h) Энэ зүйл 2020 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

139.553. Олон улсын тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд үйлчилдэггүй аэродромын гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт

(a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:

- (1) тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэх онгоцонд үйлчилдэггүй дараах аэродромын гэрчилгээ эзэмшигчид:

-Amend.12-оор шинээр орсон

- (i) тухайн аэродромд буулт үйлдэхийн өмнөх, нисэх онгоцны хөөрөлтийн цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром;эсхүл
 - (ii) тухайн аэродромоос хөөрөлт үйлдсэний дараах, нисэх онгоцны буултын цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром бол;
- (2) тогтмол агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисэх онгоцонд үйлчилдэггүй дараах аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчид:
- (i) тухайн аэродромд буулт үйлдэхийн өмнөх, нисэх онгоцны хөөрөлтийн цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром;эсхүл
 - (ii) тухайн аэродромоос хөөрөлт үйлдсэний дараах, нисэх онгоцны буултын цэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оршдог аэродром:
- (b) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу хэрэгжүүлэлтийн огноог тогтоохоос өмнө, энэ зүйл хамаарах байгууллагыг дараах зүйлийг мөрдөхийг шаардахгүй:
- (1) 139.55(a)(2)(ii), хэрэв тухайн байгууллага аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;
 - (2) 139.75, хэрэв тухайн байгууллага аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон хадгалахын оронд 139.557-д шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол:
 - (3) 139.77(a)(1A)(i);
 - (4) 139.77(a)(3)(ii);
 - (5) 137.77(a)(6A);
- (c) Гүйцэд бөглөсөн САА маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг дараах тохиолдолд Даргад хүргүүлсэн байх үүрэгтэй:
- (1) энэ зүйлийн (a)(2)-ын дагуу аэродромын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд 2019 оны 7 сарын 30-наас хойш;
 - (2) энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу аэродромын гэрчилгээ эзэмшигчийн хувьд 2019 оны 7 сарын 30-наас өмнө;
- (d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:
- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхээр санал болгосон огноог багтаасан байх;
 - (2) тухайн байгууллага 139.75-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг

-Amend.12-оор шинээр орсон

- гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд 2019 оны 7 сарын 30-наас хойш;
- (2)энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигчийн хувьд 2020 оны 7 сарын 30-наас өмнө;
- (d) Энэ зүйлийн (с)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхээр санал болгосон огноог багтаасан байх;
- (2) тухайн байгууллага нь 139.409-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.
- (e) Хэрэв хүлээн зөвшөөрөх боломжтой гэж үзвэл Дарга:
- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
- (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтооно.
- (f) Энэ зүйлийн (е)(2)-ын дагуу хэрэгжүүлэх өдрийг тогтоохдоо Дарга дараах зүйлсийг харгалзан үзнэ:
- (1)байгууллагын хүчин чадал;
- (2)байгууллагын төвөгшил;
- (3)тухайн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл;
- (4)гэрчилгээний хугацаа сунгах огноо;
- (5)тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр,эсхүл хуваарийн нөлөө;
- (6)хэрэгжүүлэх хугацаа нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байна.
- (g) Энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч нь хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг гэрчилгээ сунгуулах хүсэлтийн хамт хүргүүлэхгүй.
- (h) Энэ зүйл 2021 оны 2 сарын 1-нд өдөр хүчингүй болно.

139.557. Аэродромын гэрчилгээ эзэмшигч, хүсэлт гаргагчийн дотоод чанар баталгаажуулалтын шилжилт

- (a) Энэ Дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор 139.551(b)(1)(ii) 139.553(b)(1)(ii), 139.555(b)(1)(ii)-т шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй.
- (b) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь Гүйцэтгэх захиралтай агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдал, аэродром, түүний байгууламж, үйлчилгээнд нөлөөлөх асуудлаар шууд харьцах үүрэгтэй.
- (c) Энэ зүйл 2021 оны 2 сарын 1-нд өдөр хүчингүй болно.

-Amend.12-оор шинээр орсон

Хавсралт А - Аэродромын бодит үзүүлэлт		
<p>A.1. RESA-гийн бодит үзүүлэлт</p> <p>(a) RESA-гийн дараах зайгаар уртасгасан байх ёстой:</p> <ul style="list-style-type: none"> (1)ХБЗ-ны талбайн төгсгөлөөс цааш 90 м-ээс доошгүй зайд үргэлжилсэн байх; (2)хэрэв боломжтой бол: <ul style="list-style-type: none"> (i) ХБЗ-ны талбайн төгсгөлөөс цааш 240 м-ээс доошгүй: эсхүл (ii) (a)(1)-д шаардсан 90 м болон (a)(2)(i)-д шаардсан 240 м-ийн хоорондох аль боломжит урт. <p>(b) RESA-гийн өргөн нь дараах шаардлагыг хангасан байх ёстой</p> <ul style="list-style-type: none"> (1) тухайн ХБЗ-ны өргөнөөс хоёр дахин их болон түүнээс дээш өргөнтэй байх ба ХБЗ-ны үргэлжилсэн гол шугамын дагуу хоёр талдаа тэгш хэмтэй байрлуулсан байх; (2) боломжтой тохиолдолд, тухайн ХБЗ-ны талбайн тэгшилсэн хэсгийн өргөнтэй тэнцүү өргөнтэй байх. <p>(c) RESA-г дараах шаардлагыг хангаж байгуулсан байх ёстой:</p> <ul style="list-style-type: none"> (1)ХБЗ-д дутуу суух, эсхүл даван гүйж гарах нисэх онгоцны эвдрэл, гэмтлийн эрсдэлийг бууруулах зорилгоор тэгшилж, цэвэрлэсэн талбайтай байх; (2)боломжтой тохиолдолд, ХБЗ-д дутуу суух, эсхүл даван гүйж гарах нисэх онгоцонд аюул учруулах байгууламжгүй байх. <p>(d) RESA нь тухайн ХБЗ-ны ойртолтын, эсхүл хөөрөлтийн өндөр авах гадаргуутай давхцахгүй байх ёстой.</p> <p>(e) Хэрэв RESA нь уртын дагуу налуутай бол, дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <ul style="list-style-type: none"> (1) уруудах налуу нь 5%-иас хэтрэхгүй байх; (2) налуугийн өөрчлөлт нь аль болох жигд байх; (3) налуугийн гэнэтийн, эсхүл огцом өөрчлөлтөөс зайлсхийсэн байх. <p>(f) Хэрэв RESA нь хөндлөн налуутай бол дараах шаардлагыг хангасан байх ёстой:</p> <ul style="list-style-type: none"> (1)өгсөх, эсхүл уруудах налуу нь 5%-иас хэтрэхгүй байх; (2)налуугийн өөрчлөлт нь аль болох жигд байх. 		<p>-Amend.5-аар шинээр орсон</p>

Хавсралт В-Аэродромын хяналтын код

- (a) Аэродром төлөвлөлтийн зорилгоор сонгодог аэродромын хяналтын код болох кодын дугаар болон үсгэн кодыг тухайн аэродромын байгууламжийг ашиглахаар төлөвлөж байгаа нисэх онгоцны үзүүлэлтийн дагуу тогтоох ёстой.
- (b) Аэродромын хяналтын кодын дугаар болон үсгэн код нь Хүснэгт В-1-д заасан утгыг илэрхийлэх ёстой.
- (c) Элемент 1-ийн кодын дугаарыг Хүснэгт В-1-ийн 1-р баганад зааснаар тухайн ХБЗ-ыг ашиглахаар төлөвлөж байгаа нисэх онгоцны хяналтын талбайн уртын хамгийн өндөр утгатай тохирох кодын дугаарыг сонгож тогтоосон байх ёстой.

Тайлбар: Нисэх онгоцны хяналтын талбайн уртыг тодорхойлох нь зөвхөн кодын дугаарыг сонгоход орших бөгөөд тухайн ХБЗ-ны өгөгдсөн бодит уртад нөлөөлөх зорилгогүй.

- (d) Элемент 2-ын үсгэн кодыг Хүснэгт В-1-ийн (3) баганад зааснаар тухайн ХБЗ-ыг ашиглахаар төлөвлөж байгаа нисэх онгоцны далавчны хамгийн урт, эсхүл гадна үндсэн дугуй хоорондын зайн хамгийн ихэд тохирох аль их хэрэгцээтэй үсгэн кодыг сонгож тогтоосон байх ёстой.

Хүснэгт В-1. Аэродромын хяналтын код

Код элемент 1		Код элемент 2		
Код дугаар	Нисэх онгоцны хяналтын талбайн урт	Үсгэн код	Далавчны урт	Гадна үндсэн дугуй хоорондын зай
(1)	(2)	(3)	(4)	(5)
1	800 м-ээс бага	A	15 м хүртэл	4.5 м хүртэл

-Amend.10-аар нэмж орсон

2	800 м-ээс 1200 м хүртэл	B	15 м-ээс 24 м хүртэл	4.5 м-ээс 6 м хүртэл
3	1200 м-ээс 1800 м хүртэл	C	24 м-ээс 36 м хүртэл	6 м-ээс 9 м хүртэл
4	1800 м болон түүнээс урт	D	36 м-ээс 52 м хүртэл	9 м-ээс 14 м хүртэл
		E	52 м-ээс 65 м хүртэл	9 м-ээс 14 м хүртэл
		F	65 м-ээс 80 м хүртэл	14 м-ээс 16 м хүртэл

Тайлбар: Хүснэгтийн (5) баганад үзүүлсэн гадна үндсэн дугуй хоорондын зай гэж үндсэн газардах ангийн дугуйн гадна ирмэгийн хоорондын зайг.

Хавсралт С - Бодит үзүүлэлт

С.1. ХБЗ-ны гадаргуу

- (a) ХБЗ-ны гадаргууг, хучилтын барьцалтын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөх овон товонгүй, эсхүл нисэх онгоцны хөөрөлт, эсхүл буултад бусад хэлбэрээр нөлөөлөхгүйгээр байгуулсан байх ёстой.
- (b) Хучилттай ХБЗ-ыг Даргын тогтоосон барьцалтын минимум түвшинд, эсхүл түүнээс дээш барьцалтын үзүүлэлттэй байхаар байгуулсан, эсхүл нэмж хучсан байх ёстой.

С.2. ХБЗ-ны талбай

ХБЗ болон холбогдох зогсоох зам нь ХБЗ-ны талбайд багтсан байх ёстой.

С.2.1. ХБЗ-ны талбайн урт

ХБЗ-ны талбай нь босгоноос өмнө, хучилттай ХБЗ-ны

-Amend.10-аар шинээр орсон

төгсгөлөөс, эсхүл зогсоох замын төгсгөлөөс цааш дараах байдлаар үргэлжлэх ёстой:

- (1) аэродромын хяналтын кодын дугаар нь Хүснэгт В1-ийн 3, эсхүл 4 бол, 60 м-ээс доошгүй зайд; эсхүл
- (2) аэродромын хяналтын кодын дугаар нь Хүснэгт В1-ийн 2 бол, 30 м-ээс доошгүй зайд; эсхүл
- (3) аэродромын хяналтын кодын дугаар нь Хүснэгт В1-ийн 1 бол, 10 м-ээс доошгүй зайд.

С.2.2. ХБЗ-ны талбайн өргөн

ХБЗ-ны талбайг тухайн ХБЗ-ны гол шугамын уртын хоёр талд, тухайн ХБЗ-ны талбайн уртын дагуу үргэлжилсэн гол шугамын дагуу Хүснэгт С-1-д заасан минимум уртаар сунгах ёстой.

Хүснэгт С-1 ХБЗ-ны талбайг сунгах минимум урт

Аэродромын хяналтын кодын дугаар	ХБЗ-ны төрөл	Зай
3 эсхүл 4	Нарийвчлалтай ойртолт үйлдэх	150 м
3 эсхүл 4	Нарийвчлалгүй хэрэглэлээр ойртолт үйлдэх	75 м
3 эсхүл 4	Хэрэглэлийн бус ойртолт үйлдэх	75 м
1 эсхүл 2	Нарийвчлалтай ойртолт үйлдэх	75 м
1 эсхүл 2	Нарийвчлалгүй хэрэглэлээр ойртолт үйлдэх	75 м
2	Хэрэглэлийн бус ойртолт үйлдэх	40м
1	Хэрэглэлийн бус ойртолт үйлдэх	30м

С.2.3. ХБЗ-ны талбай дээрх байгууламж

(а) Хэврэг байдлын шаардлага хангасан, агаарын навигацийн зориулалтаар ашиглах ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээнээс бусад суурин байгууламжийг ХБЗ-ны талбайгаас дараах зайд байрлуулахыг зөвшөөрөхгүй.

<p>(1)кодын дугаар нь 4, үсгэн код нь F бол Хавсралт В-ийн Хүснэгт В-1-д заасан САТ I, II, эсхүл III-ын нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ны гол шугамаас 77.5 м зайд; эсхүл</p> <p>(2)кодын дугаар нь 3, эсхүл 4 бол, Хавсралт В-ийн Хүснэгт В-1-д заасан САТ I, II, эсхүл III-ын нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ны гол шугамаас 60 м зайд; эсхүл</p> <p>(3)кодын дугаар нь 1, эсхүл 2 бол, Хавсралт В-ийн Хүснэгт В-1-д заасан САТ I-ын нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ны гол шугамаас 45 м зайд.</p> <p>(b) Тухайн ХБЗ-ыг буулт, эсхүл хөөрөлтөд ашиглаж байгаа үед энэ зүйлийн (a)-д заасан ХБЗ-ны талбайн тухайн хэсэгт хөдөлгөөнт байгууламж байхыг зөвшөөргүй.</p>		
<p>С.2.4. ХБЗ-ны талбайн гадаргууг тэгшлэх ХБЗ-ны талбайн ХБЗ түүний хөвөө, эсхүл зогсоох замтай нийлж байгаа хэсгийн гадаргуу нь тухайн ХБЗ, түүний хөвөө, эсхүл зогсоох замын гадаргуутай ижил түвшинд тэгш байх ёстой.</p>		
<p>С.3. ХБЗ-ны эргэлтийн талбай ХБЗ-ны төгсгөлд явгалах зам, эсхүл эргэлт хийх явгалах зам байхгүй бөгөөд Хавсралт В-ийн Хүснэгт В-1-д заасан үсгэн код нь D, E, эсхүл F бол, ХБЗ-ыг нисэх онгоц 180° эргэлт хийх боломжтой эргэлтийн талбайгаар хангасан байх ёстой.</p>		
<p>С.3.1. ХБЗ-ны эргэлтийн талбайн төлөвлөлт ХБЗ-ны эргэлтийн талбайн төлөвлөлтийг, эргэлтийн талбайг ашиглахаар төлөвлөж байгаа нисэх онгоцны нисгэгчийн бүхээг тухайн эргэлтийн талбайн тэмдэглэгээг дагаж байх үед, нисэх онгоцны газардах ангийн аль ч дугуй болон эргэлтийн талбайн ирмэг хооронд тусгаарлах зай 4.5 м-ээс багагүй байхаар тооцоолох ёстой.</p>		
<p>С.3.2. ХБЗ-ны эргэлтийн талбайн гадаргуу ХБЗ-ны эргэлтийн талбай нь, тухайн эргэлтийн талбайг ашиглаж байгаа нисэх онгоцонд гэмтэл учруулж болзошгүй тэгш бус гадаргуутай байж болохгүй.</p>		
<p>С.4. Зогсоох зам Зогсоох замын өргөн нь тухайн ХБЗ-ны өргөнтэй ижил байх ёстой.</p>		

С.5. Явгалах зам

Энэ дүрмийн 139.5(аа)-д заасан аэродромын явгалах замын төлөвлөлтийг, тухайн эргэлтийн талбайг ашиглах нисэх онгоцны нисгэгчийн бүхээг нисэх онгоцны явгалахад зориулсан явгалах замын гол шугамын тэмдэглэгээг дагаж байх үед нисэх онгоцны гадна үндсэн дугуй болон явгалах замын хажуу ирмэг хоорондын тусгаарлах зай Хүснэгт С-2-т тогтоосноос багагүй байхаар тооцоолох ёстой.

Хүснэгт С-2. Явгалах замын ирмэгийн тусгаарлах зай

Үсгэн код	Тусгаарлах зай
A	1.5 м
B	2.25 м
C	3м, хэрэв тухайн ашиглахаар зорьж байгаа явгалах замыг, үндсэн дугуй хоорондын зай 18м-ээс ихгүй нисэх онгоц ашиглах бол;эсхүл
	4.5м, хэрэв тухайн явгалах замыг, үндсэн дугуй хоорондын зай 18м-тэй тэнцүү, эсхүл түүнээс их нисэх онгоц ашиглах бол
D	4.5 м
E	4.5 м
F	4.5 м

Тайлбар: Үндсэн дугуй хоорондын зай гэж урд дугуйны голоос үндсэн дугуйны геометрийн төв цэг хүртэлх зайг хэлнэ.

С.6. Гүүрэн явгалах зам

Явгалах замыг ашиглахаар төлөвлөж байгаа нисэх онгоцонд аюулгүй байх батлагдсан аргаар тодорхойлсон хажуугийн хашлагатай байхаас бусад тохиолдолд явгалах замын гол

-Amend.10-аар шинээр орсон

<p>шугамтай перпендикуляраар хэмжсэн нисэх онгоцыг даах чадвартай гүүрэн явгалах замын тухайн хэсгийн өргөн нь тухайн явгалах замд зориулан тогтоосон талбайн тэгшилсэн талбайн өргөнөөс багагүй байх ёстой.</p>		
<p>C.7. Явгалах талбай Агаарын хөлгийн зогсоолын явгалах шугамаас бусад явгалах зам нь ХБЗ-ны талбайд багтсан байх ёстой.</p>		
<p>C.8. Хүлээх байршил (a) ХБЗ-ны хүлээх байршлыг дараах байрлалд тогтоосон байх ёстой: (1) явгалах зам дээр, явгалах зам болон ХБЗ-ны уулзварт; (2) эхний ХБЗ нь стандарт явгалах чиглэлийн замын хэсгээр төлөвлөгдсөн бол, тухайн ХБЗ өөр ХБЗ -тай огтлолцох уулзварт. (b) Хэрэв тухайн байрлал, эсхүл явгалах замын чиглэл нь явгалж буй агаарын хөлгийг, эсхүл тээврийн хэрэгслийг саадаас хязгаарлах гадаргуугаас гаргах, эсхүл радио навигацийн төхөөрөмжийн үйл ажиллагаанд нөлөөлж бол ХБЗ-ны хүлээх байршлыг явгалах зам дээр тогтоосон байх ёстой. (c) ХБЗ-тай огтлолцсон замын уулзварт хүлээх цэгийн байршлыг тогтоосон байх ёстой.</p>		
<p>Хавсралт D - Саадыг хязгаарлах болон зайлуулах</p>		
<p>D.1. Саадыг хязгаарлах гадаргуу (a) ХБЗ-д дараах саадыг хязгаарлах гадаргууг тогтоосон байх ёстой: (1) конусан гадаргуу; (2) дотоод хэвтээ гадаргуу; (3) ойртолтын гадаргуу; (4) шилжилтийн гадаргуу. (b) CAT II, эсхүл CAT III-ын нарийвчлалтай ойртолтын ХБЗ-д дараах нэмэлт саадыг хязгаарлах гадаргууг тогтоосон байх ёстой: (1) ойртолтын дотоод гадаргуу; (2) шилжилтийн дотоод гадаргуу; (3) аргагүйдсэн буултын гадаргуу. (c) Хэрэглэлийн бус ХБЗ-ны хувьд, шинэ байгууламж, эсхүл өргөтгөл нь одоо байгаа хөдөлгөөнгүй байгууламжаар халхлагдах, эсхүл нисэхийн судалгаагаар тухайн байгууламжийг агаарын хөлгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй, эсхүл үйл ажиллагааны тогтмолжилтод их хэмжээгээр нөлөөлөхгүй болохыг тогтоосноос бусад тохиолдолд шинэ байгууламж, эсхүл одоо байгаа</p>	<p>139.185. Өндрийн саад, бартаа үүсэх (a) Гэрчилгээ эзэмшигч нь Иргэний нисэхийн тухай хуульд заасны дагуу аэродромын аюулгүй бүсэд байгаа аливаа өндрийн саадыг арилгуулах, тэмдэг дохио байршуулах, гэрэлтүүлгийн байдлыг хянаж шалгах үүрэгтэй. Тэмдэг, дохио, гэрэлтүүлэг байршуулах тухай зааврыг Зөвлөмжийн цуврал болон Аэродромын техникийн стандартад тусгасан байна.</p>	<p>-Amend.10-аар шинээр орсон</p>

<p>байгууламжийн өргөтгөлийг ойртолтын, эсхүл шилжих гадаргуугаас дээш байхыг зөвшөөрөхгүй.</p> <p>(d) Нарийвчлалгүй ойртолтын ХБЗ-ны хувьд, шинэ байгууламж, эсхүл өргөтгөл нь одоо байгаа хөдөлгөөнгүй байгууламжаар халхлагдах, эсхүл нисэхийн судалгаагаар тухайн байгууламжийг агаарын хөлгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй, эсхүл үйл ажиллагааны тогтмолжилтод их хэмжээгээр нөлөөлөхгүй болохыг тогтоосноос бусад тохиолдолд шинэ байгууламж, эсхүл одоо байгаа байгууламжийн өргөтгөл нь дотоод ирмэг, эсхүл шилжилтийн гадаргуугаас дээш 3000м-ийн дотор байх ойртолтын гадаргуугаас дээш гарахыг хориглоно.</p> <p>(e) Нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ны хувьд тухайн ХБЗ-ны талбай дээр зайлшгүй байх шаардлагатай хэврэг хийцтэй байгууламжаас бусад суурин байгууламжийг ойртолтын дотоод гадаргуу, шилжилтийн дотоод гадаргуу, эсхүл аргагүйдсэн буулт үйлдэх гадаргуугаас дээш, байхыг зөвшөөрөхгүй. Тухайн ХБЗ-ыг буултад ашиглаж байгаа үед эдгээр гадаргуугаас дээш хөдөлгөөнт байгууламж байхыг зөвшөөрөхгүй.</p> <p>(f) Нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ны хувьд шинэ байгууламж, эсхүл өргөтгөл нь одоо байгаа хөдөлгөөнгүй байгууламжаар халхлагдах, эсхүл нисэхийн судалгаагаар тухайн байгууламжийг агаарын хөлгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй, эсхүл үйл ажиллагааны тогтмолжилтод их хэмжээгээр нөлөөлөхгүй болохыг тогтоосноос бусад тохиолдолд шинэ байгууламж, эсхүл одоо байгаа байгууламжийн өргөтгөлийг ойртолтын, эсхүл шилжилтийн гадаргуугаас дээш байхыг зөвшөөрөхгүй.</p>		
<p>D.2. Хөөрөлтийн өндөр авах гадаргуу</p> <p>(a) Хөөрөлт үйлдэх ХБЗ-д хөөрөлтийн өндөр авах гадаргууг тогтоосон байх ёстой.</p> <p>(b) Шинэ байгууламж, эсхүл өргөтгөл нь одоо байгаа хөдөлгөөнгүй байгууламжаар халхлагдах, эсхүл нисэхийн судалгаагаар тухайн байгууламжийг агаарын хөлгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй, эсхүл үйл ажиллагааны тогтмолжилтод их хэмжээгээр нөлөөлөхгүй болохыг тогтоосноос бусад тохиолдолд, шинэ байгууламж, эсхүл одоо байгаа байгууламжийн өргөтгөлийг хөөрөлтийн өндөр авах гадаргуугаас дээш байхыг зөвшөөрөхгүй.</p>		<p>-Amend.10-аар шинээр орсон</p>
<p>Хавсралт E - Навигацийн ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ</p>		
<p>E.1. Салхины чиглэл заах хэрэгсэл</p>	<p>139.173. Салхины чиглэл заагч (a) Гэрчилгээ эзэмшигч нь салхины чиглэл заагчийг ашиглахдаа</p>	

<p>(a) Салхины чиглэл заах хэрэгслийг (windsock) хучилттай ХБЗ-ны босгоны дэргэд байрлуулсан байх ёстой.</p> <p>(b) Хэрэв хучилттай ХБЗ-ыг шөнийн цагаар ашиглахаар төлөвлөж байгаа бол, энэ зүйлийн (a)-д шаардсан салхины чиглэл заах хэрэгслийн нэгээс доошгүйг гэрэлтүүлсэн байх ёстой.</p>	<p>дараах шаардлагыг биелүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1/ нисэх багт гадаргуугийн салхины чиглэлийг мэдээлэх чиглэл заагчийг стандартын дагуу байрлуулна; 2/ салхины чиглэл заагчийг байрлуулах нь ашиглаж буй зурвас бүрт хамаарах бөгөөд түүнийг хөөрөлтийн болон суултын бүсэд байрлуулсан байна; 3/ шөнөөр нислэг үйлддэг нисэх буудлууд салхины чиглэл заагч болон бусад тэмдэгтүүдийг гэрэлтүүлсэн байна; <p>(б) Аэродромын тэмдэгтүүдийг байршуулахдаа аэродромын техникийн стандартын холбогдох заалт, зөвлөмжийн цувралуудыг ашиглана.</p>	<p>-Amend.10-аар өөрчлөгдсөн</p>
<p>E.2. Тэмдэглэгээ</p>	<p>139.157. Тэмдэг, тэмдэглэгээ болон гэрэлтүүлэг</p>	
<p>E.2.1. Өнгө</p> <p>(a) ХБЗ-ны тэмдэглэгээ нь цагаан өнгөтэй байх ёстой.</p> <p>(b) Явгалах замын, ХБЗ-ны эргэлтийн талбайн болон агаарын хөлгийн зогсоолын тэмдэглэгээ нь шар өнгөтэй байх ёстой.</p> <p>(c) Апроны аюулгүйн шугам нь агаарын хөлгийн зогсоолын тэмдэглэгээнд хэрэглэж байгаагаас эрс ялгаатай, тод ялгарч харагдах өнгөтэй байх ёстой.</p> <p>E.2.2. ХБЗ-ны тэмдэглэгээ</p> <p>Бүх хучилттай ХБЗ-д, ХБЗ-ыг тогтоосон тэмдэглэгээ, гол шугамын тэмдэглэгээ болон босгоны тэмдэглэгээг хийсэн байх ёстой.</p> <p>E.2.3. ХБЗ-ны тэмдэглэгээ тасалдах</p> <p>(a) Хоёр, эсхүл түүнээс дээш ХБЗ-ны уулзвар дээр, ХБЗ-ны хажуугийн зураасан тэмдэглэгээнээс бусад илүү ач холбогдолтой ХБЗ-ны тэмдэглэгээ харагдаж байх ёстой бөгөөд бусад ХБЗ-ны тэмдэглэгээ тасарсан байх ёстой. Илүү ач холбогдолтой ХБЗ-ны хажуугийн зураасан тэмдэглэгээ нь тухайн уулзвараар үргэлжилсэн, эсхүл тасарсан байж болно.</p> <p>(b) ХБЗ-ны хажуугийн зураасан тэмдэглэгээ тасарсан байж болохоос бусад тохиолдолд, ХБЗ болон явгалах замын уулзварт байрлах ХБЗ-ны тэмдэглэгээ харагдаж байх ёстой бөгөөд явгалах замын тэмдэглэгээ тасарсан байж болно.</p> <p>E.2.4. Хөндлөн зураас</p> <p>ХБЗ-ны босго нь хучилттай ХБЗ-ны төгсгөлөөс шилжүүлсэн эсхүл хучилттай ХБЗ-ны төгсгөл нь ХБЗ-ны гол шугамтай тэгш өнцөгт талбай үүсгээгүй бол тухайн босгоны тэмдэглэгээн дээр хөндлөн зураасыг нэмж тэмдэглэсэн байх ёстой.</p> <p>E.2.5. Чиг заагч сум</p> <p>Хатуу хучилттай ХБЗ-ны босгыг байнга байхаар шилжүүлсэн тохиолдолд, чиг заагч сумыг, шилжүүлсэн босгоны өмнө, ХБЗ-ны</p>	<p>(a) Гэрчилгээ эзэмшигч бүр өөрийн аэродромд стандартын дагуу тэмдэг дохио, будган тэмдэглэгээ хийж, арчлалтыг технологийн дагуу хийнэ. Үүнд:</p> <p>1/ хөөрч, буух зурвасны <u>будган</u> тэмдэглэгээ</p> <p>139.159. Өвлийн ашиглалт, цас мөс</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь аэродромын цас мөс арилгах Өвлийн ашиглалтын журмыг заавартаа тусгасан байна. Аэродромын өвлийн ашиглалтын журамд доорх зүйлүүдийг заавал тусгана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1/ хөдөлгөөний бүсийг цас мөснөөс түргэн шуурхай арилгах заавар; 2/ арилгасан цасыг овоолох байршил тодорхой байх, эдгээр нь агаарын хөлгийн хөдөлгүүр, далавч, бусад эд ангид саад учруулахааргүй байх; 3/ цас цэвэрлэгээний ажлын дараалал, хуваарь; 4/ цас цэвэрлэгээний ажлын явц, хөөрч буух зурвасны гадаргуугийн талаар нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагад шуурхай мэдээлэх заавар; <p>хөтөлбөрийг батлагдсан стандарт болон зөвлөмжийн цувралыг ашиглаж боловсруулна.</p>	

тухайн хэсэг дээр тэмдэглэсэн байх ёстой.

E.2.6. Газардах цэгийн тэмдэглэгээ

Хавсралт В-ийн дагуу тухайн аэродромын хяналтын кодын дугаарыг 2, 3, эсхүл 4 гэж тодорхойлсон бол, хатуу хучилттай хэрэглэлийн ХБЗ-ны ойртолтын төгсгөлд газардах цэгийн тэмдэглэгээг хийсэн байх ёстой.

E.2.7. Газардах бүсийн тэмдэглэгээ

Хавсралт В-ийн дагуу тухайн аэродромын хяналтын кодын дугаарыг 2, 3, эсхүл 4 гэж тодорхойлсон бол хучилттай нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ны газардах бүсэд, газардах бүсийн тэмдэглэгээг хийсэн байх ёстой.

E.2.8. ХБЗ-ны хажуугийн зураасан тэмдэглэгээ

Тухайн ХБЗ-ны ирмэг болон хөвөө, эсхүл эргэн тойрны газрын хоорондын үзэгдэх орчны ялгаа бага бол, хучилттай ХБЗ-ны босгонуудын хооронд ХБЗ-ны хажуугийн зураасан тэмдэглэгээг хийсэн байх ёстой.

E.2.9. Явгалах замын гол шугамын тэмдэглэгээ

(a) Хавсралт В-гийн дагуу тухайн аэродромын хяналтын кодын дугаарыг 3, эсхүл 4 гэж тодорхойлсон бол, хатуу хучилттай явгалах зам, мөстөлтийг арилгах / мөстөлтөөс сэргийлэх байгууламж болон апрон дээр ХБЗ-ны гол шугам болон агаарын хөлгийн зогсоолын хооронд үргэлжлүүлэн хөтлөх, явгалах замын гол шугамын тэмдэглэгээг хийсэн байх ёстой.

(b) ХБЗ нь стандарт явгалах чиглэлийн замын хэсэг бол дараах тохиолдолд хатуу хучилттай ХБЗ дээр явгалах замын гол шугамын тэмдэглэгээг хийсэн байх ёстой:

(1) ХБЗ-ны гол шугамын тэмдэглэгээ байхгүй; эсхүл

(2) тухайн ХБЗ-ны гол шугам нь явгалах замын гол шугамтай давхцадаггүй бол.

(c) Явгалах зам болон ХБЗ нь уулзвартай бол, тэдгээрт явгалах замын гол шугамын сайжруулсан тэмдэглэгээг хийсэн байх ёстой.

E.2.10. ХБЗ-ны эргэлтийн талбайн тэмдэглэгээ

Хатуу хучилттай ХБЗ нь эргэлтийн талбайтай бол нисэх онгоц 180° эргэлт хийж, ХБЗ-ны гол шугамын дагуу чиглүүлэхэд туслах, үргэлжлүүлэн хөтлөх эргэлтийн талбайн тэмдэглэгээг хийсэн байх ёстой.

E.2.11. ХБЗ-ны хүлээх байршлын тэмдэглэгээ

Хучилттай ХБЗ, эсхүл явгалах зам дээр ХБЗ-ны хүлээх байршлын тэмдэглэгээг хүлээх байршлын дагуу хийсэн байх ёстой.

E.2.12. Аэродромын VOR шалгах цэгийн тэмдэглэгээ

Аэродромын VOR шалгах цэгийг тогтоосон бол түүнийг VOR шалгах цэгийн тэмдгээр тэмдэглэсэн байх ёстой.

2/ явгалах замын **тэнхлэгийн зураас**;

3/ явгалах замын **хязгаарын зураас**;

4/ хүлээх байрлал;

5/ хэрэглэлийн буултын систем;

6/ аюултай газруудын тэмдэглэгээ;

7/ ил харааны тэмдэг дохионууд;

8/ I болон II ангиллын **хатуу хучилттай зурвас** бүхий аэродромуудын тэмдэглэгээ нь гэрэл ойлгогчтой байна;

9/ Салхи заагч болон аюултай газруудын тэмдэглэгээ нь гэрэлтүүлэгтэй байна.

Е.2.13. Замын хүлээх байршлын тэмдэглэгээ

Замын хүлээх байршлын тэмдэглэгээг ХБЗ руу нэвтрэх бүх хучилттай замын гадаргуу дээр тэмдэглэсэн байх ёстой.

Е.2.14. Заавал мөрдөх зааварлах тэмдэглэгээ

Заавал мөрдөх зааварлах тэмдгийг суурилуулах боломжгүй бол, заавал мөрдөх тэмдэглэгээг хучилтын гадаргуу дээр хийсэн байх ёстой.

Е.2.15. Мэдээлэх тэмдэглэгээ

Мэдээлэх тэмдгийг байрлуулсан байх ёстой боловч байрлуулах боломжгүй тохиолдолд мэдээлэх тэмдэглэгээг тухайн хучилтын гадаргуу дээр тэмдэглэж харуулсан байх ёстой.

Е.3. Гэрэл**Е.3.1. Өргөгдсөн ойртолтын гэрэл**

(a) Өргөгдсөн ойртолтын гэрэл болон тэдгээрийн тулгуур бүтэц нь ХБЗ-ны босгоноос 300 м-ээс цааш байрлах ойртолтын гэрэлтүүлгийн дараах хэсэгт байхаас бусад тохиолдолд хэврэг байх ёстой:

(1) тулгуур бүтцийн өндөр 12 м-ээс дээш бол, хэврэг байдлын шаардлага нь зөвхөн орой хэсгийн 12 м-т хамаарах ёстой;

(2) тулгуур бүтэц хэврэг бус хийцтэй байгууламжаар хүрээлэгдсэн бол, зөвхөн хүрээлсэн байгууламжаас дээш өргөгдсөн хэсэг нь хэврэг байх ёстой.

(b) Хэрэв ойртолтын гэрлийн хэмжээ, эсхүл тулгуур бүтэц хангалттай харагдахааргүй байгаа бол зохих байдлаар тэмдэглэгдсэн байх ёстой.

Е.3.2. Өргөгдсөн гэрэл

ХБЗ, зогсоох зам болон явгалах замын өргөгдсөн гэрэл нь хэврэг байх ёстой. Тэдгээрийн өндрийн хэмжээ нь сэнсний үзүүр болон жэт-агаарын хөлгийн хөдөлгүүрийн доод өөхийгөөс хангалттай тусгаарлах зай хадгалахаар намхан байх ёстой.

Е.3.3. Гадаргууд суулгасан гэрэл

ХБЗ, зогсоох зам, явгалах зам болон апроны гадаргууд суулгасан гэрлийн бэхлэх суурийг дээгүүр өнгөрч байгаа агаарын хөлгийн дугуйнаас ирэх ачааллыг дааж, агаарын хөлөгт, эсхүл гэрэлт өөрт нь эвдрэл гэмтэл учруулахааргүйгээр зохион бүтээж суурилуулсан байх ёстой.

Е.3.4. Гэрлийн тодорц ба удирдлага

(a) ХБЗ-ны гэрэлтүүлгийн тодорц нь, ХБЗ-ыг ашиглахаар төлөвлөж байгаа алсын барааны харагдацын минимум болон гадна орчны гэрлийн нөхцөлтэй тохирч байх, хэрэв ойртолтын гэрэлтүүлгийн системээр хангагдсан бол түүний хамгийн ойрын хэсэгтэй ижил тэнцүү байх ёстой.

(b) Давамгайлсан нөхцөлийн шаардлагыг хангах зорилгоор

(б) Гэрчилгээ эзэмшигч нь шөнийн нислэгт зориулагдсан гэрэлтүүлгийн системтэй бол дараах гэрлүүдэд хяналт тавих үүрэг бүхий нэгж, мэргэжилтэнтэй байна. Үүнд:

- 1/ хөөрч, буух зурвасны гэрэл;
- 2/ явгалах замын гэрэл;
- 3/ хязгаарын гэрлүүд;
- 4/ гэрэлт дохио;
- 5/ ойртолтын гэрлүүд;
- 6/ саадын гэрэлтүүлэг.
- 7/ аэродром орчмын гэрэлтүүлэг

(в) Гэрчилгээ эзэмшигч аэродромын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлгийг зөв зохистой ашиглах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Энэ хэсгийн “Зөв зохистой ашиглалт” гэдэгт цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, арчлалт, хэрэглэгчийн хэрэгцээг хангаж байх харагдац, байршил зөв байх гэсэн шаардлагууд орно.

(г) Перрон, зам талбай, барилга байгууламж, хашааны гэрэлтүүлэг зэрэг нь агаарын хөлгийн хөдөлгөөн, нислэгийн удирдлагад нөлөөлж харшлахгүй байршилтай байх, эсхүл халхлагдаж далдлагдсан байна.

(д) Аэродромын ойролцоо орших хот суурингийн гэрэлтүүлэг нь аэродромын суултын гэрэлтэй давхацсан байрлалтай, ижил өнгө, давтамжтай байвал аэродром эзэмшигч нь тухайн гэрлийг унтраах болон халхлах арга хэмжээ авна.

(e) Ашиглалтын журмыг аэродромын батлагдсан стандарт, зөвлөмжийн цуврал зэрэгт тулгуурлан боловсруулж, удирдамж болгон хэрэглэнэ.

гэрлийн тодорцыг тохируулах тохиромжтой удирдлагыг хийсэн байх ёстой. Хэрэв дараах системийг суурилуулсан бол тухайн системийг тохирсон тодорцтой ажиллаж чадахыг бататгах зорилгоор тусдаа тодорцын удирдлага, эсхүл бусад тохирох аргаар хангасан байх ёстой:

- (1) ойртолтын гэрэлтүүлгийн систем;
- (2) ХБЗ-ны ирмэгийн гэрэл;
- (3) ХБЗ-ны босгоны гэрэл;
- (4) ХБЗ-ны төгсгөлийн гэрэл;
- (5) ХБЗ-ны гол шугамын гэрэл;
- (6) ХБЗ-ны газардах бүсийн гэрэл;
- (7) явгалах замын гол шугамын гэрэл.

Е.3.5. Аэродромын гэрэлт маяк

Хэрэв дараах 1, эсхүл хэд хэдэн нөхцөл байгаа бол шөнийн цагаар ашиглахаар төлөвлөж байгаа аэродромд, аэродромын гэрэлт маяк байрлуулсан байх ёстой.

- (1) агаарын хөлөг ихэвчлэн ил хараагаар нислэг үйлддэг;
- (2) алсын барааны харагдац багасах нөхцөл байнга давтагддаг;
- (3) орчны гэрэл, эсхүл газар зүйн саадаас шалтгаалан агаараас тухайн аэродромын байрлалыг тогтооход хүндрэлтэй байдаг.

Е.3.6. Ойртолтын гэрэлтүүлгийн систем

- (a) Тухайн ХБЗ-ыг зөвхөн алсын барааны харагдац сайн нөхцөлд ашигладаг, эсхүл бусад ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ нь хангалттай чиглүүлдэг байхаас бусад тохиолдолд, хэрэгжүүлэх боломжтой бол нарийвчлалгүй ойртолтын ХБЗ-ыг энгийн ойртолтын гэрэлтүүлгийн системээр (SALS) хангасан байх ёстой.
- (b) Хэрэв хэрэгжүүлэх боломжтой бол CAT I-ийн нарийвчлалтай ойртолтын ХБЗ-д үйлчлэх CAT I-ийн нарийвчлалтай ойртолтын гэрэлтүүлгийн системээр хангасан байх ёстой.
- (c) CAT II, эсхүл CAT III-ын нарийвчлалтай ойртолтын ХБЗ-д үйлчлэх CAT II болон CAT III-ын нарийвчлалтай ойртолтын гэрэлтүүлгийн системээр хангасан байх ёстой.

Е.3.7. Ил харааны ойртолтын өнцөг заагч систем (VASIS)

- (a) Дараах 1, эсхүл хэд хэдэн нөхцөл байгаа тохиолдолд тухайн зурвас нь бусад ил харааны ойртолтын туслах хэрэгсэл, тэмдэглэгээ эсхүл ил харааны бус туслах хэрэгсэл тэмдэглэгээтэй эсэхээс үл хамааран ойртолт үйлдэх зорилгоор тухайн ХБЗ-ыг ил харааны ойртолтын өнцөг заагч системээр хангасан байх ёстой.
 - (1) тухайн ХБЗ-ыг турбо-жэт, турбо-фэн, эсхүл ойртолтын чиглүүлэх шаардлага нь ижил төстэй бусад нисэх онгоц

ашигладаг бол;

(2) дараах нөхцөлөөс шалтгаалан, бүх маягийн нисэх онгоцны нисгэгчид ойртолт үйлдэх шийдвэр гаргахад хүндрэл үүсэж болзошгүй бол:

(i) өдрийн цагаар усан дээгүүр, эсхүл онцлох газар зүйн шинж тэмдэггүй нөхцөлд, эсхүл шөнийн цагаар ойртолтын бүсэд гадна орчны хангалттай гэрэлгүй нөхцөлд ойртолт үйлдэхэд ил харааны чиглүүлэлт хангалтгүй, эсхүл

(ii) орчны газрын бартаа, эсхүл ХБЗ-ны налуу зэргээс үүдэлтэй төөрөгдүүлэх мэдээлэл;

(3) нисэх онгоц хэвийн ойртолтын траектороос доогуур өндөр алдах үед ойртолтын бүсэд байгаа байгууламж түүнд бодит аюул учруулж болох ялангуяа тийм байгууламж байгааг анхааруулах өөр бусад ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ, эсхүл ил харааны бус туслах хэрэгсэл, тэмдэглэгээ байхгүй нөхцөлд;

(4) ХБЗ-ны аль ч төгсгөлийн ерөнхий нөхцөл нь нисэх онгоц ХБЗ-нд дутуу суух, эсхүл ХБЗ-ыг даван гүйж гарах үед ноцтой аюул учруулахаар бол;

(5) газрын нөхцөл эсхүл голлох цаг уурын нөхцөл нь ойртолт үйлдэж байгаа нисэх онгоц хэвийн бус сэгсрэлт үзүүлэхээр бол.

(b) Энэ зүйлийн (a)(1) - (5)-д заасан 1, эсхүл түүнээс олон нөхцөл байгаа тохиолдолд, тухайн аэродромын хяналтын кодын дугаарыг Хавсралт В-ийн дагуу 3, эсхүл 4 гэж тодорхойлсон тохиолдолд PAPI, T-VASIS, эсхүл AT-VASIS-аар хангасан байх ёстой.

(c) Энэ зүйлийн (a)(1) - (5)-д заасан 1, эсхүл хэд хэдэн нөхцөл байгаа тохиолдолд тухайн аэродромын хяналтын кодын дугаарыг Хавсралт В-ийн дагуу 1, эсхүл 2 гэж тодорхойлсон тохиолдолд, PAPI, эсхүл APAPI-аар хангасан байх ёстой.

Е.3.8. Саадыг хамгаалах гадаргуу

(a) Ил харааны ойртолтын өнцөг заагч системээр хангахаар төлөвлөж байгаа бол саадыг хамгаалах гадаргууг тогтоосон байх ёстой.

(b) Шинэ байгууламж эсхүл өргөтгөлийн одоо байгаа хөдөлгөөнгүй байгууламжаар халхлагдахаас бусад тохиолдолд шинэ байгууламж эсхүл одоо байгаа байгууламжийн өргөтгөл нь саадыг хамгаалах гадаргуугаас дээш байхыг зөвшөөрөхгүй.

(c) Тухайн байгууламж нь одоо байгаа хөдөлгөөнгүй байгууламжаар халхлагдсан, эсхүл нисэхийн судалгаагаар нисэх онгоцны үйл ажиллагааны аюулгүй байдалд сөргөөр

нөлөөлөхгүй болохыг тогтоосноос бусад тохиолдолд саадыг хамгаалах гадаргуугаас дээш өргөгдсөн одоо байгаа байгууламжийг буулгасан байх ёстой.

(d) Нисэхийн судалгаагаар саадыг хамгаалах гадаргуугаас дээш өргөгдсөн одоо байгаа байгууламж нисэх онгоцны үйл ажиллагааны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй болохыг тогтоосноос бусад тохиолдолд дараах 1, эсхүл хэд хэдэн арга хэмжээ авах ёстой.

(1) ил харааны ойртолтын өнцөг заагч системийн ойртолтын налууг тохируулж дээшлүүлэх;

(2) тухайн байгууламж нь цацрагийн хүрээнээс гадуур байхаар ил харааны ойртолтын өнцөг заагч системийн азимутын тархалтыг бууруулах;

(3) ил харааны ойртолтын өнцөг заагч систем ба холбогдох саадыг хамгаалах гадаргуугийн тэнхлэгийг 5°-ээс ихгүйгээр шилжүүлэх;

(4) тухайн ХБЗ-ны босгыг тохиромжтой байдлаар шилжүүлэх;

(5) энэ хэсгийн (4)-ийг хэрэгжүүлэх боломжгүй болох нь тогтоогдсон бол, ил харааны ойртолтын өнцөг заагч системийг босгыг огтлох өндөр байгууламжийг нэвтрэх өндөртэй ижил өсгөхийн тулд ХБЗ-ны босгоноос цааш тохируулж шилжүүлэх.

Е.3.9. ХБЗ-ны ирмэгийн болон төгсгөлийн гэрэл

Шөнийн цагаар ашиглахаар төлөвлөж байгаа ХБЗ, эсхүл өдөр, эсхүл шөнийн цагаар ашиглахаар төлөвлөж байгаа нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ыг ирмэгийн болон төгсгөлийн гэрлээр хангасан байх ёстой.

Е.3.10. ХБЗ-ны босгоны болон хөндлөн шугамын гэрэл

(a) Тухайн босгыг шилжүүлсэн бөгөөд хөндлөн шугамын гэрлээр хангасан хэрэглэлийн бус, эсхүл нарийвчлалгүй ойртолтын ХБЗ-аас бусад ХБЗ-ны ирмэгийн гэрлээр тоноглогдсон ХБЗ-ыг, ХБЗ-ны босгоны гэрлээр хангасан байх ёстой.

(b) Тухайн босгыг шилжүүлсэн бөгөөд ХБЗ-ны босгоны гэрэл шаардлагатай боловч хийгдээгүй бол хэрэглэлийн бус, эсхүл нарийвчлалгүй ойртолтын ХБЗ-ыг хөндлөн шугамын гэрлээр хангасан байх ёстой

Е.3.11. ХБЗ-ны гол шугамын гэрэл

(a) САТ II, эсхүл III-ын нарийвчлалтай ойртолтын ХБЗ-д, ХБЗ-ны гол шугамын гэрлийг хангасан байх ёстой.

(b) Үйл ажиллагааны минимум нь 400 м-ээс бага ХБЗ-ны ил харааны зайтай ХБЗ-ыг хөөрөлтөд ашиглахаар төлөвлөж байгаа бол ХБЗ-ны гол шугамын гэрлээр хангасан байх ёстой.

Е.3.12. ХБЗ-ны газардах бүсийн гэрэл

<p>САТ II, эсхүл III-ын нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ны газардах бүсийг, газардах бүсийн гэрлээр хангасан байх ёстой.</p>		
<p>Е.3.13. Зогсоох замын гэрэл Шөнийн цагаар ашиглахаар төлөвлөж байгаа зогсоох замыг, зогсоох замын гэрлээр хангасан байх ёстой.</p>		
<p>Е.3.14. Явгалах замын гол шугамын гэрэл (a) Хөдөлгөөний эрчимжилт бага, гол шугамын тэмдэг, тэмдэглэгээ нь хангалттай хөтөлдөг ба нэмэлт гэрлээр хангах шаардлагагүй байхаас бусад тохиолдолд, ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 350 м-ээс бага байх үед ашиглахаар төлөвлөж байгаа явгалах замын гарц, явгалах зам, мөстөлтийг арилгах / мөстөлтөөс сэргийлэх байгууламж болон апроныг, ХБЗ-ны гол шугам болон агаарын хөлгийн зогсоолын хооронд үргэлжлүүлэн хөтлөж байх хэлбэрээр явгалах замын гол шугамын гэрлээр хангасан байх ёстой.</p> <p>(b) Хөдөлгөөний эрчимжилт бага, гол шугамын тэмдэг, тэмдэглэгээ нь хангалттай хөтөлдөг ба нэмэлт гэрлээр хангасан байх шаардлагагүйгээс бусад тохиолдолд, ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 350 м-ээс бага байх үед ашиглахаар төлөвлөж байгаа, стандарт явгалах чиглэлийн замын хэсгийг бүрдүүлж байгаа ХБЗ-ыг явгалах замын гол шугамын гэрлээр хангасан байх ёстой.</p>		
<p>Е.3.15. Явгалах замын ирмэгийн гэрэл (a) Үйл ажиллагааны онцлогийг харгалзан гадаргууд суулгасан гэрэл, эсхүл бусад хэлбэрээр хангалттай хөтлөх боломжтой бөгөөд явгалах замын ирмэгийн гэрлээр хангасан байх шаардлагагүйгээс бусад тохиолдолд шөнийн цагаар ашиглахаар төлөвлөж байгаа, явгалах замын гол шугамын гэрлээр хангагдаагүй хүлээх байрлал, мөстөлтийг арилгах / мөстөлтөөс сэргийлэх байгууламж, апроны болон бусад төстэй талбайн ирмэгийг явгалах замын ирмэгийн гэрлээр хангасан байх ёстой.</p> <p>(b) Стандарт явгалах чиглэлийн замын хэсгийг бүрдүүлж байгаа, явгалах замын гол шугамын гэрлээр хангагдаагүй ХБЗ-ыг шөнийн цагаар явгалахаар төлөвлөж байгаа бол явгалах замын ирмэгийн гэрлээр хангасан байх ёстой.</p>		
<p>Е.3.16. ХБЗ-ны эргэлтийн талбайн гэрэл ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 350 м-ээс бага байх үед ашиглахаар зорьж байгаа ХБЗ-ны эргэлтийн талбайг нисэх онгоц 180° эргэлт хийж, ХБЗ-ны гол шугамын дагуу чиглүүлэхэд туслах, үргэлжлүүлэн хөтлөх эргэлтийн талбайн гэрлээр</p>		

<p>хангасан байх ёстой.</p> <p>Е.3.17. “Зогс” тэмдэг</p> <p>(а) ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 550 м-ээс бага үед тухайн ХБЗ-ыг ашиглахаар төлөвлөж байгаа бол дараахаас бусад тохиолдолд ХБЗ-аар үйлчилж байгаа ХБЗ-ны хүлээх байршил бүрийг “Зогс” тэмдгээр хангасан байх ёстой:</p> <p>(1) тохирох туслах хэрэгсэл тэмдэглэгээ болон журам нь ХБЗ руу санаандгүй нэвтрэх хөдөлгөөнөөс сэргийлсэн нөхцөлийг хангаж байгаа, эсхүл</p> <p>(2) ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 550 м-ээс бага байх үед дараах хязгаарлалт тогтоосон үйл ажиллагааны журамтай бол:</p> <p>(i) тухайн цаг хугацаанд маневрын талбайд нэг агаарын хөлөг байх;</p> <p>(ii) тухайн маневрын талбайд байх тээврийн хэрэгслийн тоог минимум байлгах.</p> <p>(b) Явгалах зам, эсхүл ХБЗ-ны уулзварт 1-ээс олон “зогс” тэмдэг байрлуулсан бол өгөгдсөн цаг хугацаанд зөвхөн нэг “зогс” тэмдэг гэрэлтдэг байх ёстой.</p>		
<p>Е.3.18. Завсрын хүлээх байршлын гэрэл</p> <p>“Зогс” тэмдэг байрлуулсан байхаас бусад тохиолдолд, ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 550 м-ээс бага үед ашиглахаар төлөвлөж байгаа завсрын хүлээх байршлыг, завсрын хүлээх байршлын гэрлээр хангасан байх ёстой.</p>		
<p>Е.3.19. ХБЗ-ны хамгаалалтын гэрэл</p> <p>Дараах тохиолдолд ашиглахаар төлөвлөж байгаа ХБЗ-ны явгалах замын уулзвар бүрийг ХБЗ-ны хамгаалалтын гэрлээр хангасан байх ёстой:</p> <p>(1) “зогс” тэмдэг байрлуулаагүй үед, ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 550 м-ээс бага;</p> <p>(2) хөдөлгөөний нягтрал их үед, ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 550 м-1200 м-ийн хооронд.</p>		
<p>Е.3.20. Зогсоолын ил харааны хөтлөх систем</p> <p>Агаарын хөлгийг нарийвчлалтай байршуулах болон дохиурчин ашиглах боломжгүй үед түүнийг орлуулах өөр хэлбэрээр агаарын хөлгийг зогсоолд ороход, ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээгээр чиглүүлэхээр төлөвлөж байгаа бол, зогсоолын ил харааны хөтлөх системээр хангасан байх ёстой.</p> <p>Е.3.21. Замын хүлээх байршлын гэрэл</p> <p>Тухайн ХБЗ-ыг ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 350 м-ээс бага үед ашиглахаар төлөвлөж байгаа бол тухайн ХБЗ-д зориулсан замын хүлээх байршил бүрийг, замын хүлээх байршлын гэрлээр хангасан байх ёстой.</p> <p>Е.4. Тэмдэг болон тэмдэглэгээ</p>		

E.4.1. Ерөнхий зүйл

Хөдөлгөөний талбайн тодорхой байрлал, эсхүл чиглэлд заавал мөрдөх зааварчилгаа, мэдээллийг хүргэх, эсхүл гадаргуугийн хөдөлгөөнийг чиглүүлэх болон удирдлагын системийн шаардлагыг мөрдүүлэх зорилгоор бусад мэдээллээр хангах тэмдэг байрлуулсан байх ёстой.

E.4.2. Гэрэлтүүлэг

Тэмдгийг дараах тохиолдолд ашиглахаар төлөвлөсөн бол гэрэлтүүлсэн байх ёстой:

- (1) ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 800 м-ээс бага; эсхүл
- (2) хэрэглэлийн нислэгийн тоноглолтой ХБЗ-ыг шөнийн цагаар ашиглах бол; эсхүл
- (3) хэрэглэлийн бус ХБЗ-ыг шөнийн цагаар ашиглах бол, кодын дугаар нь 3, эсхүл 4 байх тохиолдолд.

E.4.3. Заавал мөрдөх зааварлах тэмдэг

- (a) Аэродромын удирдлагын цамхаг зөвшөөрснөөс бусад тохиолдолд, агаарын хөлөг явгалах, эсхүл тээврийн хэрэгсэл нэвтрэхийг хориглосон байрлалыг заах зорилгоор заавал мөрдөх зааварлах тэмдгийг хяналттай аэродром дээр байрлуулах ёстой.
- (b) Заавал мөрдөх зааварлах тэмдэгтэд ХБЗ-ны чиглэлийн тэмдэг, CAT I, II, эсхүл III-ын хүлээх байршлын тэмдэг, ХБЗ-ны хүлээх байршлын тэмдэг, замын хүлээх байршлын тэмдэг болон орохыг хориглосон “NO ENTRY” тэмдэг багтсан байх ёстой.
- (c) ХБЗ-ны чиглэлийн тэмдэг бүхий явгалах зам/ХБЗ, эсхүл ХБЗ/ХБЗ-ны уулзварт, хэрэглэлийн бус, нарийвчлалгүй ойртолтын, эсхүл хөөрөлтийн ХБЗ-д зориулсан Хавсралт С.8 (a)-ийн дагуу тогтоосон ХБЗ-ны хүлээх байршлыг нэмж байрлуулсан байх ёстой.
- (d) Нарийвчлалтай ойртолтын ХБЗ-д Хавсралт С-ийн С.8(a)-ийн дагуу нэг ХБЗ-ны хүлээх байршил тогтоосон бол, тухайн ХБЗ-ны хүлээх байршлын тэмдэглэгээнд ХБЗ-ны чиглэлийн тэмдгийг нэмж байрлуулсан байх ёстой.
- (e) Нарийвчлалтай ойртолтын ХБЗ-д Хавсралт С-ийн С.8(a)-ийн дагуу 2 эсхүл 3 ХБЗ-ны хүлээх байршил тогтоосон бол, ХБЗ-тай хамгийн ойрын ХБЗ-ны хүлээх байршилд ХБЗ-ны чиглэлийн тэмдгийг нэмж байрлуулах ба тухайн ХБЗ-аас хамгийн хол эдгээр ХБЗ-ны хүлээх байршилд CAT I, II, эсхүл III-ын хүлээх байршлын тэмдгийг нэмж байрлуулсан байх ёстой.
- (f) Хавсралт С-ийн С.8(b)-гийн дагуу тогтоосон ХБЗ-ны хүлээх байршилд ХБЗ-ны хүлээх байршлын тэмдгийг нэмж байрлуулсан байх ёстой.

(g) Тухайн бүсэд нэвтрэхийг хориглосон үед, орохыг хориглосон “NO ENTRY” тэмдгээр хангасан байх ёстой.

E.4.4. Мэдээлэх тэмдэг

(a) Үйл ажиллагааны шаардлагаар тэмдгээр тодорхойлох, байрлалыг тодруулах, эсхүл маршрутын (чиглэл, эсхүл хүрэх газар) мэдээлэл өгөх хэрэгцээтэй газарт мэдээлэх тэмдэг байрлуулсан байх ёстой.

(b) Мэдээлэх тэмдэг нь чиглэлийн тэмдэг, байрлалын тэмдэг, хүрэх газрын тэмдэг, ХБЗ-аас гарах тэмдэг, ХБЗ-ыг чөлөөлөх тэмдэг болон хөөрөлтийн уулзварын тэмдгийг багтаана.

(c) ХБЗ-аас гарах тэмдгийг үйл ажиллагааны шаардлагаар ХБЗ-аас гарах хэсгийг тодорхойлох хэрэгцээтэй газарт байрлуулна.

(d) Явгалах замын гол шугамын гэрлээр тухайн явгалах замын гарцыг тэмдэглээгүй бол, ILS / MLS системийн эрсдэлтэй / мэдрэмтгий талбайн периметр, эсхүл шилжилтийн дотоод гадаргуугийн доод ирмэгийн аль нь тухайн ХБЗ-ны гол шугамаас хол байгааг ХБЗ-ыг чөлөөлж байгаа нисгэгчид харуулах зорилгоор ХБЗ-ыг чөлөөлөх тэмдгийг байрлуулсан байх ёстой.

(e) Байрлал чиглэлийн хосолсон тэмдгийг явгалах замын уулзварын өмнө маршрутын мэдээллийг тодорхойлох зориулалтаар байрлуулсан байна.

(f) Чиглэл заах тэмдгийг үйл ажиллагааны шаардлагаар явгалах замын уулзварт, тэдгээрийн дугаар ба чиглэлийг тодорхойлох хэрэгцээтэй газарт байрлуулсан байх ёстой.

(g) ХБЗ, эсхүл ХБЗ-ны уулзвараас бусад тохиолдолд байрлалын тэмдгийг ХБЗ-ны чиглэлийн тэмдэгтэй хамт байрлуулсан байх ёстой.

(h) Нисэхийн судалгаагаар шаардлагагүй гэж үзсэнээс бусад тохиолдолд байрлалын тэмдгийг чиглэлийн тэмдэгтэй хамт байрлуулсан байх ёстой

E.4.5. Аэродромын VOR-ын шалгах цэгийн тэмдэг

Аэродромын VOR шалгах цэгийг тогтоосон бол, түүнийг VOR шалгах цэгийн тэмдгээр тэмдэглэсэн байх ёстой.

E.4.6. Замын хүлээх байршлын тэмдэг

Замын хүлээх байршлын тэмдгийг ХБЗ руу нэвтрэх бүх замын оролт дээр байрлуулсан байх ёстой.

E.4.7. Тэмдэгт (Marker)

Тэмдэгт хэврэг байх ёстой ХБЗ, эсхүл явгалах замын ойролцоо байрлуулсан байгаа тэмдэгт нь жет-агаарын хөлгийн хөдөлгүүрийн доод өөхий болон сэнснээс хангалттай тусгаарлах зай хадгалахаар намхан байх ёстой.

Хавсралт F - Саадыг тэмдэглэх ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ

F.1. Тэмдэглэсэн болон эсхүл гэрэлтүүлсэн байх байгууламж

- (a) Хэрэв тухайн ХБЗ-ыг шөнийн цагаар гэрэлтүүлэгтэй ашигладаг бол, дараахаас бусад тохиолдолд, дотоод ирмэгийн 3000 м-ийн доторх ойртолтын гадаргуугаас дээш, эсхүл шилжилтийн гадаргуугаас дээш өргөгдсөн суурин саадыг тэмдэглэсэн байх ёстой:
- (1) саад нь өөр суурин саадаар халхлагдсан бол тухайн саадыг тэмдэглэхгүй, эсхүл гэрэлтүүлэхгүй байж болно, эсхүл
 - (2) саад нь өдрийн цагаар дунд тодорцтой А маягийн саадын гэрлээр гэрэлтдэг ба түүний өндөр нь орчны газрын түвшнээс 150 м-ээс хэтрэхгүй тохиолдолд тэмдэглэгээ хийхгүй байж болно, эсхүл
 - (3) саад нь өдрийн цагаар өндөр тодроцтой саадын гэрлээр гэрэлтдэг тохиолдолд тэмдэглэгээ хийхгүй байж болно, эсхүл
 - (4) саад нь гэрэлт цамхаг бол нисэхийн судалгаа хийж, тухайн гэрэлт цамхгийн гэрэл хангалттай гэж үзсэн нөхцөлд гэрэлтүүлэг хийхгүй байж болно.
- (b) Саадыг хамгаалах гадаргуугаас дээш өргөгдсөн суурин байгууламж нь тэмдэглэгдсэн байх ба хэрэв ХБЗ-ыг шөнийн цагаар ашиглах бол гэрэлтүүлсэн байх ёстой.
- (c) Зөвхөн хөдөлгөөнт бүс, апрон дээр ашиглагдах агаарын хөлөг болон агаарын хөлгийн үйлчилгээний төхөөрөмж, тээврийн хэрэгслээс бусад тээврийн хэрэгслэл болон хөдөлгөөнт байгууламжийг саадад тооцсон нөхцөлд тэмдэглэгээ хийгдсэн байх ёстой ба хэрэв тээврийн хэрэгсэл болон аэродромыг шөнийн цагаар, эсхүл алсын барааны харагдац бага нөхцөлд ашигладаг бол гэрэлтүүлсэн байх ёстой.
- (d) Хөдөлгөөнт бүс дэх нисэхийн өргөгдсөн газрын гэрлийг өдрийн цагт ил харагдахаар тэмдэглэсэн байх ёстой. хөдөлгөөний бүс дэх өргөгдсөн газрын гэрэл, эсхүл тэмдэг дээр саадын гэрэл суурилуулахыг зөвшөөрөхгүй.
- (e) Явгалах замын гол шугам, апроны явгалах зам, эсхүл агаарын хөлгийн зогсоолын явгалах шугамаас Хүснэгт F-1-

-Amend.10-аар шинээр орсон

д заасан зайд байрлах бүх саадыг тэмдэглэсэн байх ёстой ба хэрэв шөнийн цагаар явгалах зам, апроны явгалах зам, эсхүл агаарын хөлгийн зогсоолын явгалах шугамыг ашигладаг бол гэрэлтүүлсэн байх ёстой.

Хүснэгт F-1. Саадын тэмдэглэгээ ба гэрэлтүүлгийн шаардлага

Аэродромын хяналтын кодын үсгэн код	Агаарын хөлгийн зогсоолын явгалах шугам, гол шугамаас бусад явгалах замаас байгууламж хүртэлх зай (метрээр)	Агаарын хөлгийн зогсоолын явгалах гол шугамаас байгууламж хүртэлх зай (метрээр)
A	16.25	12
B	21.5	16.5
C	26	24.5
D	40.5	36
E	47.5	42.5
F	57.5	50.5

F.2. Байгууламжийн тэмдэглэгээ

- (a) Тухайн байгууламж нь өөр бусад хэлбэрээр тэмдэглэх шаардлагагүйгээр, өөрийн хэлбэр дүрс, хэмжээ, эсхүл өнгөөрөө хангалттай ялгарч харагдаж байгаагаас бусад тохиолдолд, тэмдэглэгээ хийгдэх бүх суурин байгууламжийг будсан байх ёстой, гэхдээ хэрэв боломжгүй бол тэдгээрийн дээр, эсхүл дээгүүр тэмдэгт, эсхүл туг дарцаг байрлуулсан байх ёстой.
- (b) Тэмдэглэгээ хийгдэх бүх хөдөлгөөнт байгууламжийг будсан, эсхүл туг дарцгаар тэмдэглэсэн байх ёстой.

F.3. Тэмдэгт хэрэглэх

Байгууламжийн дээр, эсхүл түүний дэргэд байрласан тэмдэгт нь тухайн байгууламжийн ерөнхий хэв шинжийг хадгалах байдлаар, ил харагдахуйц байршилд байрласан байх ёстой ба цаг агаар тогтуун үед агаарын хөлөг тухайн байгууламж руу ойртох магадлалтай бүх чиглэлд, агаараас 1000 м-ээс, газраас 300 м-ээс доошгүй зайнаас танигдахуйц байх ёстой. Тэмдэгтийн хэлбэр нь бусад мэдээллийг хүргэх зорилгоор ашиглаж байгаа тэмдэгттэй андуурагдахгүй болохыг бататгахад шаардлагатай түвшинд өвөрмөц байх ёстой бөгөөд тухайн тэмдэглэгээ нь тэмдэглэсэн байгууламжийн учруулж болох аюулыг ихэсгэхгүй байх ёстой.

F.4. Туг дарцаг хэрэглэх

(a) Байгууламжийг тэмдэглэх туг дарцгийг тухайн байгууламжийн эргэн тойронд, орой дээр нь, эсхүл хамгийн өндөр ирмэгийг тойруулан байрлуулах ёстой. Хэрэв туг дарцагаар том байгууламж, эсхүл ойрхон зайтай бүлэг байгууламжийг тэмдэглэх бол тэдгээрийг 15 м-ээс доошгүй зайд байрлуулах ёстой. Туг дарцаг нь тухайн байгууламжаас учирч болох аюулыг ихэсгэхгүй байх ёстой.

(b) Суурин байгууламжийг тэмдэглэх туг дарцаг нь 0.6 м²-аас багагүй, хөдөлгөөнт байгууламжийг тэмдэглэх туг дарцаг нь 0.9 м²-аас багагүй талбайтай байх ёстой.

(c) Хөдөлгөөнт байгууламжийг тэмдэглэх туг дарцаг нь дөрвөлжин нүдтэй байх ба талууд нь 0.3 м-ээс багагүй хэмжээтэй байна. Нүдний өнгө нь хоорондоо ялгарч харагдах ба цаад харагдах суурь өнгөнөөс ялгарч байх ёстой. Эдгээр өнгө нь суурь өнгөтэй уусаж байхаас бусад тохиолдолд улбар шар болон цагаан, эсхүл улаан болон цагаан өнгийг ашиглах ёстой.

F.5. Байгууламжийн гэрэлтүүлэг

(a) Хавсралт F.1-д заасан гэрэлтүүлэх шаардлага бүхий байгууламжийг бага, дунд, эсхүл өндөр тодорцтой саадын гэрлээр, эсхүл тэдгээр гэрлийн хослолоор гэрэлтүүлсэн байх ёстой.

(b) Бага тодорцтой C маягийн саадын гэрлийг агаарын хөлгөөс бусад тээврийн хэрэгсэл дээр болон бусад хөдөлгөөнт байгууламж дээр байрлуулсан байх ёстой.

(c) Бага тодорцтой D маягийн саадын гэрлийг "Follow me" тээврийн хэрэгсэл дээр байрлуулсан байх ёстой.

Хавсралт G - Хязгаарлагдмал хэрэглээний бүсийг тэмдэглэх ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ

G.1. Хаалттай ХБЗ болон явгалах зам

Агаарын хөлөг ашиглахгүй бүрмөсөн хаагдсан ХБЗ, эсхүл явгалах зам, эсхүл тэдгээрийн хэсэг дээр “Хаалттай” тэмдэглэгээг байрлуулсан байх ёстой.

G.2. Даацын бус гадаргуу

Явгалах зам, хүлээх байрлал, апроны хөвөө болон бусад даацын бус гадаргуу нь даацын гадаргуугаас ялгарч харагдахгүй байгаа ба хэрэв түүнийг агаарын хөлөг ашигласан тохиолдолд агаарын хөлөгт эвдрэл үүсгэж болох дээрх гадаргуу болон даацын гадаргуугийн хил хязгаарын хооронд хажуугийн зураасан тэмдэглэгээ хийсэн байх ёстой.

G.3 Ашиглалтгүй бүс

Агаарын хөлөг дээгүүр нь аюулгүй өнгөрөн гарах боломжтой ч, агаарын хөлгийн хөдөлгөөн үйлдэхэд тохиромжгүй хүлээх талбай, эсхүл явгалах зам, апроны аливаа хэсэгт ажиллагаагүй болохыг анхааруулсан тэмдэгт байрлуулсан байх ёстой. Шөнийн цагаар ашиглах хөдөлгөөнт бүсэд ажиллагаагүй болохыг харуулсан гэрлэн тэмдэгт ашиглах ёстой.

Хавсралт Н - Цахилгаан систем

Н.1. Аэронавигацийн байгууламжийн цахилгаан хангамжийн систем

- (a) Аэронавигацийн байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тухайн аэродром дээр үндсэн цахилгаан хангамжийн хангалттай эх үүсвэр байх ёстой.
- (b) Энэ дүрмийн 139.5(аа)(1)-д заасан аэродромын хувьд, аэродромын ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ радио навигацийн туслах төхөөрөмжийн цахилгаан хангамжийн системийн төлөвлөлт болон хангалт нь тухайн төхөөрөмж татгалзсан үед нисгэгчийг ил харааны болон ил харааны бус үйл ажиллагаанд буруу чиглүүлэх, эсхүл төөрөгдүүлэх мэдээлэл өгөхгүй байхаар хийгдсэн байх ёстой.

Н.2. Ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ

- (a) Нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ны хувьд Хүснэгт Н-1-д заасан нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ны тохиромжтой категорийн шаардлагыг хангасан цахилгаан хангамжийн хоёрдогч эх үүсвэртэй байх ёстой. Хоёрдогч эх үүсвэр шаардагдах байгууламжид цахилгаан хангамжийн холболт нь үндсэн эх үүсвэр татгалзахад хоёрдогч эх үүсвэрт автоматаар холбогдож байхаар зохион байгуулагдсан байх ёстой.
- (b) ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 800 м-ээс бага, хөөрөлт үйлдэх ХБЗ-ны хувьд Хүснэгт Н-1-д заасан холбогдох шаардлагыг хангасан цахилгаан хангамжийн хоёрдогч эх үүсвэртэй байх ёстой.

Н.3. Системийн төлөвлөлт

- (a) ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 550 м-ээс бага үед ашиглах ХБЗ-ны хувьд Хүснэгт Н-1-д үзүүлсэн цахилгаанаар хангах систем, гэрэлтүүлэг болон гэрэлтүүлгийн системийн удирдлагыг, тухайн төхөөрөмж татгалзсан үед нисгэгчийг ил харааны үйл ажиллагаанд буруу чиглүүлэх, эсхүл төөрөгдүүлэх

-Amend.10-аар шинээр орсон

мэдээлэл өгөхгүй байхаар төлөвлөсөн байх ёстой.

(b) Нөөц нэмэлт шугам ашиглан аэродромын цахилгаан хангамжийн хоёрдогч эх үүсвэрийг хангасан бол бэлэн байдлын болон бие даасан байдлын шаардлагатай түвшнийг хангаж байгааг бататгахын тулд, тухайн хангалт нь бодит биетээр болон цахилгааны холболтоор бие даан хамааралгүй байх ёстой.

(c) Стандарт явгалах чиглэлийн замын хэсгийг бүрдүүлж байгаа ХБЗ-ыг ХБЗ-ны гэрэлтүүлэг болон явгалах замын гэрэлтүүлгээр хангасан бол, тухайн гэрэлтүүлгийн систем нь хоёр хэлбэрийн гэрэлтүүлэг зэрэг ажиллах боломжийг хязгаарлахын тулд нэгтгэж холбосон байх ёстой.

Н.4. Мониторинг

Гэрэлтүүлгийн системийг агаарын хөлгийг удирдах зорилгоор ашиглаж байгаа бол эдгээр системийн удирдлагын үйл ажиллагаанд нөлөөлж болох гэмтлийн шинж тэмдгийг мэдээлэх автомат хяналттай байх ёстой. Энэ мэдээллийг НХҮ-ний нэгжид автоматаар дамжуулдаг байх ёстой.

Хүснэгт Н-1. Цахилгааны хоёрдогч эх үүсвэрт тавих шаардлага

ХБЗ	Цахилгаан тэжээл шаарддаг гэрэлтүүлгийн төхөөрөмж	Сэлгэн залгалт хийх дээд хугацаа	Тайлбар
САТ I-ийн нарийвчлалтай ойртолт	Ойртолтын гэрэлтүүлгийн систем	15 секунд	с
	ХБЗ-ны ирмэг	15 секунд	а,с
	Ил харааны ойртолтын өнцөг	15 секунд	с
	заагч	15 секунд	а
	ХБЗ-ны босго	15 секунд	а

	ХБЗ-ны төгсгөл Үндсэн явгалах зам Саад		
САТ II/III- ын нарийвч лалтай ойртолт	Ойртолтын гэрэлтүүлгийн системийн 300м дотоод хэсэг Ойртолтын гэрэлтүүлгийн системийн бусад хэсэг Саад ХБЗ-ны ирмэг ХБЗ-ны босго ХБЗ-ны төгсгөл ХБЗ-ны гол шугам ХБЗ-ны газардах бүс Бүх “Зогс” гэрэл Үндсэн явгалах зам	1 секунд 15 секунд 15 секунд 15 секунд 1 секунд 1 секунд 1 секунд 1 секунд 1 секунд 15 секунд	a
ХБЗ-ны ил харааны зайн нөхцөл нь 550м- ээс бага үеийн ХБЗ	ХБЗ-ны хажуу ХБЗ-ны төгсгөл ХБЗ-ны гол шугам Бүх“Зогс” гэрэл Үндсэн явгалах зам Саад	15 секунд 1 секунд 1 секунд 1 секунд 15 секунд 15 секунд	b a a

Тайлбар

- a. Нислэгийн аюулгүй байдалд зайлшгүй чухал учраас хоёр дахь эх үүсвэртэй холбогдсон.
- b. ХБЗ-ны гол шугамын гэрэлгүй үед нэг секунд
- c. Ойртолтын нөхцөл нь аюултай ба уулархаг

Дүрмийн боловсруулалтын хэлтэс